



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1-2
Хуралдааны товч тэмдэглэл:	3-57
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	58-159
1.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах	60-61
2.“Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	61
3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал /үргэлжилнэ/	62-63
4.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	63-71
5.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	71
6.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	72-76
7.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	76-77
8.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	77-81
9.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	81
10.Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	82
11.Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	83
12.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	84-85
13.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	85-87
14.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	87-88
15.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	88-89
16.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	89-90

17.Улсын Их Хурлын асуулгын цаг	90-117
18.Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт	117-130
19.“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	130-133
20.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	134
21.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүн 2025.11.07-ны өдөр өргөн мэдүүлсэн/	135-136
22.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох	136-137
Хуралдаан санал хураалтаар үргэлжлэв.	138-159

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 26-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 75 гишүүн хүрэлцэн ирж, 59.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.¹

Томилолттой: Ч.Анар, Д.Батлут, Ш.Бямбасүрэн, Г.Лувсанжамц, Ч.Номин;
Чөлөөтэй: О.Алтангэрэл, Х.Баттулга, Ж.Баясгалан, Х.Булгантуяа,
Д.Бум-Очир, П.Ганзориг, П.Мөнхтулга, Л.Оюун-Эрдэнэ, А.Ундраа, Г.Хосбаяр,
Д.Энхтуяа, М.Энхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Батцэцэг, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, С.Замира;

Тасалсан: Д.Амарбаясгалан, Ж.Батсуурь, Х.Болормаа, Ж.Энхбаяр;

Хоцорсон: С.Амарсайхан-18 минут, Т.Аубакир-21 минут, М.Бадамсүрэн-11 минут, Ж.Батжаргал-09 минут, Д.Ганбат-11 минут, Б.Дэлгэрсайхан-3 цаг 06 минут, Б.Жавхлан-10 минут, Б.Жаргалан-15 минут, Д.Жаргалсайхан-17 минут, Ч.Лодойсамбуу-09 минут, П.Наранбаяр-2 цаг 07 минут, Д.Пүрэвдаваа -2 цаг 15 минут, О.Саранчулуун-27 минут, Г.Тэмүүлэн-15 минут, Б.Хэрлэн-04 минут, Д.Цогтбаатар-31 минут, Б.Чойжилсүрэн-01 минут, Р.Эрдэнэбүрэн-23 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 06 дугаар сарын 26-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаад Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Засгийн газраас 2026.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн “Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав./10:17/

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Бат.Баярмаа нар байлцав.

С.Бямбацогт: 1.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 12

Бүгд: 85

85.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

¹ Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 8 гишүүн ирцэд нэмэгдсэн болон хүндэтгэн үзэх шалтгаанаар хоцроогүй болно.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74

Татгалзсан: 11

Бүгд: 85

87.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 14

Бүгд: 85

83.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

4.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 14

Бүгд: 86

83.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 15

Бүгд: 86

82.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74

Татгалзсан: 12

Бүгд: 86

86.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 14

Бүгд: 87

83.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

8.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 14

Бүгд: 87

83.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 15

Бүгд: 87

82.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, **яаралтай хэлэлцэх эсэх**, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан “Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

С.Бямбацогт: “Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 20

Бүгд: 89

77.5 хувийн саналаар дэмжигдлээ.

“Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал /үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Ж.Сүхбаатар, Г.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Жамъянхорлоогийн Сүхбаатарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 14
Бүгд: 90
84.4 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 2.Ганбатын Эрдэнэбатыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77
Татгалзсан: 14
Бүгд: 91
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ж.Галбадрах, Ц.Даваасүрэн, Ц.Туваан, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтад дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 91.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:35/

Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Д.Батбаяр, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Наранбаатар, Ц.Туваан, А.Ундраа, Б.Уянга, Б.Мөнхсоёл, Д.Үүрийнтуяа, Р.Эрдэнэбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.40 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.40.“гэрээ байгуулах боломжтой талбай” гэж энэ хуулийн 4.1.39-д заасан гэрээг байгуулах боломжтой тусгай зөвшөөрөл олгогдоогүй, ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцаагүй, сонгон шалгаруулалтын талбайд хамрагдаагүй, эсхүл сонгон шалгаруулалтыг хоёр удаа зарласан боловч сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирээгүй, геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэхээр тогтоосон талбайг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	29
Бүгд:	92

68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.39 дэх заалтын “геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний геологийн алба” гэж, 3 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн, 15^{1.7.5} дахь заалтын “геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэснийг “Үндэсний геологийн албанд” гэж, 15^{1.3} дахь хэсэг, 15^{1.4} дэх хэсэг, 15^{1.8} дахь хэсэг, 15^{1.9} дэх хэсгийн “Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний геологийн алба” гэж, 15^{1.7} дахь хэсгийн “Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай” гэснийг “Үндэсний геологийн албатай” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	32
Бүгд:	92

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15¹.2.4 дэх заалтын “чадавхыг тусгасан” гэсний дараа “геологийн суурь судалгаа, эрлийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 28
Бүгд: 92
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15¹.7.6 дахь заалт, 15¹.7.7 дахь заалт, 20.5.7 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 28
Бүгд: 92
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15¹.9 дэх хэсгийн “15¹.1-д” гэснийг “4.1.40-д” гэж, “мэдээлнэ” гэснийг “мэдээлж байна” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 28
Бүгд: 92
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19¹.2.1 дэх заалтын “гэрээний хэрэгжилтийн тайлан” гэснийг “гэрээ дүгнэсэн акт” гэж, 19¹.2.3 дахь заалтын “зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл авах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 27
Бүгд: 92
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19¹.8 дахь хэсгийн “зөвшөөрөл олгосон” гэсний дараах “даруйд энэ” гэснийг хасаж, “нийтэд ил тод” гэсний дараах “мэдээлнэ” гэснийг “, нээлттэй мэдээлж байна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 27.1.15 дахь заалтын “ирүүлэх” гэснийг “хүргүүлэх” гэж өөрчилж, 27.1.16 дахь заалтын “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 28¹, 29¹ дүгээр зүйлийн гарчгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 28^{3.4} дэх хэсгийн “28^{3.4}” гэснийг “28^{3.3}” гэж, 29^{1.1} дэх хэсгийн “хаягдал чулуулгийн” гэснийг “хаягдлын” гэж тус тус өөрчилж, 28^{1.1} дэх хэсгийн “зөвшөөрөлтэй” гэсний дараа “хуулийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 42^{1.1} дэх хэсгийн “олон нийтэд” гэснийг “олон нийт, орон нутгийн иргэдэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.20 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.20.Эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах эрдэс, элементээс бусад эрдэс, элементэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулахгүй бөгөөд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулах эрдэс, элементийн төрөл, хэмжээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дахь заалтын 64^{1.1} дэх хэсгийн “саад учруулахыг” гэсний өмнө “хууль бусаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 29
Бүгд: 93
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 32.2 дахь хэсгийн “19^{1.5}-д заасан хайгуулын тусгай зөвшөөрлийн” гэснийг “19^{1.4}-т заасан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан талбайн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 34
Бүгд: 93
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 47.5 дахь хэсгийн хүснэгтийн 2 дахь баганын “Ашигт малтмалын нэр төрөл” гэснийг “Бүтээгдэхүүний нэр төрөл” гэж, 5 дахь баганын “ам.доллар” гэснийг “ам.доллороор” гэж, 6 дахь баганын “Боловсруулалтаас хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь” гэснийг “Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “байгаль орчны менежментийн” гэснийг “байгаль орчныг хамгаалах” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.32 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.32.“чухал ашигт малтмал” гэж олон улсын зах зээлд өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд, эсхүл дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангахад шаардлагатай ашигт малтмалыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.38 дахь заалтыг хасах гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.43 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн “Энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг “Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч” гэж, мөн хэсгийн “гаргаж болно” гэснийг “гаргана” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 20.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.9.Сонгон шалгаруулалтаар олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн босго үнэ нь 25-3000 гектар бол 20000 нэгж, 3000 гектараас дээш бол 20000 нэгж дээр нэг гектар тутамд 7 нэгж нэмж тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 32
Бүгд: 94
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 29¹ дүгээр зүйл, 29² дугаар зүйлийг хасах гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.Хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 35
Бүгд: 94
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 32.1 дэх хэсгийн “35 нэгж” гэсний дараа “, 6-9 дэх жилд 50 нэгж” гэж нэмэх, 5 дахь заалтын 33.1.5 дахь заалтын “6 дахь жилд” гэснийг “7-9 дэх жилд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 38
Бүгд: 94
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллаж болно.” гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлээс “4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний,” гэснийг “засагт нөлөөлөхүйц,” гэж” гэснийг хасаж, төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт:

4.1.12.“стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	37
Бүгд:	94

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “11.1.29” гэснийг “11.1.28” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	35
Бүгд:	94

62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “1 удаа” гэснийг “2 удаа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	34
Бүгд:	94

63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлээс “15 дугаар зүйл,” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн “16 дугаар” гэсний өмнө “15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “мэдэгдэж бүртгүүлнэ” гэснийг “мэдэгдэнэ” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 35
Бүгд: 94
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг хууль зүйн техникт нийцүүлж, өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, 1.1/Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19^{1.4} дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “нь” гэж нэмэх.

1.2/Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.3.2} дахь заалтын “талаар” гэснийг “тухай” гэж, 15^{1.7} дахь хэсгийн “ажил” гэснийг “ажлыг” гэж, 10 дахь заалтын 29^{2.1.2} дахь заалтын “талаар санал дүгнэлт” гэснийг “тухай санал, дүгнэлт” гэж, 12 дахь заалтын 35.13 дахь хэсгийн “байгууллагуудын” гэснийг “байгууллагын” гэж, 13 дахь заалтын 42^{1.2.2} дахь заалтын “байгууллагуудтай” гэснийг “байгууллагатай” гэж, 2, 4 дүгээр зүйлийн “16 дугаар зүйл” гэснийг “16 дугаар зүйлийн гарчгийн” гэж тус тус өөрчлөх.

1.3/Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын 48.15 дахь хэсгээс “тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 36
Бүгд: 94
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.35, 4.1.36 дахь заалтын, 10 дахь заалтын 28^{1.3} дахь хэсгийн, 28³ дугаар зүйлийн, 16 дахь заалтын 64^{1.2} дахь заалтын, төслийн 2 дугаар зүйлийн 35.10 дахь хэсгийн, төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7.1 дэх хэсгийн, 2 дахь заалтын 11.1.19 дэх заалтын, 6 дахь заалтын 35.4 дэх хэсгийн, төслийн 4 дүгээр зүйлийн 53.1 дэх хэсгийн “баяжуулалтын” гэснийг “боловсруулалтын” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34

Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын “ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ” буюу “АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖУУЛАЛТ” бүлгийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 32.5 дахь хэсгийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 31
Бүгд: 94
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.21 дэх хэсгийн “бүртгэж, хяналт тавина” гэснийг “бүртгэнэ” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 33
Бүгд: 94
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, уурхай, баяжуулах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтэц хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар орон нутагтай хамтран ажиллах гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нарын нэгдсэн шийдвэрт үндэслэсэн саналаар байгуулж ажиллана.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 31
Бүгд: 94
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, уурхай, баяжуулах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулж, уг гэрээг аймаг, нийслэлийн Засаг дарга батална.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 45

Бүгд: 94

52.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 47.5 дахь хэсгийн хүснэгтийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 36

Бүгд: 94

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 39

Бүгд: 94

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйлийг хасах:

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө олгосон хайгуулын тусгай зөвшөөрөлд Ашигт малтмалын тухай хуулийн 21.1.5 дахь заалт, 32.1 дэх хэсэг, 33 дугаар зүйл хамаарахгүй болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 37

Бүгд: 94
60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлж тооцох хувийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 46
Бүгд: 94
51.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Энэ хуулийн 10.2-т заасан этгээд нь биржээр дамжуулан баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээж экспортлох зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт олон улсын худалдааны нөхцөлөөр арилжиж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 38
Бүгд: 94
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтын “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэснийг “байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж” гэснийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн гаргасан саналуудыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Тав.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 59.1.2 дахь заалтын “15” гэснийг “20” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “30 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж” гэснийг “40 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Энэ хуулийн” гэснийг “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын

хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Н.Монголмаа нар байлцав.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 39
Бүгд: 95
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

С.Бямбацогт: 2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 51
Бүгд: 95
46.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 40
Бүгд: 95
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 37
Бүгд: 95
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын ахлах мэргэжилтэн С.Солонго, судлаач З.Түвшинжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярын тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх санал хураалтуудыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./11:26/

Долоо.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын ахлах мэргэжилтэн С.Солонго, судлаач З.Түвшинжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./11:29/

Найм.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн,

Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын ахлах мэргэжилтэн С.Солонго, судлаач З.Түвшинжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын Х.Баасанжаргал, П.Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 11 цаг 36 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./11:42/

Ес.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын ахлах мэргэжилтэн С.Солонго, судлаач З.Түвшинжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./11:45/

Арав.Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын ахлах мэргэжилтэн С.Солонго, судлаач З.Түвшинжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./11:48/

Арван нэг.Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын ахлах мэргэжилтэн С.Солонго, судлаач З.Түвшинжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./11:52/

Арван хоёр.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын ахлах мэргэжилтэн С.Солонго, судлаач З.Түвшинжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./11:55/

Арван гурав.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Х.Эрдэм-Ундрах, Монгол Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга О.Мөнхбаатар, мөн газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Г.Эрдэнэ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх санал хураалтуудыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./12:03/

Арван дөрөв.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Х.Эрдэм-Ундрах, Монгол Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга О.Мөнхбаатар, мөн газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Г.Эрдэнэ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./12:06/

Арван тав.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Х.Эрдэм-Ундрах, Монгол Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга О.Мөнхбаатар, мөн газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Г.Эрдэнэ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./12:10/

Арван зургаа.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./12:14/

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 05 минут үргэлжилж, 12 цаг 15 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 02 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 14 цаг 02 минутаас хуралдааныг даргалав.

Арван долоо.Улсын Их Хурлын асуулгын цаг

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, мөн газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, шинжээч Ч.Батцэцэг нар байлцав.

Тусгайлан бэлтгэсэн индрээс Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал нар цуварсан асуулт, хариултаар мэтгэлцэв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 14 цаг 47 минутаас хуралдааныг даргалав.

Мөн тусгайлан бэлтгэсэн индрээс Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө бичгээр ирүүлсэн гишүүд болох Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Ц.Баатархүү, Ө.Шижир, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн, П.Батчимэг, Б.Жаргалан, Улсын Их Хурал дахь олонхын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ж.Галбадрах, Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, Г.Уянгахишиг нарын тавьсан асуултад тусгайлан бэлтгэсэн индрээс Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын асуулгын цаг 15 цаг 43 минутад дуусав.

Арван найм.Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Ц.Хосжаргал, мөн газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, Гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор С.Оюун-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Дэд бүтцийн хэлтсийн дарга Э.Батболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч

Ч.Мөнхбаатар, Сангийн яамны Төлбөр тооцооны хэлтсийн мэргэжилтэн Т.Мөнхбат, судлаач Д.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Л.Соронзонболд, А.Ариунзаяа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, судлаач Д.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ц.Баатархүү нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэв.

Уг асуудлыг 16 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Арван Ес. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Энхтүвшин нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу түр хойшлуулав./16:45/

Хорь. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Э.Дарханцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хорин нэг. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүн 2025.11.07-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг танилцуулав.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Н.Батсүмбэрэл ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ажлын 2 өдрийн завсарлага өгөв./16:54/

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 17 цаг 28 минутаас хуралдааныг даргалав.

Хорин хоёр. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./17:29/

Дагалдан гарсан:

2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./17:29/

3.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:29/

Холбогдуулан боловсруулсан:

4.“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:30/

5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./17:30/

6.“Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:30/

7.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:31/

8.“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:31/

Уг асуудлыг 17 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүнээс 2026.06.05-ны өдөр Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдээ татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./17:33/

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал:

Нэг.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл

С.Бямбацогт: 1.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.7 дахь заалтын “дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө” гэснийг “хамтран өмчлөх дундын хөрөнгөө” гэж, 9.1 дэх хэсэг, 9.2.8 дахь заалтын “эд” гэснийг тус тус хасаж, 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.2 дахь хэсэг болгох:

“9.2.Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд дараах үүрэг хүлээнэ:

9.2.1.бие биеэ тэжээн тэтгэх, асран халамжлах;

9.2.3.бие биеийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, зөрчихгүй байх;

9.2.3.гэр бүлийн угийн бичиг хөтлөх;

9.2.4.гэр бүлийн үнэт зүйл, үндэсний соёл, уламжлал, зан заншлыг эрхэмлэх;

9.2.5.хамтын үүрэг, хариуцлагаа ухамсарлан бие биедээ үнэнч байх, гэр бүлийн хамтын амьдралаа тогтвортой байлгах, гэр бүлийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 43

Бүгд: 98

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Гэрлэлт дуусгавар болох

10.1.Гэрлэлтийг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно:

10.1.1.гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан;

10.1.2.гэрлэгчдийн хэн нэгнийг нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсон гэж тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

10.1.3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн.

10.2.Гэрлэлт дараах тохиолдолд дуусгавар болно:

10.2.1.захиргааны, эсхүл шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан;

10.2.2.гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон.

10.3.Энэ зүйлийн 10.1.3-т заасан хүйсийн өөрчлөлт тухайн хүний хөрөнгийн эрх болон эцэг, эхийн эрхийг хязгаарлах, үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 44

Бүгд: 98

55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах

13.1.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад тохиолдолд гэрлэлт цуцлуулах асуудлыг гэрлэгчдийн хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.2.Энэ хуулийн 10.1.3-т заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө иргэний улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, гэрлэлт дуусгавар болсон бол гэрлэлт цуцлахаас бусад хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг, хамтран өмчлөх дундын хөрөнгө хуваах асуудлаар гэрлэгчид нэхэмжлэл гаргах үүрэгтэй бөгөөд эдгээр асуудлыг уг нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.3.Гэрлэгчид гэрлэлтийн гэрээнд хөрөнгийн эрх, үүргийг тусгасан эсэхээс үл хамаарч, гэрлэлт цуцлуулах үед хөрөнгийн эрх, үүргийн талаар харилцан тохиролцож болно.

13.4.Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын хөрөнгө хуваах асуудлыг бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.

13.5.Шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

13.6.Шүүх гэрлэлт цуцлахдаа нэхэмжлэлийн шаардлагаас үл хамааран дараах асуудлыг шийдвэрлэнэ:

13.6.1.хүүхдийн асрамж;

13.6.2.хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь /нөхцөл, хэлбэр, байршил, хугацаа/;

13.6.3.тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардал.

13.7.Шүүх энэ хуулийн 13.6.1, 13.6.2-т заасан асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хангаж, дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

13.7.1.хүүхдийн нас, бие махбод, оюун санаа, нийгэмшихүй, танин мэдэхүй, сэтгэхүй, хөгжил, сэтгэл зүйн онцлогт нийцсэн хэрэгцээ, шаардлагыг;

13.7.2.хүүхэд долоо, түүнээс дээш настай бол түүний саналыг;

13.7.3.хүүхдийн эцэг, эх, ах, эгч, дүү, эмээ, өвөө болон түүний амьдралд чухал нөлөө бүхий бусад хүнтэй тогтоосон харилцаа, ээнэгшсэн дассан байдал;

13.7.4.эцэг, эхийн хүүхдийг асран хамгаалж, хүмүүжүүлэхэд оролцож байсан оролцооны байдал, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, чадавхыг;

13.7.5.хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх төлөвлөгөө, хүүхэдтэй харилцах чадвар, эцэг, эхийн амьдралын хэв маяг, эрүүл мэнд, эрхэлсэн ажил, ажлын цагийг;

13.7.6.гэрлэгчид хүүхдийн асрамжийн асуудлаар тохиролцсон эсэхийг;

13.7.7.эцэг, эхийн зан байдал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эсэх, хүүхдэд үзүүлэх нөлөөг.

13.8.Гэрлэгчид хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцсэн байдлаар өөрөөр тохиролцоогүй бол шүүх энэ хуулийн 13.6.1-д заасан хүүхдийн асрамжийг хэрэгжүүлэхээр тогтоогдсон эцэг, эсхүл эхэд хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрхийг олгоно.

13.9.Шүүх энэ хуулийн 13.6.3-т заасан тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардлыг энэ хуулийн долдугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

13.10.Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авч, хамтран ажиллаж болно.

13.11.Эхнэр нь жирэмсэн, эсхүл хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзана.

13.12.Гэрлэгчдийн хэн нэгний хүчирхийллээс болж, гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд аюул, хор уршиг учирч болзошгүйн улмаас гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг гаргахад энэ хуулийн 13.11-д заасан нь саад болохгүй.

13.13.Энэ хуулийн 13.11-д заасан нөхцөл байдал арилсан бол гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.”

Тайлбар: -Энэ хуулийн 13.6.1-д заасан “хүүхдийн асрамж” гэж хүүхдийг хэний асрамжид үлдээх буюу хүүхдийн амьдрах газрыг ойлгоно.

-Энэ хуулийн 13.8-д заасан “хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрх” гэж хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүүхэд гадаад улсад зорчих, шашин шүтэх, эс шүтэх, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх дугуйланд сургах зэрэг хүүхдийн хөгжил, хүүхдийн хуваарьт хөрөнгийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиран зарцуулах талаар шийдвэр гаргах эрхийг ойлгоно.

-Энэ хуулийн 13.11-д заасан “хүнд өвчтэй” гэж гэрлэгчдийн хэн нэг нь баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалтад заасан өвчтэй бөгөөд шүүхэд гэрлэлт цуцлуулах асуудлыг хэлэлцэх үед өвчин нь хүндэрсэн шатандаа орсны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжгүй болох нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байхыг ойлгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 46
Бүгд: 98
53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Шүүх гэр бүлийн нэг гишүүнд ногдох хөрөнгийг тодорхойлох

15.1.Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хэсгийг тодорхойлоход гэрлэлтийн гэрээ, эсхүл гэрлэлтийн гэрээ байгуулаагүй бол Иргэний хуулийн 129, 130 дугаар зүйлд заасны дагуу шүүх шийдвэрлэнэ.

15.2.Гэрлэлтээс гадуурх харилцааны, эсхүл гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэрлэлт цуцалсан, эсхүл гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал,

хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлын үүднээс гэрлэлт цуцалсан, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол Иргэний хуулийн 129.3-т заасны дагуу гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо шүүх өөрөөр тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 44

Бүгд: 98

55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл.Хүүхдэд нэр, эцэг /эх/-ийн нэр, овог өгөх

24.1.Эцэг, эх харилцан зөвшилцсөний үндсэн дээр хүүхдэдээ нэр өгнө.

24.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хүүхэд эцгийн овог, нэрийг авна.

24.3.Хүүхдийн эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлээгүй бөгөөд харилцан тохиролцоогүй, эсхүл хүүхдийн эцгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогоогүй, эсхүл эцэг, эхийн хэн нэгний өмнөх гэрлэлт дуусгавар болоогүй бол эх нь хүүхдэд нэр өгөх бөгөөд хүүхэд эхийн овог, нэрийг авна.

24.4.Хүүхдийн эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй бол улсын бүртгэлийн байгууллага хүүхдэд нэр, овог, эцэг /эх/-ийн нэр өгч болно.

24.5.Дараах тохиолдолд хүүхдийн эцэг, эсхүл эхийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хүүхдэд овог, эцэг /эх/-ийн нэр өгнө:

24.5.1.хүүхдийн эцгийг тогтоосон бол эцгийн овог, нэрийг;

24.5.2.эцэг нь тодорхойгүй бөгөөд хүүхдийн эхийг тогтоосон бол эхийн овог, нэрийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 45

Бүгд: 98

54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 33 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32 дугаар зүйл болгох:

“32 дугаар зүйл.Хүүхдийн асрамж, хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн эрх, үүрэг

32.1.Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бусад шалтгаанаар хүүхдийн оршин суугаа газраас өөр газарт оршин сууж байгаа нь хүүхдийн өмнө хүлээх эцэг, эхийн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

32.2.Хүүхдийн асрамж, хүүхдийн талаар шийдвэр гаргах болон тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарьтай холбоотой гаргасан шүүхийн шийдвэрийг эцэг, эх биелүүлэх үүрэгтэй.

32.3.Хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхдийн талаар мэдээлэл авах эрхтэй.

32.4.Хүүхдийн талаар шийдвэр гаргах эрхтэй эцэг, эсхүл эх нь хүүхдийн асуудлаар гаргасан аливаа шийдвэрийн талаар тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

32.5.Эцэг, эхийн хэн нэг нь, эсхүл 14 насанд хүрсэн хүүхэд тухайн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хүүхдийн асрамж болон хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарийн талаарх шүүхийн шийдвэрийг өөрчлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

32.6.Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бусад шалтгаанаар эцэг, эх тусдаа амьдарч байгаа бол энэ хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хэн нэгэндээ саад учруулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 45

Бүгд: 98

54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 49 дүгээр зүйлийг 46 дугаар зүйл болгож, 49.4 дэх хэсгийн “49.1-д” гэснийг “46.1-д” гэж, 49.5 дахь хэсгийн “49.4-т” гэснийг “46.3-т” гэж, 49.8 дахь хэсгийн “хүүхдийн” гэснийг “түүний” гэж тус тус өөрчилж, 49.3 дахь хэсгийг хасаж, 49.1, 49.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.1, 46.2 дахь хэсэг болгох:

“46.1.Талууд энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бол шүүх энэ хуулийн 46.2-т заасан тэтгэлэг тогтоох аргачлалын дагуу хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг харгалзан тэтгэлэг тогтооно.

46.2.Тэтгэлэг тогтоох аргачлалыг сар, улирал, хагас жил, эсхүл жилээр төлөх тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, тэтгэлэг авагчийн хэрэгцээ, шаардлага, хүүхдийн нас, тоо, хүүхэдтэй уулзах хуваарь зэрэг нөхцөл байдлыг харгалзан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 44

Бүгд: 98

55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 54 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 53 дугаар зүйл болгох:

“53 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөх

53.1.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бөгөөд шүүхийн шийдвэрээр тэтгэлгийн хэмжээг тогтоосны дараа энэ хуулийн 44, 45 дугаар зүйлд заасан тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдал өөрчлөгдсөн бол тэтгэлэг авагчийн, эсхүл тэтгэлэг төлөгчийн нэхэмжлэлийн үндсэн дээр тэтгэлгийн хэмжээг өөрчлөх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

53.2.Шүүх энэ хуулийн 53.1-д заасан асуудлыг шийдвэрлэхдээ энэ хуулийн 46.2-т заасан аргачлалын дагуу дахин тогтооно.

53.3.Эцэг, эх, эсхүл төрлийн хүн нь хүүхдийг энэ хуульд заасан хугацаанд тэжээн тэтгэх, өсгөн хүмүүжүүлэх үүргээ ноцтой зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол хүүхэд 18 насанд хүрснээс хойш эцэг, эх, эсхүл төрлийн хүнээ тэжээн тэтгэх үүргээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөж болно.

53.4.Тэжээн тэтгүүлэгчийн тэжээн тэтгүүлэх эрхийн үндэслэл арилсан бол энэ хуулийн 43.1-д заасан этгээдийн тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болно.

53.5.Тэжээн тэтгүүлэгч нь тэжээн тэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, хүчирхийлсэн, дарамталсан, гэм хор учруулсан, эсхүл учруулахаар завдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол тэтгэлэг төлөгчийг тэжээн тэтгэх үүргээс шүүхийн шийдвэрээр чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 42

Бүгд: 98

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 66 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 65 дугаар зүйл болгох:

“65 дугаар зүйл.Үрчлэгчийн эрх, үүрэг, хориглох зүйл

65.1.Үрчлэгч нь эцэг, эхийн нэгэн адил энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

65.2.Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн чадамжтай, эрүүл мэндийн болон эдийн засгийн бүрэн чадавхтай хүн байх бөгөөд ашиг олох зорилгоор хүүхэд үрчлэн авахыг хориглоно.

65.3.Хүүхдийг дараах хүнд үрчлүүлэхийг хориглоно:

65.3.1.бусдын асрамж, дэмжлэгт байгаа хүн;

65.3.2.ганц бие 65, түүнээс дээш настай хүн;

65.3.3.шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тогтоогдсон хүн;

65.3.4.эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан хүн;

65.3.5.үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн хүн;

65.3.6.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүн;

65.3.7.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар эцэг, эх байх эрх, үүргийг биелүүлж чадахгүй болох нь тогтоогдсон хүн;

65.3.8.хорих ял эдэлж байгаа, эсхүл Эрүүгийн хуульд заасан хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж, эсхүл Эрүүгийн хуульд заасан бусад гэмт хэрэгт удаа дараа ял шийтгүүлж байсан хүн;

65.3.9.бүртгэлтэй хаяг дээрээ амьдардаггүй, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй орчинд амьдардаг хүн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 45

Бүгд: 98

54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 68 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 67 дугаар зүйл болгох:

“67 дугаар зүйл.Хүүхэд үрчлэлтийн бүртгэл, хяналт

67.1.Хүүхэд үрчлүүлэх эсэх шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор тухайн шүүх шийдвэрийн хувийг улсын бүртгэлийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

67.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь үрчлэлтийн мэдээллийн сан /хүүхэд үрчлэх хүсэлтэй иргэн, үрчлүүлэх хүүхдийн болон үрчлэгдсэн хүүхэд, үрчилж авсан иргэний мэдээлэл/ бүрдүүлнэ.

67.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд түүнийг 18 насанд хүртэл хагас жил тутамд хяналт тавьж, хүүхдийн хөгжлийн тайланг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

67.4.Энэ хуулийн 67.2-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, энэ хуулийн 67.3-т заасан үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

67.5.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн нөхцөл байдал бий болсныг тогтоовол хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны

байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

67.6. Сонирхогч тал үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсэн гэж үзвэл үрчлэлтийг хүчингүй болсонд тооцуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 42
Бүгд: 98
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

11. Төслийн 83 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 82 дугаар зүйл болгох:

“82 дугаар зүйл. Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх

82.1. Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхэд Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хуулийг дагаж мөрдөнө.

82.2. Монгол Улсын харьяат хүүхдийг Монгол Улсын иргэн үрчлэн авах хүсэлт гаргаагүй бол хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцүүлэн хүүхэд үрчлэн авахаар хүсэлт гаргасан гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлнэ.

82.3. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий гадаад үрчлэлтийн орон тооны бус зөвлөл /цаашид “Гадаад үрчлэлтийн зөвлөл” гэх/ ажиллана.

82.4. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллага, эсхүл зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн байгууллагаар дамжуулан Гадаад үрчлэлтийн зөвлөлд гаргана.

82.5. Монгол Улсад 6 сараас доошгүй хугацаанд байнга оршин сууж байгаа гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах хүсэлтээ энэ хуулийн 82.4-т заасан байгууллагаар дамжуулалгүйгээр Гадаад үрчлэлтийн зөвлөлд гаргана.

82.6. Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэн үрчлэн авахад энэ хуулийн 64, 65 дугаар зүйлд заасныг нотлох тайланг өөрийн улсын эрх бүхий байгууллагаас гаргуулж, энэ хуулийн 82.9-д заасан журмын дагуу ирүүлнэ.

82.7. Гадаад үрчлэлтийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн улс хооронд хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэх бөгөөд үрчлэгдсэн эсэх тухай шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын таван өдрийн дотор улсын бүртгэлийн болон гадаадын иргэний асуудал хариуцсан байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

82.8.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх тухай шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор үрчлэгчид мэдэгдэж, шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

82.9.Энэ хуулийн 82.3-т заасан Гадаад үрчлэлтийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

82.10.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг тухайн улсын хуулийн дагуу үрчлүүлсэн нь Монгол Улсын олон улсын гэрээ, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд харшлаагүй бол хүлээн зөвшөөрч болно.

82.11.Энэ хуулийн 65.3-т зааснаас гадна Монгол Улсаас албадан гаргасан, Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байхаар тогтоосон хугацаа нь дуусаагүй байгаа гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 41

Бүгд: 98

58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 84 дүгээр зүйлийг 83 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“83 дугаар зүйл.Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих

83.1.Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийн мэдээллийг энэ хуулийн 67.2-т заасан үрчлэлтийн мэдээллийн санд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтмол нийлүүлнэ.

83.2.Улс хооронд үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд тавих хяналтыг Дипломат төлөөлөгчийн газар хэрэгжүүлнэ. Дипломат төлөөлөгчийн газар байхгүй тохиолдолд Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, мэдээлэл авна.

83.3.Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэн, гэр бүл нь хүүхдийн хөгжлийн тайланг 18 насанд хүртэл хагас жил тутамд энэ хуулийн 83.2-т заасан байгууллагаар дамжуулан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад болон гадаадын иргэний харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

83.4.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдсан, эсхүл тогтоогдсон бол Дипломат төлөөлөгчийн газар, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гадаадын иргэний

харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

83.5.Гадаад улсад оршин суугаагаас бусад гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд заасан хяналт тавьж, хүүхэд хөгжлийн тайланг хагас жил тутамд гаргана.

83.6.Гадаад улсад оршин суугаагаас бусад гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдсан, эсхүл тогтоогдсон бол хүн, хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

83.7.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсний дараа хяналт тавих, үрчлэгч талтай гэрээ байгуулах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

83.8.Сонирхогч тал улс хооронд үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл үрчлэлтийг хүчингүй болсонд тооцуулах нэхэмжлэлийг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн хүүхдийг үрчлүүлэх шийдвэр гаргасан шүүхэд гаргаж, шийдвэрлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 49

Бүгд: 98

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 47

Бүгд: 98

52.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

12.Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 46

Бүгд: 98

53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 8¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8¹.1.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 45

Бүгд: 98

54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.1.5, 6.1.6 дахь заалт болгох:

“6.1.5.донорын бэлгийн эс ашиглаж хүүхэд төрсөн бол түүнийг нотлох эмнэлгийн байгууллагын магадлагаа болон хоорондын байгуулсан гэрээ;

6.1.6.донорын бэлгийн эс ашиглан тээгч эхээс хүүхэд төрсөн бол түүнийг нотлох эмнэлгийн байгууллагын магадлагаа болон хоорондын байгуулсан гэрээ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 44

Бүгд: 98

55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.19, 6.20 дахь хэсэг нэмэх:

“6.19.донорын бэлгийн эс ашиглаж төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг Гэр бүлийн тухай хуулийн 27.2-т заасан эцэг, эхийн овог, нэрээр бүртгэж, төрсний гэрчилгээ олгоно.

6.20.донорын бэлгийн эс ашиглан тээгч эхээс төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг Гэр бүлийн тухай хуулийн 27.2-т заасан эцэг, эхийн овог, нэрээр бүртгэж, төрсний гэрчилгээ олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 45

Бүгд: 98

54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.3.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцалсан бол гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван

өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 46

Бүгд: 98

53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Гэрлэлт сэргээсний бүртгэл

9.1.Гэр бүлийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу иргэн гэрлэлт сэргээсний бүртгэлд бүртгүүлэх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, өөрийн биеэр бүртгүүлнэ:

9.1.1.тус тусдаа гаргасан өргөдөл;

9.1.2.иргэний үнэмлэх, эсхүл иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, эсхүл паспортыг орлох баримт бичиг.

9.2.Гэр бүлийн тухай хуулийн 18.2, 18.3-т заасны дагуу гэрлэлтийг сэргээсэн бол гэрлэлт сэргээсэн тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

9.3.Иргэнийг нас барсан гэж зарласан, сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 9.2-т заасан баримт бичигт хавсаргана.

9.4.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

9.5.Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан энэ хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор гэрлэлт сэргээсний бүртгэлийг хөтөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 44

Бүгд: 98

55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлд “Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн” гэсний дараа “7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “8 дугаар зүйлд” гэснийг “5.3-т” гэж, мөн зүйлийн 7.8 дахь заалтын “9 дүгээр” гэснийг “7 дугаар” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 45
Бүгд: 98
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн ““нас барсны бүртгэлд” гэснийг “Гэр бүлийн тухай хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.4-т заасан тохиолдол бий болсон” гэж” гэснийг ““Гэрлэгч нас барсны бүртгэлд бүртгэгдсэн” гэснийг “Гэрлэгч нас барсны, эсхүл хүйс өөрчлөгдсөн бүртгэлд, эсхүл нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 127 дугаар зүйлийн 127.4, 127.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 127 дугаар зүйлийн 127.7 дахь хэсгийг 127.5 дахь хэсэг болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 45
Бүгд: 98
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт буюу 517 дугаар зүйлийн 517.3 дахь хэсэг нэмэх:

“517.3.Өвлүүлэгчийг 18 насанд хүртэл тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол өвлөх гэрээслэлд өөрөөр заагаагүй тохиолдолд уг этгээд хуульд заасан өвлөх эрхээ алдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 43
Бүгд: 98
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 129 дүгээр зүйлийн 129.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“129.3.Гэрлэлт дуусгавар болсонтой холбоотойгоор гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийг тодорхойлохдоо хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал болон хуульд заасан бусад нөхцөлийг харгалзан шүүх өөрөөр тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 133 дугаар зүйлийн 133.2 дахь хэсгийн “энэ хууль болон” гэснийг, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 517 дугаар зүйлийн 517.1 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 43
Бүгд: 98
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн “127.6” гэснийг “127.4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 46
Бүгд: 98
53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

С.Бямбацогт: Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт,” гэснийг “заалтын” гэж өөрчилж, “мөн зүйлийн 7, 9 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 43
Бүгд: 98
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт нэмэх:

1/6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт:

“1.1.4.хүүхдээ үе тэнгийн дээрэлхэлт үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “торгох, эсхүл албадан сургалтад хамруулж, долоогоос гуч

хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэснийг “торгоно.” гэж өөрчилж, мөн зүйлийн 14, 15 дахь хэсгийг төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалтын дугаарыг “1.1.5” гэж өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 43
Бүгд: 98
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 46
Бүгд: 98
53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

С.Бямбацогт: Төслийн 1 дүгээр зүйлийн “55.2.1-55.2.6, 55.3.1-55.3.6-д” гэснийг “54.1, 54.2-т” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

С.Бямбацогт: Төслийн 1 дүгээр зүйл буюу Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.7.“бүтэн өнчин хүүхэд” гэж Гэр бүлийн тухай хуулийн 4.1.2-т заасныг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 46

Бүгд: 98
53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгасан санал:

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл

С.Бямбацогт: 1.Төслийн 60 дугаар зүйлийг 59 дүгээр зүйл болгож, 60.1.1 дэх заалтын “сурч” гэсний өмнө “хөгжүүлэх,” гэж нэмж, 60.1.3 дахь заалтын “үл хөдлөх эд хөрөнгө, мал, банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг” гэснийг “хөрөнгийг” гэж, “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.1.4 дэх заалтын “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.2.3 дахь заалтын “асрамж,” гэснийг “асран хамгаалалт, харгалзан” гэж, 60.2.4 дэх заалтын “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж, 60.2.5 дахь заалтын “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 60.3 дахь хэсгийн “бага насны” гэснийг “долоон насанд хүрээгүй” гэж тус тус өөрчилж, 60.2.4 дэх заалтын “, дэнчин тавих” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 75 дугаар зүйлийг 74 дүгээр зүйл болгож, 75.1 дэх хэсгийн “хуулийн зарчимд харшлахгүй бол гэрлэлтийг Монгол Улсад хүчинтэйд тооцно.” гэснийг “хуульд заасан нөхцөлийг хангаж, гэрлэхэд харшлах шалтгаангүй бол Монгол Улсад гэрлэлтийг хүчин төгөлдөр гэж үзэж, хүлээн зөвшөөрнө.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 43
Бүгд: 98
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 82 дүгээр зүйлийг 81 дүгээр зүйл болгож, 82.2 дахь хэсгийн “хуулиар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол хүчинтэйд” гэснийг “хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 42
Бүгд: 98
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 43

Бүгд: 98

56.1 хувийн саналаар гормын санал дэмжигдлээ.

Горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 43

Бүгд: 98

56.1 хувийн саналаар гормын санал дэмжигдлээ.

Горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар гормын санал дэмжигдлээ.

Горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар гормын санал дэмжигдлээ.

Горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал:

Нэг.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл

С.Бямбацогт: “37 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч

37.1.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилох бөгөөд сэтгэл зүйч нь төрийн захиргааны албан хаагч байна.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан сэтгэл зүйч нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож болох бөгөөд ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 47

Бүгд: 98

52.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

С.Бямбацогт: Төслийн нэрийг “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” гэж өөрчилж, төслийн 1, 2, 3, 4, 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн онцлог, зориулалтад нийцсэн, стандартын шаардлага хангасан шүүхийн барилга байгууламж шинээр барих байршил, газрын асуудлыг судалж, шийдвэрлэх;

2/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн барилга байгууламжийг барихад шаардагдах зардал болон гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх бусад шүүхийн барилгад зориулалтын шүүх хуралдааны танхим, хүүхдээс мэдүүлэг авах тусгай өрөө байгуулах асуудлыг судалж, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх арга хэмжээг авах;

3/Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтад заасан Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч, мэргэжилтнийг бэлтгэх, тэдгээрийн цалин хөлс болон үйл ажиллагаа, чиг үүрэгт холбогдох шаардлагатай зардлыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх;

4/гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, шүүхийн цахим үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хэрэг, маргааныг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх.

2.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөл /П.Золзаяа/-д даалгасугай:

1/Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтад заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтнийг сургах;

2/гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчийг мэргэшүүлэн сургах;

3/гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж, хэрэгжүүлэх.

3.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи /Д.Эрдэнэчимэг/-д даалгасугай:

1/гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг мэргэшүүлэн шинээр батлагдсан хууль тогтоомж, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр сургаж, бэлтгэх;

2/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх болон дүүргийн, сум, сум дундын анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлалын багт ажиллах шүүгчийг бэлтгэх, шаардлагатай сургалтад хамруулах.

4.Өсвөр насны хүнд авсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, бэлтгэл ажил хангахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/, Хууль зүй, дотоод хэргийн сайд /С.Амарсайхан/-д тус тус даалгасугай.

5.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байгаа боловч хугацаанаас өмнө суллагдах боломжтой өсвөр насны хүний талаарх мэдээллийг хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтран гаргаж, хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд /С.Амарсайхан/, суллагдсан өсвөр насны хүнд хяналт тавьж, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/-д тус тус даалгасугай.

6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор хамтран хэрэгжүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/, Шүүхийн ерөнхий зөвлөл /П.Золзаяа/-д тус тус даалгасугай.

7.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт заасан “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам”-ыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор баталж, хэрэгжүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/, Хууль зүй, дотоод хэргийн сайд /С.Амарсайхан/, Монгол Улсын Ерөнхий прокурор /Б.Жаргалсайхан/, Шүүхийн ерөнхий зөвлөл /П.Золзаяа/-д тус тус даалгасугай.

8.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу арван зургаан насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах ажиллагааг явуулахад шаардагдах дуу-дүрсний бичлэг хийх зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэх, шинэчлэх асуудлыг судалж, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

9.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт заасан эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийн ажиллах журмыг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор баталж, хэрэгжүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/-д даалгасугай.

10.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг тогтоох, хөрөнгөтэй холбоотой болон бусад гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хуульч, өмгөөлөгчийг мэргэшүүлэн сургах, хууль тогтоомжийг сурталчлах зэрэг арга хэмжээ авахыг Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч /М.Мөнхбат/, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч /Л.Данзанноров/-т зөвлөсүгэй.

10.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг тогтоох, хөрөнгөтэй холбоотой болон бусад гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хуульч, өмгөөлөгчийг мэргэшүүлэн сургах, хууль тогтоомжийг сурталчлах зэрэг арга хэмжээ авахыг Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч /М.Мөнхбат/, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч /Л.Данзанноров/-т зөвлөсүгэй.

11.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

12.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 46

Бүгд: 98

53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгасан санал:

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

С.Бямбацогт: Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “3 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8.6 дугаар зүйл:

8.6 дугаар зүйл. Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1. Шүүх энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

2. Өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан бол энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоох хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авна.

3. Өсвөр насны хүнд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага хамтран хэрэгжүүлэх талаар шүүхийн шийдвэрт тусгана.

4. Өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааны 50 хувь өнгөрсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол цаашид хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй талаарх прокурорын дүгнэлтийг үндэслэн хугацаанаас өмнө эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

5. Өсвөр насны хүн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

6. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

7. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд өсвөр насны хүн санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

8.Шүүх прокурорын дүгнэлтийг үндэслэн өсвөр насны хүнд шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан хугацаанд хүлээлгэсэн энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтыг өөрчилж болно.

2/8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтаас гадна дараах үүрэг, хязгаарлалтыг хүлээлгэнэ:

2.1.өсвөр насны хүнд болон түүний гэр бүлд сэтгэл зүйчээс зөвлөгөө, эмчилгээ авахыг даалгах;

2.2.нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд хамруулах;

2.3.хичээлийн ирцээ тогтмол хүргүүлэхийг даалгах;

2.4.хохирогчоос уучлал хүсэхийг даалгах;

2.5.шөнийн цагаар гэртээ байхыг даалгах;

2.6.өсвөр насны хүнийг хүмүүжүүлэхэд шаардлагатай бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 45
Бүгд: 98
54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 48
Бүгд: 98
51.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 45
Бүгд: 98
54.1 хувийн саналаар гормын санал дэмжигдлээ.

Горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

С.Бямбацогт: Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.5.10 дахь заалтыг хэвээр үлдээх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 42
Бүгд: 98
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: ““Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 47

Бүгд: 98

52.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын урилгаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын сургуулийн 1989, 2006 оны төгсөгчид, Завхан аймгийн Нөмрөг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын 40 дүгээр сургуулийн 1986 оны төгсөгчид, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 1996 оны төгсөгчид, Завхан аймгийн Баянтэс сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын 16 дугаар сургуулийн 1991 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн урилгаар Завхан аймгийн Улиастай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2005 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Оюуны-Ирээдүй” сургуулийн 2006 оны төгсөгчид, Увс аймгийн Давст сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид, Увс аймгийн Цагаанхайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид, Увс аймгийн Бөхмөрөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Төмөр замын их сургуулийн Төмөр зам, замын аж ахуйн инженерийн ангийн 2006 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны урилгаар “Тэгш нийгэм холбоо” төрийн бус байгууллага болон Бие бялдар сэргээн засах Монголын нийгэмлэгийн ажилтнууд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 22 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 41 минут үргэлжилж, 126 гишүүнээс 101 гишүүн хүрэлцэн ирж, 80.2 хувийн ирцтэйгээр 18 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БЯМБАДУЛАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 10 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад чуулганы эхлэх хугацаа жоохон хоцорчихлоо. 2026 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн чуулганы хуралдааны ирц ирвэл зохих 126 гишүүнээс 75 гишүүн буюу 59.5 хувийн ирцтэй байна. Чуулганы хуралдаан ирц бүрдсэн учраас чуулганы хуралдааныг нээснийг мэдэгдье.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурал /УИХ-ын/ гишүүн Гомбын Ганбаатарын урилгаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЕБС-ийн 1989 он болон 2006 оны төгсөгч УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Гишүүддээ чуулганы мэдээлэл өгье. Долоо хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай. 1.Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд ТБХ-ны 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны явцад тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг хойшлуулсан тул нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлаас хасагдсан.

6 дугаар сарын 26-нд УИХ-ын гишүүн Энхбатын Болормаа төрсөн байна. Тэгээд УИХ-ын гишүүн Энхбатын Болормаад төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд УИХ-ын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдөр чуулганы хуралдаанд 9 цагт хүрэлцэн ирсэн гишүүдээ танилцуулъя. Алтаншагай, Пүрэвдорж, Алдаржавхлан, Заяабал, Баярбаатар, Эрдэнэбат, Эрдэнэболд, Сарнай, Соронзонболд нарын гишүүд яг 9 цаг 00 минутад чуулганы хуралдаанд хүрэлцэн ирсэн байна. Тэгээд эртэч гишүүддээ баяр хүргэе.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 22 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт нь хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 9 төсөл байгаа, 2 дугаарт нь УИХ-ын чуулганаар Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ, 3 дугаарт нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/-ийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ, 4 дүгээрт нь Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн

анхны хэлэлцүүлгийг явуулна, 5 дугаарт нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ, 6-д нь Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна, 7-д нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна, 8-д нь Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна, 9-д ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна. Гэр бүлийн хуулийг дагаж хэлэлцэж байгаа асуудлууд саяын хуулиуд, 10-д нь Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна, мөн Гэр бүлийн хуулийг дагаж өөрчлөх ёстой, 11-д Эх эцэг олон хүүхэд өрх толгойлсон эх эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг, 12-т нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг мөн гэр бүлийн хуулиуд дагасан нэлээн хэдэн хуульд өөрчлөлт орно.

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар 13-т УИХ-ын асуулгын цаг, 14-т Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд эцсийн хэлэлцүүлэг явуулна, 15-т Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна, 16-т Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна, 17-т Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна, 18-т Нийслэлийн 2024-өөс 2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх төсвийн байгууллагын санал, дүгнэлтийг хэлэлцэнэ, 19-т Зарим байгууллагын цалингийн хэмжээг тогтоох тухай УИХ-ын 2023 оны 117 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ, 20-т Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /ХЭҮК/-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна, 21-т Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолыг хэлэлцэнэ, 22-т баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно. Ийм 22 асуудал өнөөдөр хэлэлцэнэ.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д УИХ-ын дарга хууль санаачлагч УИХ-д өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлж бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороодод хуваарилсан талаар танилцуулъя.

Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн БОХХАА-н байнгын хороонд хуваарилсан.

Зочин танилцуулъя. Завхан аймгийн Нөмрөг сумын ерөнхий боловсролын сургууль /ЕБС/-ийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой

танилцаж байна. Төгсөлтийнхөө 20 жилийн ойг тэмдэглэж байгаа Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Хэлэлцэх асуудалдаа орно. ТББХ тун удахгүй дуусна. Сая хурал эхэлсэн. ТББХ-ны гишүүд орж ирэхээр, дуусчихсан байх шиг байна. Дуусаж уу Төрийн байгуулалт? Дууссан байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ/-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, ААНОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална. Гишүүд, ТББХ дууссан гишүүд орж ирж байна.

Гишүүд, хуулийн төслүүдийг эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Санал хураалтдаа бэлтгэцгээе гишүүд. Гишүүд санал хураалтдаа бэлтгэж дууссан уу? Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирцэд ороогүй татгалзсан гарч байгаа гишүүд чуулганы танхимд хүрэлцэн ирнэ үү. Бат-Эрдэнэ гишүүн байна, Хэрлэн гишүүн байна, Алтаншагай байна. Гишүүд суудлаа эзэлчихье, хуулийн төсөл эцэслэн батална, 64 гишүүний саналаар эцэслэн батлах ёстой, суудлаа эзэлцгээе.

Хуулийн төслүүдийн эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Сая бэлдчихсэн байгаа. Дахиад санал хураалтад бэлдчихээрэй гишүүд. Зочин танилцуулъя. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын ЕБС-ийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Санал хураалт явуулъя гишүүд анхааралтай байгаарай.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 85 гишүүн оролцсоноос 73 гишүүн буюу 85 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 85 гишүүн оролцож, 74 гишүүний 87 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 71 гишүүн буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын

томьёоллоор санал хураалт явуулъя. 86-аас 72 гишүүн буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 86-аас 71 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 86-аас 74 буюу 86 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-гоос 73 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-гоос 73 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-гоос 72 гишүүний 82 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа. УИХ-ын гишүүд, ажлын хэсэгт талархлаа илэрхийлье.

10.29 цаг

Хоёр. “Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. УИХ-ын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг хэлэлцэж шийдвэрлэнэ. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулах хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх УИХ-д бичгээр хүсэлт тавьсан бол УИХ-ын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ гэж заасан.

Засгийн газраас 2026 оны 6 дугаар сарын 25-ны өдөр уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Их Хуралд өргөн мэдүүлсэн. УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт явуулъя.

“Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 89 гишүүн орсноос 69 гишүүн дэмжиж, 77.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Төслийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

10.31 цаг

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал /үргэлжилнэ/

Дараагийн асуудалдаа орѐе. Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. УИХ-ын гишүүд нэр дэвшүүлсэн байгууллага болон нэр дэвшигчдээс асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Жамъянхорлоогийн Сүхбаатарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжѐе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 90 гишүүн орсноос 76 гишүүн буюу 84 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ганбатын Эрдэнэбатыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжѐе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 91 гишүүн орсноос 77 гишүүн буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ. Даваагийн Цогтбаатар гишүүн, Саруулсайханы Цэнгүүн гишүүнийг дэмжсэнд авъя. Даваасүрэн гишүүнийг Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнийг дэмжсэнд авъя. Жанчивын Галбадрах гишүүнийг дэмжсэнд тооцѐе. Ингээд 91 гишүүн, 81 гишүүн болж байх шиг байна.

ҮХЦ-ийн гишүүнээр томилох саналыг хуралдаанд оролцогчдын олонх дэмжсэн тул Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнээр томилох, Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнээс чөлөөлөх тухай УИХ-ын тогтоолыг баталсанд тооцлоо. Туваан, Бейсен гишүүнийг дэмжсэнд тооцѐе.

Монгол УИХ-ын тогтоол, 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэг, 105 дугаар зүйлийн 105.2 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1.Монгол УИХ-ын санал болгосноор Жамъянхорлоогийн Сүхбаатар, Ганбатын Эрдэнэбат нарыг Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнээр томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Гунгаагийн Баясгаланг Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнээс чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2026 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр, тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.35 цаг

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 40 дүгээр сургуулийн 1986 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төгсөлтийнхөө 40 жилийн ойг тэмдэглэж байгаа зочдодоо УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Дөрөв.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Дараагийн асуудалдаа оръё. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхны хэлэлцүүлэг үргэлжлүүлнэ. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 48 санал байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Нэг.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.40 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.40.“гэрээ байгуулах боломжтой талбай” гэж энэ хуулийн 4.1.39-д заасан гэрээг байгуулах боломжтой тусгай зөвшөөрөл олгогдоогүй, ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцаагүй, сонгон шалгаруулалтын талбайд хамрагдаагүй, эсхүл сонгон шалгаруулалтыг хоёр удаа зарласан боловч сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирээгүй, геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэхээр тогтоосон талбайг;” Санал гаргасан УИХ-ын гишүүн Жавхлан, Батбаяр, Батболд, Батнайрамдал, Наранбаатар, Туваан, Ундраа, Уянга, Мөнхсоёл, Үүрийнтуяа, Эрдэнэбүрэн цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт. Санал хураалтад 126 гишүүнээс 92 гишүүн орсноос 63 гишүүн буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.39 дэх заалтын “геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний геологийн алба” гэж, 3 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн, 15^{1.7.5} дахь заалтын “геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэснийг “Үндэсний геологийн албанд” гэж, 15^{1.3} дахь хэсэг, 15^{1.4} дэх хэсэг, 15^{1.8} дахь хэсэг, 15^{1.9} дэх хэсгийн “Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний геологийн алба” гэж, 15^{1.7} дахь хэсгийн “Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай” гэснийг “Үндэсний геологийн албатай” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 92-оос 60 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.2.4} дэх заалтын “чадавхыг тусгасан” гэсний дараа “геологийн суурь судалгаа, эрлийн” гэж нэмэх. Санал

гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 92-оос 64 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15¹.7.6 дахь заалт, 15¹.7.7 дахь заалт, 20.5.7 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 92-оос 64 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15¹.9 дэх хэсгийн “15¹.1-д” гэснийг “4.1.40-д” гэж, “мэдээлнэ” гэснийг “мэдээлж байна” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 92-оос 64 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19¹.2.1 дэх заалтын “гэрээний хэрэгжилтийн тайлан” гэснийг “гэрээ дүгнэсэн акт” гэж, 19¹.2.3 дахь заалтын “зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл авах” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 92-оос 65 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зочин танилцуулъя. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 1996 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө ойг тэмдэглэж байгаа Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19¹.8 дахь хэсгийн “зөвшөөрөл олгосон” гэсний дараах “даруйд энэ” гэснийг хасаж, “нийтэд ил тод” гэсний дараах “мэдээлнэ” гэснийг “, нээлттэй мэдээлж байна.” гэж өөрчлөх. Санал хураалт. 93-аас 61 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 27.1.15 дахь заалтын “ирүүлэх” гэснийг “хүргүүлэх” гэж өөрчилж, 27.1.16 дахь заалтын “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93-аас 62 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 28¹, 29¹ дүгээр зүйлийн гарчгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 28³.4 дэх хэсгийн “28³.4” гэснийг “28³.3” гэж, 29¹.1 дэх хэсгийн “хаягдал чулуулгийн” гэснийг “хаягдлын” гэж тус тус өөрчилж, 28¹.1 дэх хэсгийн “зөвшөөрөлтэй” гэсний дараа “хуулийн” гэж нэмэх. Санал хураалт. 93-аас 62 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 42¹.1 дэх хэсгийн “олон нийтэд” гэснийг “олон нийт, орон нутгийн иргэдэд” гэж өөрчлөх. Санал хураалт. 93-аас 63 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.20 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.20.Эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах эрдэс, элементээс бусад эрдэс, элементэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулахгүй бөгөөд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулах эрдэс, элементийн төрөл, хэмжээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болголоо. 11 дэх саналд ажлын хэсгийн ахлагч Жавхланд микрофон өгье.

Б.Жавхлан: Бүгдэд нь өглөөний мэндийг хүргэе. Энэ дээр гүйцээн боловсруулах шаардлага үүсээд байгаа юм. Энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл авах гэсэн юм.

С.Бямбацогт: 11 дэх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө, ажлын хэсэг Эдийн засгийн байнгын хороонд. 12.Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дахь заалтын 64^{1.1} дэх хэсгийн “саад учруулахыг” гэсний өмнө “хууль бусаар” гэж нэмэх. Санал хураалт. 93-аас 64 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 32.2 дахь хэсгийн “19^{1.5}-д заасан хайгуулын тусгай зөвшөөрлийн” гэснийг “19^{1.4}-т заасан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан талбайн” гэж өөрчлөх. Санал хураалт. 93-аас 59 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 47.5 дахь хэсгийн хүснэгтийн 2 дахь баганын “Ашигт малтмалын нэр төрөл” гэснийг “Бүтээгдэхүүний нэр төрөл” гэж, 5 дахь баганын “ам.доллар” гэснийг “ам.доллороор” гэж, 6 дахь баганын “Боловсруулалтаас хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь” гэснийг “Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 93-аас 62 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 4 дүгээр зүйлийн “40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “байгаль орчны менежментийн” гэснийг “байгаль орчныг хамгаалах” гэж,” гэснийг хасах. Санал хураалт. 93-аас 62 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.32 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.32.“чухал ашигт малтмал” гэж олон улсын зах зээлд өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд, эсхүл дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангахад шаардлагатай ашигт малтмалыг;” Санал хураалт. 93-аас 63 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.38 дахь заалтыг хасах. Санал хураалт. Ажлын хэсэг жоохон анхааралтай байна шүү. Санал хураалтыг хүчингүй болголоо. Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Их Хурлын дарга уучлаарай, энэ дээр ажлын хэсэг нэг эргэж харах асуудал байгаа юм. Энэ дээр гүйцээн боловсруулахад чиглэл авах гэсэн юм.

С.Бямбацогт: 17 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

18.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.43 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 93-аас 62 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн “Энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг “Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч” гэж, мөн хэсгийн “гаргаж

болно” гэснийг “гаргана” гэж өөрчлөх. Санал хураалт. 93-аас 61 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зочин танилцуулъя. Завхан аймгийн Баянтэс сумын ЕБС-ийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 20 жилийн ойг тэмдэглэж, Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

20.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 20.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.9.Сонгон шалгаруулалтаар олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн босго үнэ нь 25-3000 гектар бол 20000 нэгж, 3000 гектараас дээш бол 20000 нэгж дээр нэг гектар тутамд 7 нэгж нэмж тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 94 гишүүнээс 62 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21, Ажлын хэсгийн ахлагч Болдын Жавхлан. 5 асуудал дээр гүйцээн боловсруулах шаардлагатай байгаа юм. Энэ ингээд 3 дахь нь болж байна. Энэ 21 дүгээр асуудал дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: 21 дэх санал хураалтыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө, Эдийн засгийн байнгын хороо, ажлын хэсэгт. 22.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.Хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.” Санал хураалт. 94-өөс 59 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 32.1 дэх хэсгийн “35 нэгж” гэсний дараа “, 6-9 дэх жилд 50 нэгж” гэж нэмэх, 5 дахь заалтын 33.1.5 дахь заалтын “6 дахь жилд” гэснийг “7-9 дэх жилд” гэж өөрчлөх. Санал хураалт. 94-өөс 56 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24, ажлын хэсгийн ахлагч Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Баярлалаа. 24 дээр мөн гүйцээн боловсруулах чиглэл авъя, тийм энэ дээр нэг жоохон янзлах асуудал байгаа.

С.Бямбацогт: 24 дэх санал хураалтыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө. 25.Төслийн 4 дүгээр зүйлээс “4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний,” гэснийг “засагт нөлөөлөхүйц,” гэж” гэснийг хасаж, төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт:

4.1.12.“стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг,” Санал хураалт. 94-өөс 57 буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 4 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “11.1.29” гэснийг “11.1.28” гэж өөрчлөх. Санал хураалт. 94-өөс 59 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төслийн 4 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “1 удаа” гэснийг “2 удаа” гэж өөрчлөх. Санал хураалт. 94-өөс 60 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 6 дугаар зүйлээс “15 дугаар зүйл,” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн “16 дугаар” гэсний өмнө “15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “мэдэгдэж бүртгүүлнэ” гэснийг “мэдэгдэнэ” гэж,” гэж нэмэх. Санал хураалт. 94-өөс 59 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг хууль зүйн техникт нийцүүлж өөрчлөх. Санал хураалт. 94-өөс 60 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.1/Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19¹.4 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “нь” гэж нэмэх.

1.2/Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15¹.3.2 дахь заалтын “талаар” гэснийг “тухай” гэж, 15¹.7 дахь хэсгийн “ажил” гэснийг “ажлыг” гэж, 10 дахь заалтын 29².1.2 дахь заалтын “талаар санал дүгнэлт” гэснийг “тухай санал, дүгнэлт” гэж, 12 дахь заалтын 35.13 дахь хэсгийн “байгууллагуудын” гэснийг “байгууллагын” гэж, 13 дахь заалтын 42¹.2.2 дахь заалтын “байгууллагуудтай” гэснийг “байгууллагатай” гэж, 2, 4 дүгээр зүйлийн “16 дугаар зүйл” гэснийг “16 дугаар зүйлийн гарчгийн” гэж тус тус өөрчлөх.

1.3/Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын 48.15 дахь хэсгээс “тус тус” гэснийг хасах.Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 94 гишүүнээс 58 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.35, 4.1.36 дахь заалтын, 10 дахь заалтын 28¹.3 дахь хэсгийн, 28³ дугаар зүйлийн, 16 дахь заалтын 64¹.2 дахь заалтын, төслийн 2 дугаар зүйлийн 35.10 дахь хэсгийн, төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7.1 дэх хэсгийн, 2 дахь заалтын 11.1.19 дэх заалтын, 6 дахь заалтын 35.4 дэх хэсгийн, төслийн 4 дүгээр зүйлийн 53.1 дэх хэсгийн “баяжуулалтын” гэснийг “боловсруулалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Цэнгүүн. Санал хураалт. 94-өөс 60 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын “ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ” буюу “АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖУУЛАЛТ” бүлгийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Наранбаатар. Санал хураалт. 94-өөс 60 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 32.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Цэнгүүн УИХ-ын гишүүн. Санал хураалт. 94-өөс 63 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.21 дэх хэсгийн “бүртгэж, хяналт тавина” гэснийг “бүртгэнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Цэнгүүн. Санал хураалт. 94-өөс 61 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, уурхай, баяжуулах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтэц хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар орон нутагтай хамтран ажиллах гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нарын нэгдсэн шийдвэрт үндэслэсэн саналаар байгуулж ажиллана.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Бадамсүрэн. Санал хураалт. 94-өөс 63 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, уурхай, баяжуулах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулж, уг гэрээг аймаг, нийслэлийн Засаг дарга батална.” Санал гаргасан УИХ-ын гишүүн. Наранбаатар гишүүн санал гаргасан гишүүн.

Н.Наранбаатар: Өглөөний мэнд хүргэе. Гишүүд минь энэ 42.1 дээр анхаараад өгөөч. Энэ хуулийн төслөөрөө зөвхөн сумын Засаг даргатай л гэрээ байгуулахаар яваад байгаа, нөгөө аймгийн Засаг даргыг хаячхаад байгаа юм. Тэгэхээр би санал гаргаад, Байнгын хороон дээр дэмжигдээгүй юм. Уг нь аймгийн Засаг дарга батална гээд оруулсан, дэмжээгүй юм. Тэгэхээр аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга хоёр хоёулаа оролцож байж л энэ лиценз эзэмшигчидтэй нөгөө нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах ёстой байхгүй юу. Тэгэхээр хэрвээ энэ төслөөрөө явбал одоо Оюутолгойтой жишээ нь Ханбогд сумын Засаг дарга л гэрээ байгуулна, аймгийн Засаг дарга ерөөсөө хамаагүй болчхож байгаа юм. Эрдэнэс Тавантолгой, Энержи Ресурс, бусад том компаниудтай Цогтцэций сумын Засаг дарга л гэрээ байгуулна, аймгийн Засаг дарга хамаагүй болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд чинь доор нь цагдаагийн газар, мэргэжлийн хяналт, байгаль орчин гээд бүгд байгаа байхгүй юу. Сумын Засаг даргатай л зөвхөн гэрээ байгуулна гэж орчхоод байгаа юм. Тэгэхээр энийг та бүхэн кнопдоо хүрэхгүй байж байгаад нэг босгоод өгөөч гэж хүсэх гэсэн юм.

С.Бямбацогт: Санал хураалт явуулъя. Санал хураалтад 94 гишүүнээс 49 гишүүн буюу 52 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зочин танилцуулъя. Булган аймгийн Хишиг-Өндөр сумын ЕБС-ийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө ойг тэмдэглэж, Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 47.5 дахь хэсгийн хүснэгтийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Батнайрамдал. Санал хураалт. 94-өөс 58 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал хураалт. 94-өөс 55 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйлийг хасах:

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө олгосон хайгуулын тусгай зөвшөөрөлд Ашигт малтмалын тухай хуулийн 21.1.5 дахь заалт, 32.1 дэх хэсэг, 33 дугаар зүйл хамаарахгүй болно.” Санал хураалт. 94-өөс 57 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлж тооцох хувийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Болдын Жавхлан. Саналаа тайлбарлаж л үг хэлнэ. Өөр боломжгүй. Үг хэлэх дэг байхгүй, тийм ээ? Санал хураалт. 94-өөс 48 буюу 51 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Энэ хуулийн 10.2-т заасан этгээд нь биржээр дамжуулан баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээж экспортлох зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт олон улсын худалдааны нөхцөлөөр арилжиж болно.” Санал хураалт. 94-өөс 56 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. 94-өөс 60 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал. 1.Төслийн 2 дугаар зүйлийн “, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтын “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэснийг “байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж” гэснийг хасах. Санал гаргасан

УИХ-ын гишүүн Мөнхбаясгалан. 94-өөс 60 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Ажлын хэсгийн ахлагч Болдын Жавхлан гишүүнд микрофон өгье.

Б.Жавхлан: Баярлалаа. Энэ нөгөө сүүлийнх нь юм байгаа юм. Энэ дээр нэг эргэж суух хэрэгтэй байгаа тул гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: Нэг дэх санал дээр үү?

Б.Жавхлан: Бүхэлд нь, тийм.

С.Бямбацогт: Хэд хүртэл? Хоёр дахь санал хураалтыг явуулах уу? Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэдгийг?

Б.Жавхлан: Үгүй ээ, бүхэлд нь.

С.Бямбацогт: Энэ бүхэлд нь, 5-ыг бүхэлд нь гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Зочин танилцуулъя. Нийслэлийн ЕБС-ийн 16 дугаар сургуулийн 1991 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Зургаа.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 59.1.2 дахь заалтын “15” гэснийг “20” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 94-өөс 60 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “30 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж” гэснийг “40 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж” гэж өөрчлөх. Санал хураалт. 94-өөс 60 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүд бусдадаа төвөг болохгүй жоохон өөр өөрсдийнхөө түвшинд ярьчихмаар байна шүү. Заал дүүрэн хашхирмааргүй байна шүү.

Долоо.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Энэ хуулийн” гэснийг “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн” гэж өөрчлөх. Санал хураалт. 94-өөс 60 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулж дууслаа. Ашигт малтмалын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

11.06 цаг

Тав.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Дараагийн асуудалдаа оръё. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл хэлэлцэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Энэ хуралдаанд УИХ-ын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе, хурууны хээгээ уншуулаарай. Бусдадаа хүндэтгэлтэй хандъя, бусдад нөлөөлөхгүй байя гишүүд. Өөр өөрсдийнхөө итгэл үнэмшлээр саналаа өгнө шүү дээ. Тийм болохоор бусдадаа нөлөөлөх гээд хэрэггүй. Санал хураалт явуулъя.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ санал уначихлаа. Туваан гишүүн горимын санал.

Ц.Туваан: Саяын санал хураалт дээр төхөөрөмж ажилласангүй тул энэ санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

С.Бямбацогт: Гишүүд анхааралтай байцгаана шүү. Туваан гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 95-аас 55 буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Санал хураалтыг явуулъя. Томъёоллыг уншиж танилцуулсан, санал хураалт. 95-аас 58 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

11.10 цаг

Зургаа.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хороо /ХЗБХ/-ны танилцуулгыг УИХ-ын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна. Одонтуяа гишүүн танилцуулъя, ажлын хэсгийн гишүүн.

С.Одонтуяа: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2026 оны 6 дугаар сарын 18, 19-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Ажлын хэсгээс хуулийн төслүүдийн талаар 32 санал, мөн УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн 3 саналыг боловсруулж, Байнгын хороогоор хэлэлцүүлсэн бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Одонтуяа гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг танилцуулъя. Пунцагийн Золзаяа Шүүхийн ерөнхий зөвлөл /ШЕЗ/-ийн дарга, Доржсүрэнгийн Мөнгөнтуул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Оюунбаатарын Оюунзул Хууль зүй, дотоод хэргийн яам /ХЗДХЯ/-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эрдэнэбаярын Баярбаясгалан Цагдаагийн ерөнхий газар /ЦЕГ/-ын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Батсайханы Тэнүүн

Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын Байгалийн шинжлэх ухааны шинжилгээний хэлтсийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийн эрхлэгч, Зоригийн Түвшинжаргал Гэр бүлийн бодлого судлаач, Батсуурийн Нарангэрэл Улсын бүртгэлийн ерөнхий газар /УБЕГ/-ын Иргэний бүртгэлийн газрын улсын ахлах байцаагч, улсын ахлах бүртгэгч, Бямба-Оюугийн Отгон УБЕГ-ын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч, Сэргэлэнгийн Солонго Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын харьяат хариуцсан ахлах мэргэжилтэн, Дамдинчойжилын Ундраа Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн гишүүн, Хүчирхийллийн үндэсний хорооны гишүүн. Энэ ажлын хэсгийн зарим гишүүд яагаад байхгүй байна? Нордогжавын Арвинтариа Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал, Алтангэрэлийн Батбаатар Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч.

Ажлын хэсгийн гишүүдэд хууль танилцуулъя. УИХ-ын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах ёстой. УИХ-ын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бүрэн гүйцэд хариулт өгөх ёстой. УИХ-д хүрэлцэн ирээгүй, асуултад худлаа хариулсан, буруу мэдээлэл өгсөн, дутуу хариулсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авдаг болохыг сануулъя. Та бүхэн үнэн зөв хариулаарай, УИХ-д хүндэтгэлтэй хандаарай. Ирэх ёстой ирээгүй гишүүдээ ирүүлээрэй.

Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Банзрагчийн Түвшингийн урилгаар Завхан аймгийн Улиастай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2005 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй сургуулийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя, алга байна. Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя, алга байна. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуултаа асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ Гэр бүлийн тухай хууль улс орны үндэс болсон маш чухал хууль гэж харж байгаа. Яагаад вэ гэвэл гэр бүл амгалан тайван байж нийгэм өөрөө амгалан тайван байдаг, гэр бүл тогтвортой байж нийгэм өөрөө сайхан тогтвортой хөгжиж, урагшилж, явдаг гэж боддог. Сүүлийн үед гэрлэлт буурч, салалт ихсэж байгаа явдал маш их санаа зовоож байна. Монгол Улс өөрийнхөө гэр бүлийн уламжлалтай, өөрийн гэсэн гэр бүлийн ийм үнэт зүйлийн үзэлтэй, ер нь гэр бүлээ гэсэн ийм хүмүүжилтэй ийм ард түмэн. Энэ утгаараа хүүхдийн дээд эрх ашиг гэдэг зүйлийг оруулж ирж, хүүхэд дээрээ төвлөрсөн, хүүхдийнхээ эрх ашгийг эрхэмлэсэн ийм хуулийн төсөл оруулж ирж байгаад миний бие энэ дээр дэмжиж байгаа.

Тэгэхдээ энэ дээр хэд хэдэн асуулт байгаа юм. 1 дүгээрт, гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч гэж энэ хуулийн 13.6, 13.5 дээр заасан байгаа. Тэгэхээр энэ ямар мэргэжил, эрх бүхий хүнийг ойлгох вэ гэдгийг асуумаар байна. Тэгээд шинжээчийг хэн нь сонгон шалгаруулаад, хэн нь томилоод, үйлчилгээний зардлыг нь хэн нь хариуцаад, дүгнэлтийг нь хэрхэн маргах талаар төсөлд тодорхой тусгасан байгаа юу гэдгийг 1 дүгээрт асууя? Ер нь улсын хэмжээнд ийм гэр бүлийн шинжээч шаардлагатай хэдэн хүн ийм шаардлагатай гэж гарч байна, ямар мэргэжлийн хүмүүсийг энд оруулж ирж ажиллуулах гэж байна, орон нутагт ийм шинжээч

хүрэлцээгүйгээс хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа удаашрах эрсдэлийг хэрхэн шийдвэрлэх вэ гэсэн энэ гэр бүлийн шинжээчийг тойрсон асуултууд байна.

2 дугаарт нь нууцлалын асуудал байгаа. Үрчлэлтийн нууцлалыг мэдэж байгаа албан тушаалтан бусад этгээдэд нууцлалыг хадгалах үүрэгтэй гэсэн ийм заалт 70.1 дээр байгаа. Гэхдээ энэ нь үрчлэлт, эрүүл мэндийн шинжилгээ, хүүхдийн сэтгэл зүйн үнэлгээ зэрэг эмзэг мэдээлэл агуулсан мэдээллийн санд ер нь хэрхэн нэвтрэх талаар ямар байдлаар зохицуулсан бэ? Мэдээллийг хэдэн жил хадгалдаг, хэзээ устгах, мэдээлэл задруулсан тохиолдолд ямар хариуцлага хүлээх вэ гэсэн ийм 2 дахь асуудал байна.

3-д нь ер нь хүүхдээс шүүх, цагдаа, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, шинжээч гээд тус тусдаа асуугаад яваад байвал хүүхдийг сэтгэл зүйн хувьд дарамтад оруулах, хохирол учруулах ийм магадлалтай. Тэгэхээрээ 1 асуудлаар олон дахин ярилцлага авах асуудлыг ер нь хэрхэн хязгаарласан бэ гэдгийг асууя? Тэгээд шинжээчийн дүгнэлт гэж байгаа, энэ шинжээчийн дүгнэлт нь цорын ганц үндэслэл болохгүй гэсэн баталгааг хэрхэн хангах вэ? Ингээд сонсож байгаад зөвхөн шинжээчийн дүгнэлтээр гараад эхэлбэл ямар байх вэ? Тэгээд талууд дүгнэлттэй хэрхэн танилцах, шинжээчид асуулт тавих, нэмэлт болон дахин үнэлгээ хийлгэх ийм дүгнэлтийг маргах эрхтэй байгаа юу гэдгийг асууя?

Тэгээд хамгийн эцэст нь би ганц тоо баримт хэлэхэд, жишээлбэл 2024 онд бол гэрлэлт, 2025 оны 1-ээс 5 дугаар сард жишээлбэл 5246 байгаа, ингээд энэ нь өмнөх оны өнөөгийн байдлаас 647-гоор буюу 11 хувь буурчихсан байна, 12 хувь бараг. Гэрлэлт цуцалсан нь болохоороо 2025 оны 1-ээс 5 дугаар сард 1962 байгаа, ингээд 2026 оны 1-ээс 5 дугаар сард 2072 болж, 110-аар буюу 5.6 хувиар өсчхөөд байгаа юм. Тэгэхээрээ ийм нөхцөл байдал дунд орж ирчхээд байгаа. Ийм учраас гэр бүлийн тогтвортой байдлыг хангах тал дээр хуулийн төсөлд хэрхэн тусгасан бэ? Зөвхөн шийтгээд байхдаа биш, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах тал дээр ямар зарчмын шинжтэй асуудлыг тусгасан бэ гэдэг хамгийн сүүлийнх нь асуулт болгож асууя. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Баасанжаргал хариулъя.

Х.Баасанжаргал: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Хүүхэд, гэр бүлийн шинжээч биш, мэргэжилтэн гэж бид ажлын хэсэг өөрчилсөн байгаа, хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн гээд. Энэ хүн өөрөө хаана ажиллах вэ гэхээр ШЕЗ-ийн захиргааны ажилтан байна. Тэгээд шүүх болгон дээрээ болж өгвөл нэг шүүгч дээр нэг хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн ажиллахаар тооцоолол, судалгаанууд гараад, хуулийн төсөлд тусгаад явж байгаа. Анх удаагаа манай энэ шүүх эрх мэдлийн тогтолцоонд хуульч биш өөр мэргэжлийн хүн буюу сэтгэл судлаач, социологич, нийгмийн ажлын мэргэжилтэй хүнийг шүүхийн энэ үйл ажиллагаанд оруулж ирж байгаа нэг ийм онцлог зохицуулалт байгаа. Хамгийн гол нь бид энэ тогтолцоог авч явахын тулд сая таны хэлээд байгаа тэр нууцлалыг хадгалах дүгнэлтийн асуудал гээд энэ зүйлүүдийг маш олон талаас нь бодож тооцоолж бусад улс орнуудын туршлагыг ч гэсэн харсан. Яг одоогийн практикт шүүгчид дандаа шинжээчийг гаднаас томилдог, гаднаас буюу хүүхэд гэр бүлийн газар луугаа, аймгийнхаа, дүүргийнхээ газар луу явуулдаг. Яг тэнд ажил хийж байгаа үндсэн нийгмийн ажилтнууд энэ ажлыг дандаа ажлынхаа хажуугаар хийдэг, үндсэн ажилд нь 1 дүгээрт ордоггүй, үүнтэй холбоотой хэрэг удаашрах, маш их хугацаа алдах, ийм дор хаяж 2-оос 3 сарын хугацаа алддаг ийм тохиолдол байгаа. Тийм учраас энийг бид

залруулаад, яг шүүхийнх нь өөрийнх нь үндсэн inspector, яг үндсэн хүүхэд гэр бүлийн мэргэжилтэн байхаар хуульд оруулж ирж байгаа, тогтолцооныхоо нэг хэсэг болгох юм гэж оруулж ирж байгаа юм.

2 дугаарт энэ мэргэжилтний гаргаж байгаа дүгнэлт өөрөө шүүгч энийг захирамжаараа ямар, ямар асуудлыг тодруулах юм, бүр өргөн хүрээнд гаргах юм уу, тодорхой асуудлын хүрээнд гаргах юм уу гэдгийг шүүгч энэ мэргэжлийн хүндээ чиглүүлэг өгнө. Ингээд мэргэжлийн хүний дүгнэлтийг харгалзаж шүүх шийдвэрээ гаргана гэж байгаа юм. Харгалзан үзнэ гэж байгаа юм. Ялангуяа энэ мэргэжлийн хүний дүгнэлт гаргах дээр бид хэд хэдэн ийм маш олон хувилбараар ажиллах боломжийг нээж өгсөн. Хүүхдийн сургууль, ангийн багштай уулзах, орчинд нь очиж ажиглалт явуулах, зөвхөн ярилцлагын аргаас бид татгалзаж байгаа. Одоогийн байгаа бидний уламжлалт арга голдуу дандаа ярилцлага хийх, хүүхдийн санал авах гэдэг ийм агуулгаар явж байгаа. Бид 7-гоос дээш насны хүүхдүүдийн саналыг нь авна, 7-гоос доош насны хүүхдийг маш олон нөхцөл байдал, бүх зүйлүүдийг тал бүрээс нь судалж үзэж байгаад, тэр байтугай хүүхдийн ганцхан аав ээжээс гадна эмээ, өвөө гэж хүмүүсийн оролцоо манай Монгол Улсын гэр бүлийн бүтцэд маш өндөр оролцоотой хүмүүс байдаг. Өвөө, эмээдээ ээнэгшсэн, дассан байдлыг хүртэл харгалзаж үзэж, хүүхэд гэр бүлийн мэргэжлийн хүн энэ дээр шүүгчид шийдвэр гаргахад нь тусалж, мэргэжлийн дүгнэлт гаргаж өгөх юм гэдэг ийм тайлбарыг хэлье. Дахин мэргэжлийн энэ дүгнэлт дээр гомдол гаргах эрх.../минут дуусав/

С.Бямбацогт: Наранбаяр гишүүн тодруулж асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Ямар ч байсан сэтгэл зүйч, яг энэ гэр бүл судлалын чиглэлийн ийм улсууд Шүүхийн ерөнхий зөвлөл дээр ажиллаад, төрийн үйлчилгээ илүү ойртох юм байна гэж ойлголоо. Мөн гэр бүл дэх тэр эмээ, өвөө нарын энэ оролцоо юмыг нэлээн нарийвчилж харж байгаа нь их сайн байна. Яагаад гэвэл энэ манай уламжлалт гэр бүлийн бүтэц. Эмээ, өвөө дээрээ хүүхдүүд их өсдөг, тэндээсээ уламжлалаа их сайн ойлгож авдаг, "ачтан буурал эмээ минь" гээд сайхан дуу хүртэл байдаг шүү дээ. Тэгэхээр энэ байдлыг харгалзаж байгаад би энэ дээр дэмжиж байна.

Тэгээд нөгөө хамтарсан асрамж гэсэн ойлголт байгаа. Энэ хамтарсан асрамжийг хэрэгжүүлэх ийм нарийвчилсан зохицуулалт энэ төсөлд хэрхэн туссан бэ? Хүүхдийн үндсэн оршин суух газар, сургууль, эмчилгээний янз бүрийн ийм зардлууд, амралтын хуваарь, гадаад зорчих шийдвэрийг эцэг эх хэрхэн гаргах тал дээр энэ ямар заалтууд орсон тухай тодруулж асууя?

С.Бямбацогт: Баасанжаргал гишүүн хариулъя.

Х.Баасанжаргал: Энэ хүүхдийн асрамжийн асуудлаар манай ажлын хэсэг нэлээн ярилцаад олон хувилбаруудыг судалж үзсэн. Яалт ч үгүй сая таны хэлж байгаа тэр хамтран асрах хувилбарыг бид судалж үзсэн. Гэхдээ өнгөрсөн хугацаанд бид дандаа хүүхдийн асрамжийг эцэг эхийн хэн нэгэн дээр нь шийдэх замаар, ээж нь юм уу аав нь тухайн хүүхдийн асрамжийг хариуцаж байгаа бол бүх үүрэг хариуцлага тухайн аав юм уу, ээжид нь оногддог байсан. Тэгээд энийг бид хамтын асрамжийн хэлбэр лүү биш хүүхдийн асрамжаас гадна хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрхийн асуудлаар, хүүхдээ эцэг эх нь, нөгөө хамт амьдраагүй эцэг эх нь, асрамжийг нь аваагүй эцэг эх нь хэрхэн яаж уулзах юм, ямар хуваариар уулзах юм гээд ингээд энэ бүх асуудлуудыг бид ийм нэг дараагийн түвшинд нь

аваачсан гэсэн үг. Хамтын асрамжийг бид яагаад энэ удаа бүр ингээд хамтын асрамж байдлаар оруулаагүй гэвэл энэ нь өөрөө олон улсад их олон маргаан дагуулж байгаа асуудал байгаад байгаа юм байна лээ. Тэгэхээр хүүхдийн асрамж хэн нэгэн дээр нь.../минут дуусав/

С.Бямбацогт: Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя, алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулах ёстой, санал хураалтуудыг нэгтгээд 16 цагт явуулъя. Зарчмын зөрүүтэй 35 санал байгаа.

11.26 цаг

Зочин танилцуулъя. Увс аймгийн Давст сумын ЕБС-ийн 1996 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 30 жилийн ойг тэмдэглэж байгаа, Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Сайхан баярлаарай.

Долоо.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Буяагийн Тулга танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Тулга: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ-ын 2026 оны 6 дугаар сарын 18, 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт заасны дагуу хууль тогтоомж хоорондын уялдааг хангах зорилгоор боловсруулсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 52.9 хувиар дэмжсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хэвээр адилхан байгаа. Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя, алга байна. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя, алга байна. Ариунзаяа гишүүн асуултаа болилоо. Өлзийхүү Шижир гишүүн алга байна. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуултаа асууя, больсон гэнэ. Отгоны Саранчулуун гишүүн больсон. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг хойшлуулаад 16 цагаас явуулна.

11.29 цаг

Найм.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Да.Цогтбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2026 оны 6 дугаар сарын 18, 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт заасны дагуу хууль тогтоомж хоорондын уялдааг хангах зорилгоор боловсруулсан Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 52.9 хувиар дэмжсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан

талаар ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг хэвээрээ түрүүний ажлын хэсэг. Гэр бүлийн хуулийг дагаж хуулиудад нэмэлт, өөрчлөлт орох ёстой байгаа, гишүүд асуулт асууна. Батын Батбаатар гишүүн алга байна, Баатаржавын Мөнхсоёл гишүүн алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байна уу. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа, ер нь маш олон хуульд өөрчлөлт оруулж байгаа. Би зүгээр зарчмын хувьд нэг хэдэн зүйл асуух гэсэн юм. Ер нь энэ хуулиар гэр бүл болох, нэгэнт бий болгосон гэр бүлээ хамгаалах, гэр бүл салах гэсэн ийм 3 үе шат болгон дээр сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэцийн эрүүл мэндийн оролцоо эсвэл сэтгэл зүйн үйлчилгээ, сэтгэл зүйчийн оролцоо зэрэг асуудлууд нь ер нь хэр тусгагдаж, хуучин байснаасаа хэр сайжирсан юм бэ? Энэ тал дээр мэдээлэл өгөөч.

Яах вэ бид ингээд хуулийн процессыг харахаар яг тэр гэр бүл салах, салсны дараа харилцаатай холбоотой хариуцлага энэ тэрийг нэлээн их ярьж байна шүү дээ. Ер нь гэр бүлийн шүүхийн тухай асуудал дээр ч гэсэн яг гэр бүл болохтой холбоотой, гэр бүл болохын өмнөх хариуцлагатай холбоотой, хүүхэдтэй болох хариуцлагатай холбоотой, энэ дээр чинь бүгд дээр нь хүний сэтгэл зүйн төлөвшил, сэтгэл зүйн боловсрол, сэтгэл зүйн суурь асуудлууд хөндөгдөж байгаа байхгүй юу. Тэгэхээр хуучнаасаа ер нь ямар байсан зүйлийг ямар болгож сайжруулж байгаа талаар саяын яг үе шат болгон дээр тайлбарлаж өгөөч? Тэгээд дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг хариулах уу? Баасанжаргал хариулах уу? Оюунзул ХЗДХЯ хариулъя, индрийн 3 дугаар микрофон.

О.Оюунзул: ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Оюунзул. Хуулийн төслөөр сэтгэл зүйч гэрлэлт цуцлах маргаан дээр иргэний хэрэг үүсгэхээс өмнө заавал эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулж байгаа. Энэ хүрээнд сэтгэл зүйч оролцох боломжийг хуульчилж өгсөн. Мөн дээрээс нь Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг дагаж байгаа энэ тогтоолоор энэ сэтгэл зүйчийн орон тоог баталгаажуулж өгөөд, тэгээд аймаг болгонд бүхий л орон нутгийн болгонд 1, 1 сэтгэл зүйч байхаар орон тоог нь оруулж өгсөн байгаа. Тэгээд энэ сэтгэл зүйч маань гэрлэлт цуцлах маргаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаанд урьдчилсан арга хэмжээнд оролцоно. Мөн дээрээс нь бид Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүхийн шатад эвлэрүүлэн зуучлах ийм баг ажиллахаар хуульчилж өгсөн. Энэ хүрээнд энэ багт нь энэ сэтгэл зүйч маань орж ажиллахаар байгаа.

С.Бямбацогт: Нэмж хариулъя. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Саранчулуун гишүүний асуултыг ойлгохдоо нөгөө анхнаасаа гэрлэлтээ бүртгүүлэхээс эхлээд яг нөгөө гэр бүлийн үндсэн харилцаанд яг сэтгэл зүйчийн оролцоо хэр байгаа вэ гэдэг ийм агуулгаар асууж байна гэж ойлголоо. Тэгээд энэ хууль дээр бид гэр бүлийн сэтгэл зүйч сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг, туслалцаа авах талаар ерөнхий зарчмын заалтууд орсон. Яг хэзээ, ямар байдлаар, ямар төрийн үйлчилгээтэй холбогдож орох вэ гэдэг нь Гэр бүлийг дэмжих

тухай хуулийн төсөл буюу Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яамнаас өргөн барьж байгаа тэр төслөөр үндсэн харилцааг зохицуулах буюу процессын харилцаа илүү тэр хуулийн төсөл дээр орно гэдэг ийм зүйлийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны өргөн барьж байгаа төсөл дээр байгаа. Энэ төсөл болохоор ХЗДХЯ-наас өргөн барьж байгаа буюу яг үндсэн гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулж байгаа ийм хууль зүйн үр дагавартай ийм хууль байгаа.

С.Бямбацогт: Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Тийм. Тэгэхлээр хүмүүс ойлгохдоо энэ Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэлээр хүмүүс гэрлэхдээ гэрээ хийх тухай асуудал хөндөгдөж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ нь яг хаана нь орж байгаа юм бэ? Тэр гэрээнийх нь эрх зүй болон чадал нь ямаршуу байх юм, одоо гэрлэхихсэн байгаа хүмүүст энэ ямар өөрчлөлтийг бий болгох юм бэ? Гэрлэхийг хүлээж байгаа хүмүүс жишээлбэл энэ хуулийн дараа ямар, ямар шинэ зүйлүүдийг хийх ёстой болох вэ гэдэг дээр мэдээлэл, ямар өөрчлөлтүүд байгаа талаар мэдээлэл өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя, 3 дугаар микрофон.

О.Оюунзул: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Гэрлэлтийн гэрээтэй холбоотойгоор асуулт байгаа. Гэрлэлтийн гэрээгээр яг одоогийн хууль тогтоомжоор эд хөрөнгийн тохиролцоогоо Иргэний хуулиар нэрлэгдээгүй гэрээ байдлаар хийх боломжтой байгаа. Энэ маань цоо шинэ зүйл биш. Гэхдээ хуулийн төсөл дээр илүү гэрлэлтийн гэрээ гэж нэрлэж өгөөд, яг энэ гэрлэлтийн гэрээндээ гэрлэгчдийн эд хөрөнгийн асуудлыг гэрлэлт цуцлахтай холбоотойгоор заавал шүүхэд хууль хэрэглэж маргаан үүсгэхээс нь өмнө урьдчилан сэргийлж тохиролцох тэр боломжийг нь тусгахаар оруулж өгсөн байгаа. Энд маань үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой жишээлбэл гэрлэлтийн гэрээн дээр тусгавал эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд энэ урьдчилсан тэмдэглэгээг хийгээд бүртгэлд нь ингээд яг тэр тохиролцсон хөрөнгө дээр яг энэ гэрлэлтийн гэрээгээр ингэж тохиролцоно шүү гэдэг дээр ингээд бүртгэл хийж нэг нь дур мэдэж захиран зарцуулахгүй байх.../минут дуусав/

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 11 цаг 36 минутаас хуралдааныг даргалав.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн нэмж хариулъя.

П.Сайнзориг: Манай Саранчулуун гишүүн нөгөө иргэд, олон нийтэд зөв мэдээлэл өгье гэдэг үүднээс асуугаад байх шиг байна. Энэ дээр мэдээж 4 дүгээр бүлэг дээр маш том тодорхой зохицуулалтууд нарийвчилж орж байгаа. Ер нь гэрээний харилцаа талуудын сайн дурын үндсэн дээр явагдана. Эхнэр нөхөр сайн дурын үндсэн дээр энэ гэрээгээ байгуулна, заавал гэсэн үг биш. Гэрлэсний дараа болон хэдийд ч энэ гэрээний асуудлыг харилцан тохиролцож байгуулж болно. Бид өмнөх хуулиудаас агуулгыг нэлээн нарийвчилж өгсөн. Гэрлэгчдийн байнга оршин суугаа, амьдарч байгаа орон байрнаас бусад гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөгч дундын эд хөрөнгийн эрх үүргийг яаж хуваарилах вэ, гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгийг тодорхойлох, гэрлэлт дуусгавар болсны дараах гэр бүлийн гишүүдэд ногдох эд хөрөнгийн эрх болон хамтран эзэмших өмчлөх дундын эд хөрөнгийг шилжүүлэх, хамтран өмчлөх, эсхүл хуульд заасан бусад нөхцөлөө

тогтоох, гэр бүлийн хэрэгцээний зардлыг хуваарилах гэх мэт энэ асуудлуудыг тусгаж болно. Бусад.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Нэмж тодруулъя. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Гэрээнд эд хөрөнгийн асуудлууд нэлээн ойлгомжтой тусаж байгаа юм гэж ойлголоо. Би дахиад нэг зүйл тодруулъя. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээж аав гэрлэлээ гэж бодъё эсвэл гэртээ ямар нэгэн хүн асардаг хүн хүнтэй гэрлэлээ гэж бодоход энэ дээр нөгөө салахад чинь нөгөө асрах тухай асуудал яриад байгаа шүү дээ. Тэтгэмжийн асуудал ярьж байгаа шүү дээ. Тэгвэл гэрээн дээр энэ тухай ер нь дурдаж хөндсөн ийм агуулга энэ тэр байх юм уу, гэрээний тийм жишиг загвар байх юм уу, яг яах юм гэдэг дээр мэдээлэл өгөөч?

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Гэрлэгчдийн гэрээний асуудал гэрээний үүрэг үүсэж байна. Гэвэл яг таны асууж байгаа энэ асрах гэдэг юм уу, тодорхой кэйс дээр асууж байна. Энэ хууль зүйн үүрэг, энэ гэрээнд тусгаж энэ эрх үүргийг хязгаарладаг, эсвэл чи ингэнэ шүү, тэгнэ шүү гэж урьдчилан тохирдог зүйл байхгүй. Тодорхой кэйс ба кэйсийн онцлогоос шалтгаалж болно. Ер нь эцсийн дүндээ шүүхээр шийдвэрлүүлэх энэ нөхцөл байдал руугаа орно. Тэгээд энэ хууль зүйн эрх учраас гэрээгээр зохицуулдаг харилцаа биш. Энийгээ тодорхой хэмжээнд ээж аав, эцэг эх, асран хамгаалах харгалзан дэмжигчид тодорхой гэр бүлийн тэр онцлог, эргээд энэ хүүхдийн насны онцлогоос эхлээд л болон эрүүл мэндийн онцлог шалтгаанаас эхлээд бүх зүйлүүдийг тодорхой зохицуулж өгсөн байж байгаа харгалзаж үзэх нөхцөлүүдийг.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Увс аймгийн Цагаанхайрхан сумын ЕБС-ийн 1996 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөгчдөдөө эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Сайхан баярлаарай та бүхэн маань сайн сайхныг хүсье. Баасанжаргал гишүүн нэмж хариулъя.

Х.Баасанжаргал: Саранчулуун гишүүний яг асуугаад байгаа асуултад нэг зүйлийг аягүй тодорхой хариулъя. Яг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй юм уу яг ийм асаргааны хүнийг хэрвээ хүнтэй гэр бүлийн гишүүн нь ийм асаргааны байгаа тохиолдолд нэг зүйл орж ирсэн. Тэтгэмжээс гадна зардлын асуудлыг бид шийдэхээр Гэр бүлийн хууль болоод Гэр бүлийн процессын хуульд аль алин дээр нь орсон байгаа. Ялангуяа гэрлэлтийн гэрээтэй холбож тайлбарлавал гэрлэгчид бие биеэ насанд хүрээгүй болон сургуульд сурч байгаа 18-аас 21 хүртэл насны, эсхүл хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх сурах эрхийг хангах үүргээс чөлөөлсөн, эсхүл хязгаарласан ийм төрлийн гэрээ 1 дүгээрт байгуулж болохгүй.

2 дугаарт Гэр бүлийн тухай хууль дээр орж байгаа нэг чухал заалт юу вэ гэвэл энэ тэтгэмжийн хэмжээг зөвхөн амьжиргааны доод түвшний хэмжээгээр тогтоохгүй, тухайн тэтгэмж авч байгаа хүүхдийн хэрэгцээ шаардлага, онцлогийг харгалзана, зардлыг харгалзана, тэтгэлэг төлөгчийн орлогыг харгалзана, тэтгэлэг төлөгч хэчнээн хүний тэтгэлгийг төлдөг юм бэ гээд энэ бүх нарийн зүйлийг харгалзаж үзэж байж, Засгийн газар.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооны гаргасан саналын горимын саналаар санал хураалгах ёстой, санал хураалтыг 14 цагт явуулна, 16 цагт явуулна.

11.42 цаг

Ес.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Баярбаатар таныг индэрт урьж байна.

Б.Баярбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2026 оны 6 сарын 18, 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2026 оны 6 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт заасны дагуу хууль тогтоомж хоорондын уялдааг хангах зорилгоор боловсруулсан ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.8 хувиар дэмжсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ байгаа. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн саналын нэрсийн дагуу асуулт асууна. Эрдэнэболд гишүүн алга байна, Банзрагчийн Түвшин гишүүн алга байна, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн алга байна, Батын Батбаатар гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж дууслаа. Байнгын хорооны гаргасан саналаар горимын саналаар санал хураах ёстой, санал хураалтыг 16 цагт хураана.

11.45 цаг

Арав.Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Сайнзориг гишүүнийг индэрт урьж байна.

П.Сайнзориг: УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2026 оны 6 дугаар сарын 18, 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт заасны дагуу хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор боловсруулсан ЭХХШТХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслөөр зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.8 хувиар дэмжсэн болно.

УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдон боловсруулсан ЭХХШТХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Зочин танилцуулъя. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын ЕБС-ийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөгчид та бүхэнд, багш, төгсөгчид та бүхэндээ УИХ-ын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүний танилцуулснаар хэвээрээ байгаа. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна, нэрсийг өгсөн байна. Энэ дэлгэц дээр нэрс гарч ирэхгүй байгаад байна шүү, хүмүүсээ. Эрдэнэболд гишүүн алга байна, Батын Батбаатар гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж дууслаа. Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулах ёстой, санал хураалтыг 16 цагаас явуулна.

11.48 цаг

Арван нэг.Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Эцэг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Мөнхтөрийн Нарантуяа-Нара танилцуулна. Нарантуяа-Нара таныг индэрт урьж байна.

М.Нарантуяа-Нара: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2026 оны 6 дугаар сарын 18, 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт заасны дагуу хууль тогтоомж хоорондын уялдааг хангах зорилгоор боловсруулсан Эцэг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.8 хувиар дэмжсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Эцэг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ байгаа. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Эрдэнэболд гишүүн алга байна, Дамдины Жаргалсайхан гишүүн алга байна, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж дууслаа. Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулах ёстой, санал хураалтыг 16 цагт явуулна.

11.52 цаг

Арван хоёр.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна. Баасанжаргал гишүүн танилцуулна, Баасанжаргал гишүүнийг индэрт урьж байна.

Х.Баасанжаргал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ-ын 2026 оны 6 сарын 18, 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2026 оны 6 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт заасны дагуу хууль тогтоомж хоорондын уялдааг хангах зорилгоор боловсруулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 56.3 хувь дэмжсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өөрчлөгдөөгүй хэвээрээ байгаа. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батбаатар гишүүнээр тасалж байна. Батын Батбаатар гишүүн алга байна. УИХ-ын гишүүд асуулт асууж дууслаа. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Хуулийн төсөл санаачлагчаас буюу яамнаас энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах яг энэ заалтыг өргөн мэдүүлээгүй. Гэхдээ ажлын хэсгээрээ ярьж байгаад бид ямар зохицуулалт орсон бэ гэвэл хүүхдийн тэтгэлэг төлөх үүргээ 3 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй бол зээлийн мэдээллийн санд энэ мэдээллийг нь нийлүүлэх ийм зохицуулалт орж байгаа. Тэгээд би энэ мэдээллийг зориуд олон нийтэд мэдээлэх нь зөв байх. Энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш энэ мэдээлэл орно. Тэгээд цаашид энэ нь

өөрөө зээл авах тохиолдолд зээл авагчийн өөрийнх нь санхүүгийн сахилга бат оноонд нь энэ өөрөө нөлөөлөх болно. Тийм учраас энэ дээр эцэг эхчүүд хариуцлагатай байх шаардлага үүсэж байгаа шүү гэдгийг хэлэх нь зөв байх.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. УИХ-ын гишүүд асуулт асууж дууслаа. Зочин танилцуулъя. Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын ЕБС-ийн 1996 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ УИХ-ын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Байнгын хорооны гаргасан саналын горимын саналаар санал хураалт явах ёстой, санал хураалтыг 16 цагт явуулна.

11.55 цаг

Арван гурав.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа орьё. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг УИХ-ын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна. Баасанжаргал гишүүнийг индэрт урьж байна.

Х.Баасанжаргал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ-ын 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа. УИХ-ын 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 2 саналаар болон хуулийн төслийн зарим зүйлээр дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан нэг саналаар тус тус санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төслүүдийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд болон хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Батаагийн Батцэрэн Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах ШЕЗ-ийн гишүүн, Лхагвадоржийн Энхбилэг Багахангай, Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, Нямдоржийн Оюунтуул дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, Отгонбаярын Мөнхбаатар Улсын ерөнхий прокурорын Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга, Гантөмөрийн Эрдэнэ УЕПГ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, ахлах прокурор, Доржсүрэнгийн Мөнгөнтуул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Оюунбаатарын Оюунзул ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарсүрэнгийн Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Эрдэнэбаярын Баярбаясгалан ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Батсуурийн Нарангэрэл УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч, Бямба-Оюугийн Отгон УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч, Очирбатын Амарсанаа Олон улсын Улаанбаатар Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, доктор, дэд профессор, Нордогжавын Ариунтуяа Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал. Энэ хүмүүс чинь тэгээд цөөхөн хүмүүс байна шүү дээ. Аль нь Алтангэрэлийн Батбаатар Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч.

Монгол УИХ-ын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй, 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ гэсэн хуулийн заалтыг та бүхэнд танилцуулж байна.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Зочин танилцуулъя. Увс аймгийн Бөхмөрөн сумын ЕБС-ийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөгчид та бүхэндээ УИХ-ын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. УИХ-ын гишүүдийн нэрсийг өгье. Эрдэнэболд гишүүн алга байна. УИХ-ын гишүүд асуулт асууж дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулах ёстой, зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураах санал хураалтыг 16 цагт үргэлжлүүлнэ.

12.03 цаг

Арван дөрөв.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Одсүрэнгийн, Одонтуяа гишүүн танилцуулна.

С.Одонтуяа: УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй тул ХЗБХ-ны дарга Цогтбаатар Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Салдангийн Одонтуяа гишүүн танд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ байгаа. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн саналын нэрсийн дагуу асуулт асууна. Эрдэнэболд гишүүн байна, Эрдэнэболд гишүүн алга байна. Ингээд гишүүд

асуулт асууж дууслаа. Байнгын хорооны гаргасан горимын саналын дагуу санал хураалт явуулна. Санал хураалтыг 16 цагт явуулна.

12.06 цаг

Арван тав.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Салдангийн Одонтуяа гишүүн танилцуулна. Одонтуяа гишүүнийг урьж байна.

С.Одонтуяа: УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй тул ХЗБХ-ны дарга Д.Цогтбаатар Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Зочин танилцуулъя. Төмөр замын их сургуулийн төмөр зам, замын аж ахуйн инженерийн ангийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа төгсөгчид та бүхэндээ ажил үйлс, амьдрал нь ган зам шигээ өөдрөг байх өлзийтэй ерөөлийг дэвшүүлье.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авна. Батын Батбаатар гишүүн нэрээ өгсөн байна. Батбаатар гишүүн алга байна. УИХ-ын гишүүд асуулт асууж дууслаа. Тайлбар хэлэх үү? Баасанжаргал гишүүн. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Цагдаагийн албаны тухай хуульд орж байгаа энэ нэмэлт, өөрчлөлтийн гол үр дагавар нь ямар зохицуулалт орж байгаа вэ гэдгийг товчхон иргэдэд мэдээлэл болгоод тайлбарлах нь зүйтэй байх.

Урьд нь ял шийтгэл үйлдэж байсан уу гэдэг лавлагааг бид авдаг, олон байгууллагууд энэ лавлагааг "чи өөрөө яваад аваад ир" гэж хүмүүсээр өөрсдөөр нь энэ лавлагааг авхуулдаг. И-Монголиа дээр байршуулчихсан байдаг. Тэгэхээр энэ удаа хүүхэд байхдаа үйлдсэн гэмт хэргийн талаарх ийм мэдээлэл, ийм лавлагааг өөрт нь хүртэл харагдахгүй байдлаар техникийн зохицуулалт орж байгаа. Өөрөөр хэлбэл хүүхэд байхдаа үйлдсэн тэр гэмт хэргийнх нь хариуцлагыг тэр хүүхэд үүрчихсэн байгаа, тэрний үр дагавар нь насан туршид нь энэ хүүхдийн эрх зүйн байдлыг дордуулж болохгүй гэдэг агуулгаар нь манай ажлын хэсэг ярилцаад яг энэ Цагдаагийн албаны тухай хуульд ийм техникийн зохицуулалтыг нь өөрчлөхөөр, энэ лавлагаа мэдээлэл авах боломжгүй байдлаар техникийн зохицуулалтыг тусгасан байгаа. Харин тагнуул болон цагдаагийн байгууллага ч гэдэг юм уу өөр яг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бол мэдээж энэ лавлагаа авах боломж нь нээлттэй байгаа гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулна. Санал хураалтыг 16 цагт явуулна.

12.10 цаг

Арван зургаа.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг УИХ-ын гишүүн хэн танилцуулах вэ? Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн танилцуулна. Баасанжаргал гишүүнийг индэрт урьж байна.

Х.Баасанжаргал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа. УИХ-ын 2026 оны 6 сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн үүрэг, гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан нэг саналаар санал хураалт явуулахаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төслүүдийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Саранчулууны урилгаар "Тэгш Нийгэм Холбоо" ТББ-ын болон Бие бялдар сэргээн засах Монголын нийгэмлэгийн ажилтнууд УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ УИХ-ын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал, ажил үйлс нь өөдрөг байх өлзийтэй сайхан ерөөлийг өргөн дэвшүүлъя.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн нэрээ өгсөн байна. Эрдэнэболд гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулах ёстой, санал хураалтыг 16 цагт явуулна.

12.14 цаг

Үдээс өмнөх хуралдаан дууссан тул чуулганыг 14 цаг хүртэл завсарлуулж байна. 14 цагаас асуулгын цаг эхэлнэ. 14 цаг хүртэл чуулганы хуралдаан завсарлаж байна.

*2026 оны 06 дугаар сарын 26, Баасан гараг,
Төрийн ордон "Их хуралдай" танхим
14 цаг 02 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Үдээс хойших хуралдаанаа эхэлье. Улсын Их Хурлын асуулгын цаг байгаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Арван долоо.Улсын Их Хурлын асуулгын цаг

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.1-д ээлжит чуулганы хугацаанд сар бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаан гишүүдээс Ерөнхий сайдад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүү, төлөв байдал болон бусад асуудлаар асуулт тавих УИХ-ын асуулгын цаг байна гэж заасан.

УИХ-ын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах УИХ-ын асуулгын цаг эхэлж байна. УИХ дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал нарыг индэрт урьж байна. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.6-д заасны дагуу УИХ дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн асуултыг тавьж, мэтгэлцэнэ. Бүлгийн цуварсан асуултын тоог 9-с хэтрүүлэхгүй,

асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй. Асуултаа тавьж мэтгэлцээнээ эхлүүлье.

О.Цогтгэрэл: Та бүхэнд үдээс хойшийн мэндийг хүргэе. Өнөөдрийн асуулга мэтгэлцээний сэдэв нийгмийн хамгаалал ба нийтийн халамж гэдэг сэдэв. Энэ сэдэв үнэхээр өнөөдөр Монгол Улсад үнэхээр тулгамдсан шийдэх ёстой, шийдэхээс гадна энэ дээр асуудал ил тод болох ёстой ийм чухал сэдэв гэж үзэж байгаа. Улс орон гэдэг чинь өөрөө хөдөлмөрлөдөг, бүтээдэг, ирээдүйдээ итгэж байгаа, эрсдэлээс хамгаалагдаж байгаа тэр иргэд зайлшгүй төрийн хамгаалалтад орж, бие даан ажиллаж амьдрах боломжгүй иргэдээ хэрхэн хамгаалах вэ гэдэг энэ 2 том бүлэг иргэдээс буюу нийгмийн хамгааллаас халамжийн тогтолцооноос асуудал хамаарах ёстой гэж үзэж байгаа.

Гэтэл сүүлийн жилүүдийн нөхцөл байдлыг харахад нийгмийн хамгаалал гэдэг ойлголт энэ өөрөө нийтийн халамж болж хувираад санаатай юу, санамсаргүй юу, зориудаар юу мэдээд үү, мэдэхгүйгээр үү ямар ч байсан бүх зүйл буруугаар эргэсэн ийм нөхцөл байдал бий болчихлоо. Тэгэхээр яг халамжийн тогтолцоо гэдэг бие даан амьдрах чадваргүй иргэдэд төрөөс тодорхой бодлого чиглүүлж ажиллах ёстой, хамгаалал гэдэг эрсдэлээс хамгаалсан илүү даатгалын шинжтэй эдийн засгийн арга механизмууд энд орсон энэ тогтолцоо байх ёстой. Тэгтэл яг энэ тогтолцоо, энэ үйл ажиллагаа олон улсад байдаг энэ жишиг энэ ийм харамсалтай нөхцөл байдалд өнөөдөр ялгаагүй ялгах боломжгүй ийм нөхцөл байдалд орсныг та бүхэн мэдэж байгаа юу? Энийг бүр тэр тусмаа энэ нь өөрөө улс төрийн арга хэрэгсэл болж хувирсан гэдэгтэй та санал нийлж байна уу? Нэгдэж байна уу?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: ЗГ-ын чөлөөлье гэдэг санаачилга ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх гэж байгаа. Ажил эрхлэлтийг өндөр байлгаж байгаа зорилготой ажил эрхлэлт өндөр байгаа тохиолдолд хөдөлмөрийн орлого өндөр байдаг, хөдөлмөрийн орлого өндөр байвал дотооддоо үйлдвэрлэж байгаа нийт бүтээгдэхүүн өсдөг. Энэ замаар иргэн болгон, өрх болгонд энэ эдийн засгийн өсөлт хангагдах ийм суурь зарчимтай. Гэтэл өнгөрсөн хугацаанд бидэнд нийгмийн хамгаалал энэ халамж 2-ыг 1 саванд хийчхээд яваад байсан. Би үүнтэй санал нэгдэж байна. Тийм учраас би танд хэлэхэд энэ асуудлыг шийдэхийн тулд энэ чөлөөлье гэдэг санаачилга дэвшүүлсэн. Энэ санаачилга өөрөө тэр эдийн засгийн өсөлтийг болоод ДНБ /GDP/-ийн өсөлтийг өрх рүү хүргэх зорилготой буюу ажил эрхлэлт өндөр байх руу чиглэж байгаа юм.

Нийгмийн хамгаалал гэдэг амьдралын аль нэг мөчлөгт хүнд тохиолдож болох эдийн засаг, нийгмийн эрсдэлээс хамгаалах бодлого байдаг. Нийтийн, нийгмийн халамж өөрөө юу вэ гэхээр нийгмийн хамгааллын өөрөө нэг бүрэлдэхүүн хэсэг, хүн амын ядуурал, эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн ийм тусгай бодлого. Гэтэл өнөөдөр халамж өндөр байна гээд ярьдаг, яг халамж өндөр байна уу гээд харахаар бил жилд 2.4 их наядын энэ нийгмийн хамгаалал, халамж 2-ыг 1 саванд хийчхээд иргэддээ хүргэж байгаа юм. Энэний чинь бараг 1.5-аас 1.7 их наяд нь зөвхөн хүүхдийн мөнгө, 1.7 их наяд хүртэлх тэр олгож байгаа тэр халамж, хамгаалал чинь өөрөө зөвхөн тэр нөгөө хүн амыг өсгөх бодлого руу чиглээд байдаг. Тэгэхээр нийгмийн хамгаалал, халамж хоёроо салгаж ойлгох ёстой. Нийгмийн халамж өөрөө хамгааллаасаа тусдаа. Тэгэхээр Нийгмийн халамжийн хууль, Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг ЗГ Их Хурал руу хүргүүлсэн. Энэ юу вэ гэхээр нийгмийн

халамжийг нийгмийн хамгааллаас нь салгаж харъя гэдэг зорилттойгоор бодлогоо чиглүүлж байгаа.

О.Цогтгэрэл: Тэгэхээр яг бодитой байгаа ганц 2 тоонуудыг ярьж л даа. Монгол Улс 3.6 сая иргэнтэй. Энэнээс хөдөлмөрийн насны 2.2 сая, 2.3 сая иргэд байна. Энэ тоонуудыг ингээд харахаар хүүхэд орохгүйгээр наад халамжид хүүхэд орохгүйгээр, хүүхдээс гадна 1 сая иргэн халамжид ямар нэгэн хэмжээгээр хамрагдаж байна. Тэгээд та бод доо 2.2 сая насанд хүрсэн иргэнээс үндсэндээ ажиллах хүчинд 1.2 сая нь байгаа. Гэтэл хүүхдээс, хүүхдийг хасвал хүүхдийн мөнгийг хасвал цаана нь 1 сая шахам иргэн ямар нэгэн хэмжээгээр энэ улс орон халамжид хамрагдаж байна. Мөнгөн дүнг нь орхиё, 2.5 их наяд орчим мөнгөн дүн бүхий халамжийн хөтөлбөр энд явж байгаа. Тэгэхээр Монгол Улсыг ажил хийж хөдөлмөрлөж байгаа иргэд, халамж авч байгаа иргэд, би энэ саяын тоонд чинь нийгмийн хамгаалал ороогүй тоо. Тэгэхээр энэ тоо үнэхээр та бүхэн энэ тоонуудаа яг ойлгож байгаа юу, мэдэж байгаа юу? Дахиад давтаад хэлэхэд хүүхэд орохгүйгээр 1 сая 290 мянга орчим байна уу тэтгэмж авч байгаа хүүхэд орохгүйгээр энэнээс тусдаа 1 сая иргэн ямар нэгэн хэмжээгээр халамж авч байна. Энэ халамж авч байгаа мөнгө нь нийт дүн нь 2.5 их наяд.

Гэтэл энэ мөнгөн дүнгийнх нь нийт хэмжээг харьцуулаад харвал сая бид татварын хууль дээр бөөн маргаан болж эхэлдэг. Хүн амын орлогын албан татварт Монголчууд 2.7 их наядыг төлж байна. Яг ажил хөдөлмөр хийж байгаа иргэдээс авсан 2.7 их наяд төгрөгийн хэмжээтэй мөнгийг халамжид бид, хамгаалалд биш шүү халамжид, дахиад энэ халамж гэдгийн чинь цаана ороогүй, халамжийн данс нь бичигдээгүй мөртөө халамжийн шинжтэй бид асар их хөтөлбөрийг энэ улс оронд зарцуулж байна. Тэгээд энэний энэ өөрчлөлт, шинэчлэлийн ажил энэ.../үг тасрав/

Н.Учрал: Та нийгмийн хамгаалал, халамж 2-ыг ялгаж байна уу гэдэг асуултыг би танаас асуумаар байна. Нийгмийн хамгаалал гэдэг амьдралын мөчлөгт хүнд тохиолдож болзошгүй асуудал дээр, тэр нийгмийн эмзэг бүлэг дээрээс нь тэр ядуурлаас хамгаалах бодлого. Нийгмийн халамж гэхээр энэ өөр ойлголт. Нийгмийн халамж өөрөө нийгмийн хамгааллын нэг бүрэлдэхүүн хэсэг. Энэ тусгай бодлого байдаг. Тэр ядуурлыг бууруулахад зориулсан тусгай бодлого. 2.4 их наяд чинь нийгмийн халамж, хамгаалалд зарцуулагдаж байгаагийн чинь 72 хувь нь өөрөө хүн амаа өсгөх бодлого. 1.7 их наяд чинь хүүхэд, эхэд олгогдож байгаа зорилтот хөтөлбөр. Тэгэхээр бид хэнийг халамж гэж ойлгоод яваад байсан, эцэстээ 10 гаруй жилийн дотор хүн ам 400 мянгаар өсчихсөн. Тэгэхээр энийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль руу оруулаад, энэ хөтөлбөр буюу энэ чинь эксит стратегитай /exit strategy/ байгаад хэзээ дуусах вэ гэдгийг нь томъёолъё гэдэг ийм зорилттойгоор концепцыг нь углуургаар нь бид ингэж харж байгаа юм.

Тэрнээс биш өнөөдөр нийтээрээ халамжид өртчихлөө гээд байдаг. Яг үнэндээ энэ 2.4 их наядын чинь 1.7 нь эх, хүүхдэд. Үлдсэн нь өөрөө яг нөгөө тусгай бодлого хэрэгжүүлээд яваад байдаг. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээрээ гарна, хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээр очиж байгаа халамж чинь хөдөлмөрийн чадварынхаа хэдэн хувийг алдсаныг нь бүрэн тооцож чадахгүй болоод байдаг. Дээрээс нь үйлдлийн чадамж буюу ямар үйлдлийг хийж чадахгүй байгаа вэ гэдгийг нь тооцох буюу тэр ICF аргачлалын дагуу бид энийг зохион байгуулъя гээд энэ 2-ыг салгаж байгаа. Ингэж байж углуургаар нь харахгүй бол халамж хавтгайрлаа, халамж хавтгайрлаа гээд байгаа яг тусгай тэр зорилтот бүлэгт хэзээ хүрч байгаа юм, тэр хүнийг хэзээ ядуурлаас аварч байгаа юм, яг хэзээ тэр хүнийг ажлын байран

дээр бэлтгэж байгаа юм гэдэг нь тодорхойгүй байгаа учраас сонгуулийн циклүүдийн өмнө дандаа ингэж нэг тийм хайр зарлаж, найр тавьсаар байгаад энэ тогтолцоог эвдээд хаячихсан. Би энэ тогтолцоог засахын тулд ЗГ 3 хууль оруулж ирээд хэлэлцүүлж байна.

О.Цогтгэрэл: Харин та бүхэн нийгмийн хамгааллыг нийтийн халамж болгож холион бантан болгоод хутгаад энийг ард иргэд нь ядуурлаас гардаггүй энэ нь өөрөө эрх баригч намд, МАН-д улс төрийн асар том бааз суурь болгодог энэ тогтолцоог та нар авч явсныгаа би өнгөрсөн хугацааны бодлого руу, өмнөх Засгийн газрууд руугаа таныг бухаж энийг хүлээн зөвшөөрч байна гэж ойлгож байна. Энийг өөрчлөхийн төлөө байна гэж илэрхийлж байна гэж ойлгож байна. Яг бид бүгдийн барьж байгаа халамж хамгаалал 2-ын зааг ялгааны бодлого зорилтот хэсэгтээ, тодорхой цөөн хэсэгтээ халамжаа өгдөг, халамжийг одоо байгаагаас илүү оролцоо, хүртээмжтэй асуудлыг шийдсэн энэ чиглэлд л явах ёстой гэдэг ийм л бодлого. Би түрүүн танд тоо хэллээ. Хүүхэд орохгүйгээр цаана нь 1 сая иргэн халамж авч байгаа шүү, нийтдээ 2.3 сая иргэн. Тэрийг би баталгаатай тэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эх сурвалжаас ярьж байгаа шүү сайдаас нь та тодруулаарай. Сайдаас нь 2.3 сая иргэн ямар нэгэн хэмжээгээр халамжид хамрагдсан гэдэг албан ёсны тоо баримт энэний цаана байгаа.

Тэгээд саяын тоо баримтуудын үрээр юу болж хувирав? Юу болж хувирав? Яг үндсэндээ саяын тоо баримтуудын үрээр энэ улс оронд чинь дундаж давхарга гэдэг нөгөө ирээдүйдээ итгэдэг, ажил хийдэг, цалин авдаг цалингаасаа татвараа төлдөг, хүүхдийнхээ ирээдүйд санаа зовдог, боловсролд нь хөрөнгө оруулдаг энэ хэсэг чинь одоо байхгүй болж байна. Улам шахагдаж, хавчигдаж байхгүй болж байна.

Нөгөө ядуурал гэдэг зүйл чинь 20 жилийн өмнө байсан 3 хүний нэг ядуу өнөөдөр хэвээрээ. Яагаад гэвэл өнгөрсөн хугацааны наад хайр халамжийн бодлого чинь хавтгайрсан учраас. Тэгээд хайр халамжаар ядуурлаас гардаггүй гэдэг бодит үнэнтэй та бид нүүр тулгарч байна. Өнгөрсөн 20 жилийн бодлого, өнгөрсөн 10 жилийн бодлого. Тэгэхээр энэ бүгд.../үг тасрав/

Н.Учрал: Цогтгэрэл дарга та хүртэл хольж яриад байхаар ийм байдалд оруулж байна. Та хүртэл хольж яриад байна шүү дээ, 2.4 их наяд төгрөг өгдөг тэрийг битгий хамгаалал, халамжид хольж хутгаад бай гээд байхгүй юу. Нийгмийн хамгаалал буюу нийгмийн хамгаалал, халамж 2 чинь нийлээд 2.4 их наяд. Тэрний чинь 1.7 их наяд нь хүүхдийн мөнгө, эхэд зориулагдаж байгаа юм. Тэрний чинь би танд тоог нь хэлье 370 мянган хүн зорилтот бүлэгт буюу 370 мянган зорилтот бүлэгт л халамж очиж байгаа, мөнгөн тэтгэмж очиж байгаа байхгүй юу 370 мянга, 1 сая биш, 370 мянга. Та хүртэл хольж яриад байхаар бусад нь холино шүү дээ. Тэгэхээр та иргэнээс асуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ та нарт халамж хавтгайраад байна уу, хөдөлмөрийн чадвараа алдсан хувь хэмжээг чинь тогтоосон уу, үйлдлийн чадамж буюу ямар үйлдэл хийж чаддагийг нь тогтоосон уу, ялгаатай тогтоож чадаж байна уу, халамж хавтгайраад байна уу? Үнэхээр нийгмийн эмзэг бүлэгт хүнсний талон гэж 20 мянган төгрөг тараагаад тэр ядуурлаас гаргаж байна уу, халамж хавтгайрч байна уу? Халамж чинь зорилтот бүлэгтээ хүрэхгүй байна.

Хүүхдийн мөнгө чинь хүн амаа өсгөх бодлого, 0-оос 3 насны хүүхдээ асарсны тэр өгч байгаа бодлого чинь өөрөө нийгмийн хамгааллын бодлого. Үүний үр дүнд 10 гаруй жилийн дотор 400 мянгаар хүн ам өсчхөөд байна. Энэ нийгмийн хамгааллын

бодлого. Энийг аваачаад халамжтай хольчхоод, тэгээд халамж хавтгайрлаа, халамж хавтгайрлаа гээд, халамж нүдээ олохгүй байна. 2.4 их наядын чинь 72 хувь нь эх, хүүхдэд өгөх ёстой хүн амаа өсгөх бодлого. Энийг бид Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулиар энэ бол хүн амаа өсгөх бодлого. Энэ хөтөлбөр, 4 жил тутам тайлангаа тавьж байна. Ази Номхон далайн бүс хүүхдийнхээ төлөө хүн амаа өсгөх рүүгээ сайн бодлого дэвшүүлж байгаа улс гээд манайхыг үнэлчхээд байгаа юм. Энэ халамж биш. Халамж зорилтот бүлэгтээ хүрэхгүй 28 хувь хүрэхгүй байна. Халамжаа зорилтот бүлэгт чиглүүл.../үг тасрав/

О.Цогтгэрэл: Хүүхдийн мөнгөн дээр, хүүхдийн мөнгийг хүн амаа өсгөх бодлого, дээрээс нь энэ байгалийн баялгийг зүй зохистой хуваарилах бодлого гэдгийг АН санаачлаад, энэнээс нааших өөрчлөлтүүдийг тууштай дэмжиж ирсэн. Тийм учраас би хүүхдийн мөнгөнөөс тусдаа 980 орчим, 900 гаруй мянган насанд хүрсэн иргэний тоог Аубакир сайд хариулаарай, 2.3 сая гэдэг тоог танай албан ёсны мэдээллээс манайхан авсан байна лээ. Та тэрийгээ баталж харуулж, баталгаажуулж хэлэлцэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Тэр төсөв мөнгөний тухайд сайд нарын багц гэж байдаг. Сайд нарын багц дээр тэтгэвэр орохгүйгээр бараг 4.6 их наяд байна уу, хамгийн өндөр дүнтэй боловсролоос, эрүүл мэндээс бусад бүх салбараас хамгийн өндөр дүнтэй мөнгө Нийгмийн хамгааллын сайдын багцад л байгаа. Энэ дотор нэгдсэн төсөвт орж байгаа нийгмийн даатгалын сангийнх орохгүйгээр. Тэгэхээр энэнд бид нийт дүнгээрээ улсын татвар төлөгчдийн мөнгө хаашаа чиглэж байгааг зөвхөн энэ тоо л харуулна. Бүх сайд нарын багцаас хамгийн өндөр нь хаана байна вэ гэдэгт энэ нөхцөл байдлыг харуулах байх гэж бодож байна.

Тэгээд хамгийн гол нь хамгийн сайн нийгмийн бодлого бол, хамгийн сайн халамжийн бодлого бол ажлын байр бий болгох, ажлын байрыг бий болгох. Гэтэл өнөөгийн эрх баригчдын барьж ирсэн бодлого, бодлогын цөм ажлын байр. Тэгэхдээ энэ ажлын байрыг татвар төлөгчдийн мөнгөөр төрд, төрийн өмчит компани /ТӨК/-д ажлын байр бий болгохыгоо ажлын байр гэж ойлгодог. Энэ явсаар байгаад, яг шуудхан хэлэхэд МАН-ын хамаарал бүхий гишүүд тэр хүмүүсийг нь төрийн алба гэдэг ТӨК гэдэг асрамжийн цэцэрлэг, тийм халамжийн газар болоод хувирчихсан.

Н.Учрал: Нийгмийн хамгааллын бүрэлдэхүүн хэсэг халамж. Та бид 2 ямар онолын мэтгэлцээн хийлтэй биш, улс төрч хүмүүс байна даа. Тэгэхээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр ТӨК-ийн засаглал болохгүй байгаа, би, та бид 2 үүнтэй санал. Их Хуралд хамт хэдэн жил суухдаа та бид 2 энэ дээр нэгддэг байсан. ТӨК-ийн засаглал болохгүй байгаа учраас сая ажлаа аваад 80 хоногийн дотор 14 компанийг татан буулгасан. Эрдэнэс Монгол компанийг зөвхөн Баялгийн сангийн хуулийн дагуу тэндээс орж байгаа ногдол ашиг, орлогыг иргэдэд хүрэх зөв жишгийг тогтоосон. Сая 3 дахийг нь ЗГ-ын хурлаар Чингис хаан баялгийн сан, дээрээс нь ТӨК-иуд дээр яг энэ сая Узбекстанд хөрөнгө босгосны адилаар олон улсын хөрөнгийн менежментийн компаниудад нээлттэй урилга хүргүүлчихлээ. Наадмаас өмнө би эдгээр компаниудын аль нэг компанитай ТӨК-ийн менежментийг сайжруулж яг ашиг, орлогыг иргэний халаасанд хүргэх ажлыг менежментэд өгнө.

ТӨК болохгүй байгаа учраас энэ ТӨК-ийн хуулийг Хэрэг эрхлэхийн дарга байхдаа би ахалж өргөн мэдүүлсэн. Харин Их Хурлын гишүүддээ үнэхээр их талархаж байна. Энэ олон хуулиуд Монголд хувьсгал авчирна. ТӨК-ийн хуулийг баталсны дараа харин 1 сарын 1 гээд хугацаагаа тавьчихсан байна лээ. Уг нь

наашлуулчихвал ТУЗ-ийг хуулийн дагуу бүгдийг нь чөлөөлнө, би гүйцэтгэх захирлуудыг хуульд заасны дагуу шаардлага тавина. KPI-аар үнэлнэ, та ч, би ч хувийн хэвшилд ажиллаж байсан, KPI-аар үнэлнэ. Түүнээс цалин бага байгаа, өндөр байгаадаа ч биш, ногдол ашиг хуримтлуулж чадаад, индикаторуудаа тавиад тэр нэгждээ хүрч чадаж байвал яг үүнийх нь дагуу урамшуулна.

О.Цогтгэрэл: Яг таны сая хэлснийг энэ нэг их тийм шинэ үлгэрийн далай эхэлж байна л гэж харж байна. ТӨК гээд төрийн оролцоотой засаглал нь төрөөс томилогддог энэ өмчлөл нь төр дээр байдаг энэ байгууламжийг энэ чигээр нь би сайжруулна гээд та хэлээд байгаа юм. Наадах чинь сайжрахгүй, наадах чинь ерөөсөө сайжрахгүй. Харин наадхыг чинь хувьд шилжүүлэх, менежментийг нь шилжүүлэх бүр олон нийтийнх болгож хувиргах. Угаасаа өөрөө өөрснөө энэний төлөө ажилладаг тэр дэлхий нийтийн дэг жаяг руу нь явуулахгүй бол, ТӨК-ийг байлгачхаад энийг би гоё болгоно, бүтээмжийг нь сайжруулна, засаглалыг нь сайжруулна, их сайн хүмүүс авчирч тавина гээд, наана чинь сайн хүн гэж байхгүй, муу наадах дээр чинь. Харин эрх ашгаараа холбогдсон, энийг хэмнэлтийн төлөө, энэний үр ашгийн төлөө, энэнээс ирээдүйгээ ирээдүй нь энэнээс хамаарч зүгээр энэ дээр нэг тийм намын тавиулууд очоод, хэчнээн мундаг намын тавиул очоод наадах систем чинь нэг процент ч үнэндээ сайжрахгүй. Энэ цоо шинэ төрийн өмчийг байдгаар нь байлгаад сайжруулна гэдэг үлгэрийн далай эхэлж байна л гэж харж байна.

Тэр тусмаа танай сая 27 оны нэг жилийн ажлын төлөвлөгөө өнгөрсөн долоо хоногт УИХ-аар орж байсан. Тэрэн дээр энийг хувьчлах, хувьд шилжүүлэх, олон нийтийнх болгох ямар ч үг, өгүүлбэр байхгүй болчихсон явж байна лээ. Тэгэхээр та байгаа юмыг сайхан өнгө будаг, косметик хийе, төрд байдгаараа байя. Төр нөгөө, одоо наад авлига, хээл хахууль чинь их гоё хэлбэрт л орно, далдлагдсан хэлбэрт л орно. Зүгээр л энэ косметик будаг өөрчлөөд юу өөрчлөгдөх юм, юу ч өөрчлөгдөхгүй наанаас чинь.

Н.Учрал: Өнгөрсөн цаг хугацаанд яг 14 ТӨК-ийг татан буулгаад цомхотгол хийчихсэн Ерөнхий сайд хэд байсан бэ гэвэл би сайн мэдэхгүй байна. ТӨК-ийг өнөөдрийн ийм засаглалын хямралд оруулсан хүмүүс танай манай намынхан аль аль нь. 24 оны сонгуулийн дараа ТӨК-ийг АН, МАН 2 хамтдаа завааруулсан. Энийгээ ярих ёстой шүү. Хэрэгтэй, хэрэггүй бүтээмжийн, хяналтын менежерүүдийг хамтдаа тавьсан энэ хариуцлагаас хэн ч зугтахгүй шүү. Эрдэнэс Монгол нэгдэл компанийг Чингис хаан баялгийн сан болгоод, 14 компанийг татан буулгаад, 67 тэрбум төгрөг хэмнээд, хуулийнх нь дагуу Чингис хаан хөрөнгө оруулалтын сангийн зарчмаар ажиллуулъя гээд Чингис хаан баялгийн сангийн нэгдэл гээд өчигдөр ЗГ-ын хурлаараа нээлттэй урилгуудыг ХОМК-уудад өгөөд, одоо ХОМК-уудын энэ саналд нь үндэслээд ТӨК дээр хөрөнгө босгох ажлыг ХОМК-оор хийлгээд эхлүүлнэ. Ингэснээрээ портфоли буюу хөрөнгө оруулалтын сан дээр хувьцааны багцуудыг нэгтгээд бирж дээр гаргана. Ингэж хөрөнгө босгоно.

Энэ тохиолдолд тухайн ТӨК-ийн 5-ыг авна уу, 10-ыг авна уу нэгдсэнийх нь дараа гаргахаар 5 хувийг нь эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтын сан дээр ч гэсэн үнэлгээ хийгдэнэ, олон улсын аудит хийлгэнэ, засаглал сайжирна. Энэ бол бодитой ажил. Дээрээс нь Их Хурлын гишүүддээ би талархаж байгаа. Бизнесийн эрх чөлөөний хууль, 100 хуулийн өөрчлөлт, энэ хуулиудыг гаргаснаараа бодитой чөлөөлөлт хийгдэнэ, бүтээмж нэмэгдэнэ. Дээрээс нь энэ ТӨК-ийн хууль гарснаараа энэ хууль дээр тавигдсан шалгуур, шаардлагыг давж гүйцэтгэх захирал болох, ТУЗ-

д суух хүн төдийлөн олдохгүй. Энд мэдлэгтэй, боловсролтой шалгуурт тэнцсэн хүмүүс олдоно. Бүх зүйлийг нээлттэй болгосон, сая эрчим хүч дээр би нээлттэй auction хийж байгаатай яг адилхан юу ч нуухгүй.

О.Цогтгэрэл: Яг үндсэн сэдэвтэйгээ холбоход наад ТӨК-ийг чинь хэчнээн тордоод, томруулаад, өнгөлөөд зүлгээ гэж ач холбогдол өгөх тусам бидний бид хоёрын өнөөдөр ярьж байгаа наад төрөөс хамаарсан амьдралтай хүмүүс, наад татаас авдаг хүмүүс, халамж авдаг хүмүүс чинь улам л ихэснэ. Энд ямарваа нэгэн энд өөр логик байхгүй. Та нар ингээд сайхан байж бай, бид нар энд төр та нарыг сайхан амьдруулчихна. Уг нь та наад толгойгоо, сэтгэхүйгээ арай өөрөөр, зарим зүйл дээр ярьдаг шигээ л бодмоор байх юм. Тэрийг нь тэр олон нийтэд нь, иргэд рүү нь чиглүүлж наад төрийг чинь жижигсгэчихье л гэж бодъё л доо. Та төр байдгаараа байгаад улам гоё болгочихно. Дахиад л өмнө нь ярьж байсан нэг агуулгыг давтаад л ярья. Өмнөх асуулгын цаг дээр та ярьж байсан 14 компани татан буулгалаа гэж, тэр 14 компани татан буулгаад тэр чинь нэр, хаягаа өөрчилж өөр нэгэнд нэгдэж байгаа болохоос биш, нэг процент ч багасаагүй, буураагүй шүү. Наадах чинь зүгээр л нэг ийм жижигхэн хууран мэхлэлт, заль, явган заль л явж байна. Наадах чинь өөр юу ч биш.

Тэр компанийг та хувьчилсан бол хувьцаат компани болгосон бол би энийг агшлаа, багаслаа, төр жижигслээ гэж хэлнэ. А компанийн нэрийг Б компани болгоод, А компанийн нэрийг Х компанид нэгтгэчихлээ гээд юу өөрчлөгдөх юм. Зүгээр хууран мэхлэлт наадах чинь. Тэгэхээр үндсэн сэдэвтэйгээ дахиад эргүүлээд холбоод ярихад ямар ч байсан халамжийн тогтолцоогоор энэ ядуурал буурч, ажлын байр нэмэгдэхгүй гэдгийг бид хангалттай хугацаанд харлаа, нотоллоо. Тэр тусмаа та нарын боддог, сэтгэдэг төрийг томруулах замаар, улам гоё болгох замаар, өнгөлөх замаар, өөрчлөн байгуулах замаар энэ чинь буурахгүй нь гэдэг нь улам бүр тодорхой болчихлоо. Тэгээд цаашид яах юм бэ? Та нар энэ үлгэрээ ингээд шинэ, шинэ үлгэр зохиогоод, угаасаа түүхээр нотлогдчихсон үлгэрийг 2 дугаар ангийг нь ингэж зохиож ярихын хэрэг.../үг тасрав/

Н.Учрал: Цогтгэрэл дарга тийм, тийм. Цогтгэрэл дарга их гутранги хүн юм. Болохгүй, бүтэхгүй л гээд байх юм. Бидний үеийнхэн болно, бүтээнэ, болгоно, бүтээнэ гэдэг ийм үеийнхэн юм. Тийм учраас би тантай зүгээр нэг зүйлийг хэлье, 260 оронтой буусан, 67 тэрбум төгрөг хэмнэгдсэн, 14 компани татан буугдсан. Та тэр 14 компанийг одоо олж чадахгүй. Тэр байхгүй, тэнд ажиллаж байсан 260 орон тоо байхгүй, 260 орон тоо буучихсан. ТӨК-ийн хууль дээр та нар ажилласан. Ингээд таны ярьж байгаа энэ ТӨК дээр хувь, хувьцааг гаргах эрх чинь Их Хурлын эрх. Тийм учраас энэ ажлыг хэнээр хийлгэх ёстой вэ гэхээр яг энэ Узбекстанд сая мөнгө босгосны яг адилаар хөрөнгө оруулалт менежментийн компани Хөрөнгө оруулалтын сангийн хуулийн дагуу менежмент хийдэг юм, өгөөжийг тооцдог байхгүй юу. Тэгэхээр тэр ХОМК-д өгөөд, тэр ХОМК үнэхээр энэ компанийн 5 хувь, энэ компанийн 10 хувь, энэ компанийн 15 хувийг нийлүүлээд портфоли (Portfolio) буюу хөрөнгө оруулалтын багц болгоод гаргавал энэ дунд компанийн засаглал сайжирдаг. Энэ бол онол, онол байхгүй юу.

Би ажлаа хийхдээ онолын дагуу хийж байгаа юм. Яагаад гэхээр өнгөрсөн хугацаанд би хувь, хувьсгалд аль алинд нь ажилласан учраас би онолын дагуу сурч мэдсэн мэдлэг, боловсролоо ашиглаж хийж байгаа. Тэрнээс би аливаа зүйлийг таамгаар хийж ирээгүй. Тийм учраас би ТӨК-ийн хуулийг УИХ батлаад өгөөч гэж хүссэн. Бизнесийн эрх чөлөөний хуулийг батлаад өгөөч гэж хүссэн. Надад ТӨК дээр

баримтлах үндсэн чиглэлийг оруулж ирэхэд УИХ-ын тогтоол дагуулаад ХОМК-ийн зөвлөснөөр 5, 10 хувийг нь хувьцаа гаргах эрхийг өгчих, 28 оноос өмнө би олон улсын бирж дээр ТӨК-ийг хөрөнгө оруулалтын портфолио болгоод мөнгө босгож үзүүлье. Тэрнээс биш нэг ийм хэдүүлээ яах вэ ингээд улс төр хийнэ гэдэг нэг асуудал. Тэгэхдээ онол, амьдрал 2 үргэлж хамт байдаг.

О.Цогтгэрэл: Та бухимдах хэрэггүй л дээ, наадах чинь бодит үнэнтэй та эвлэр өнгө, косметикоор аргалж хуурдгаа одоо больцгоо. Дахиад онол яривал байгалийн хууль дээр байдаг юм. Энерги хадгалагдах хууль гэж байдаг юм, энерги устаж үгүй болдоггүй, хэлбэрээ өөрчилдөг юм, хэлбэрээ өөрчилдөг юм. 14 компанийг татан буулгана гэдэг чинь зүгээр хэлбэрээ өөрчилж байгаа юм. Тэр энерги устаж үгүй болдоггүй шиг, хэлбэрээ өөрчилдөггүй шиг төрийн өмчийн тэр мөнгөн дүн чинь хэвээрээ байж байдаг юм. Энэ чинь ийшээ энэ дэлхийгээс алга болчихдоггүй юм. Энергийн хууль шиг юм наадах чинь. Харин та хувьд шилжүүлж, олон нийтийнх болгосон бол энэ жинхэнээсээ наад энергийн өөрчлөлт чинь орно. Та тэгэхээр болгоно гэж биш, жинхэнээсээ онол, ном байтугай, нийгмийн байтугай байгалийн хуулиас та шал өөр юм яриад явчихлаа. Шал өөр юм яриад явчихлаа.

Дахиад сая тэр хамгийн сайн халамж бол ажлын байр гэдэг дээр дахиад яг танай ЗГ-тай, танай ч гэлтгүй л дээ ер нь энэ ЗГ-тай холбоотой нэг асуудал хөдөлмөрийн зах зээлийн тухай яриа байна. Өнөөдөр ажил олгогчид нь ажилтангүй, ажиллах хүчингүй болчихсон. Их, дээд сургууль төгсөөд шаардлага хангахгүй баахан залуучуудтай болчихсон. Энэ 2 нь огтлолцдоггүй, энэ 2 нь огтлолцдоггүй. Тодорхой тоо яривал 60, 70 мянгаараа ажилтан хэрэгтэй. Тодорхой тоо яривал 60, 70 мянгаараа ажилгүйчүүд. Энэний дунд ажил, хөдөлмөрийн чадвартай, харьцангуй ажил, хөдөлмөрт бэлтгэгдсэн хэсэг нь гадагшаа гараад явчихсан, гадагшаа гараад дайжихад бэлэн болчихсон. Тэгэхээр уг нь зүй нь үнэхээр энэ халамжийг өөрчилъё, ажлын байр руу шилжъё, ядаж халамжаасаа хамгаалал руу шилжъё. Эрсдэлийн даатгалын тогтолцоондоо мөнгөө төлдөг энэ хэсгийг ихэсгэе л гэвэл саяын энэ хөдөлмөрийн зах зээлийн энэ асар том орон зай.../минут дуусав/

Н.Учрал: 40 гаруй төрлийн халамж байна. Тийм учраас Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулиар, манай АН-ынхан ярьдаг, мэдээж хүүхдийн мөнгийг санаачилсан гэж. Би энэ маш зөв бодлого гэж боддог. Хүн амаа өсгөх би үүнийг хүлээн зөвшөөрдөг, гэхдээ үүнийг халамж биш гэж үзэж байгаа, хүн амаа өсгөх бодлого. Тийм учраас энэ бодлогыг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулиар зохицуулаад, халамж гэдэг тусдаа саванд зорилтот бүлэгт чиглэсэн тусгай зорилтот хөтөлбөрүүдээ ийшээ хийе гэж байгаа. Тэгж байж зорилтот бүлэг халамжийнхаа үр шимийг хүртэнэ. Үгүй болохоор тэр Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль, энэ 2-ыг ингээд нийлүүлээд саванд хийчихээр халамж хавтгайрсан харагдаад байдаг, халамжлуулах шаардлагатай бүлгүүд нь сэтгэл хангалуун биш байгаад байгаа нь асуудлын мөн чанар юм гэдгийг би танд хэлье.

Мөн ЗГ-ын явуулж байгаа бодлого хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого. Би хэлсэн танд ажил эрхлэлт өндөр байвал хөдөлмөрийн орлого өндөр байдаг, хөдөлмөрийн орлого өндөр байвал ДНБ /GDP/ тэлдэг. ДНБ /GDP/ тэлснээрээ нэг зам нь өөрөө хөдөлмөр эрхлэлт, цалингаар дамжиж өрх рүү ордог, нөгөө зам нь Үндэсний баялгийн сангийн хуулиар ордог. Тэгэхээр би 2 замаар алхаж байгаа юм. Үндэсний баялгийн сан, тэр цалингаар дамжуулж хийх орлого. Үүнд саад болоод байгаа зүйл нь Бизнесийн эрх чөлөөний хууль, 100 хуулийн өөрчлөлт. 100 хуулийн өөрчлөлт дээр манай АН-ынхан сайн ажилласан, би энэ бизнесийн эрх чөлөө, эдийн

засгийн эрх чөлөө 2-ыг нэгтгээд Жаргалан гишүүн, энэ Цэнгүүн гишүүн эд нар ажилласан. Би талархаж байгаа. ТӨК-ийн хууль дээр АН-ынхан хамтарч ажилласан, би талархаж байгаа. Үүний дараа хүний утас авахгүй байж байгаад ТӨК-ийг цэгцэлнэ гэдгийг хэлье. Зүгээр хөрөнгө босгох нарийн ширийн асуудлуудаар би АН-ын гишүүдтэй ч санал солилцож байсан. Би Түвшин гишүүнтэй санхүүгийн зах зээлийн талаар яривал илүү удаан ярих байх л гэж бодож байна.

С.Бямбацогт: Гишүүд ээ, хөндлөнгөөс мэтгэлцэгчдэд битгий нөлөөл тэгэх үү. Та хэд маань суудалдаа суучих, тийм.

О.Цогтгэрэл: Саяын асуулт тэмээ гэхээр, ямаа гэхээр л явчихлаа. Шал өөр хадуураад та чинь. Нөгөө асуусан биш, өөрийнхөө хүссэн сэдвээ ч яриад явчих шиг боллоо. Би уг нь наад хөдөлмөрийн зах зээл дээр наад халамж, хамгааллын чинь өөрчлөх үндсэн суурь болсон хөдөлмөрийн зах зээл дээр чинь асар том орон зай, гар үүсчихлээ. Энэ талд нь ажиллах хүчний хэрэгцээтэй ААН-үүд байдаг, энэ талд нь ажилгүй залуучууд дүүрэн. Энэ 2-ын чинь энэ орон зайг яах юм бэ? Энэ рүү хандах чинь өөрөө наад нийгмийн энэ хамгаалал, нийтийн халамж болоод хувирчихсан байгаа энэ бодлогын чинь эсрэг хамгийн үр дүнтэй та нарын ажиллах ёстой үндсэн цэг чинь тэнд байна шүү дээ. Энэ зүйлээ хаячхаад дэвэн дэлхийн, тэнгэрийн юм, өөр юм ингээд зохиогоод яриад, асуулт, хариултыг ингээд шал утга учиргүй өөр тийшээ авч яваад байх юм.

Тэгэхээр энэ та нарын үнэхээр Монгол Улсад өнөөдөр тулгамдчихсан байгаа. Тэгээд үлдсэн хэсэг нь яадаг вэ? Тэрэн дунд байгаа хамгийн боломжтой хэсэг нь тэр пунд талын зайд шаардлага нийцэж байгаа хэсэг нь гадагшаа гараад дайжчихсан, үлдсэн нь дайжихад бэлэн. Энэ чинь л өөрөө бараг өнөөдрийн та бидний яривал хамгийн чухал асуудал энд яваад байна гэдгийг хэлье. Тэгээд энэ бүгдийн саяын тэр нийгмийн халамж хавтгайрч, халамжийн бодлого хамгаалалттайгаа холилдож энэ явж байгаагийн нэг үндэс, энэ буурахгүй байгаагийн үндэс чинь төрөөс явуулж байгаа хамгийн том бодлогын нэг инфляц /inflation/, үнийн өсөлт, мөнгөний ханшны уналт. Энэ чинь энэ сегментийг улам ядууруулаад байна. Та нар тэр мөнгөний бодлого, олон, олон зүйлүүдээ эргээд нэг хараарай. Энэ төрийн оролцоогоо хараарай. Энэ инфляц гэдэг чинь далд татвар, төрөөс авч байгаа албан бус татвар болж хувирчхаад наад нийгмийн эмзэг хэсгийг чинь улам ядууруулж, улам эмзэг хэсэгт оруулаад байна. Энэ дээр энэ бол Монголбанкны бодлого ЗГ-т хамаагүй.../минут дуусав/

Н.Учрал: Цогтгэрэл дарга өнөөдөр их ажил хэрэгч биш байна. Тэгээд ямар сонгууль болж байгаа биш, би төрийн ажлаа л хийж байгаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого манай ЗГ-ын тэргүүлэх бодлого гэж би хэлсэн. 1990 оны бага төрөлтийн үеийнхэн өнөөдөр хөдөлмөрийн зах зээлийг авч явж байна. Тийм учраас зах зээл дээр ажиллах хүч хомс болсон. Тийм учраас бид Нийгмийн даатгалын хуулийг оруулж ирэхдээ ахмадуудыг ашиглах ёстой буюу ажил олгогч, ажилтны шимтгэлийг чөлөөлье гэдэг бодлогыг оруулж ирсэн. Яагаад гэхээр 2007 оны алтан гахай жилтнүүд 21 нас хүртэл энэ нэг гар үүсчээд байгаа юм. Энийг цэгцлэх ёстой.

Дээрээс нь сая татварын хууль дандаа ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой. Халаасанд нь яаж 79200 үлдээх вэ. Баярмаа гишүүний санаачилсан тэр 1 хувь бол 2 сая хүртэлх тэр 188 мянгыг яаж үлдээх вэ гэдэг дандаа хөдөлмөр эрхлэлтээс үлдсэн орлогыг халаасанд нь үлдээх байхгүй юу. Тийм учраас би тэр татварын бодлогыг оруулж ирсэн. Танайх шиг 6-аас 10 тэрбумын борлуулалттай

компаниуд 23 мянга төрөөсөө, НӨАТ-ын суутган төлөгчийн босго 400 сая болчихвол дахиад 20 мянган компани төрөөсөө гэдэг бодлогыг оруулж ирсэн. ААНӨАТ 2.5 болчихвол 180 мянган компанийг бий болгох ийм бодлогыг оруулж ирсэн. Бизнесийн эрх чөлөөний хууль дээр банкнууд 5 хувиар санхүүгийн зах зээл дээр мөнгө босгодог бол санхүүгийн компаниуд адилхан 5 хувь хүртээсэй гэж бодсон. Шинэ эдийн засгийн төрөлжилт бий болж байгаа үед тэр дата төв, хиймэл оюуны төвийг оруулж ирвэл гаалийн тоног төхөөрөмжөөс нь чөлөөлчхөөсэй гээд. Энэ бодлого болгоны цаана дандаа ажлын байр нь хөгжих, хамгийн сайн нийгмийн хамгаалал бол ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршдог. Тийм учраас та үүнийг ойлгох ёстой. Ер нь Үндэсний бүтээмжийг дээшлүүлэх мастер төлөвлөгөөг би ЗГ дээр боловсруулж байна. Ер нь GDP гэдэг өөрөө бүтээмжтэй шууд хамаатай асуудал байдаг. Тийм учраас таны үзэл санааг би дэмжиж хэрэгжүүлж.../минут дуусав/

О.Цогтгэрэл: Тэгэхээр харин уг нь энэ халамж, хамгааллаа цэгцлэх, халамж, хамгааллаа зохистой болгох, яг нийгмийн зорилтот хэсэгт нь халамжийг нь илүү таатайгаар өгдөг, ихэнх хэсэг нь ажлын байранд, хөдөлмөрийн зах зээлдээ шилждэг энэ л бодлого бидэнд хэрэгтэй байгаа юм. Гэтэл сая татварын хуулиуд дээр ярьж байгаагаар та нар чинь 3 мянган доллараас дээш цалин авдаг, татвараа төлдөг тэр иргэн бараг нийгмийн дайсан юм шиг л юм ярьцгаана лээ. Бараг л нийгмийн дайсан юм шиг эд нарыг татварыг нь авах ёстой 20, 30 хувь авч байгаа нь харин ч бага байна. Энэнээс их авах ёстой. Тэр нь 10 сая төгрөгийн цалингийн орлоготой гэхээр 3 мянган доллар хүрэхгүй цалингийн орлоготой нөхдүүд. Гэтэл уг нь энэ ажил хийж байгаа, хөдөлмөр эрхэлж байгаа, татвараа төлж байгаа, ирээдүйдээ санаа зовж байгаа тэр тусмаа саяынх чинь нийгмийн идэвхтэй бүлэг, нийгмийн дундаж давхарга эдгээрийгээ биш, эдгээрийгээ зүгээр л хууран мэхэлсэн гэх юм уу даа. Яг л та сая татварын бодлого дээр ярьж байхад олон, олон зүйлүүд, анги, давхарга ялгаа, өсөн нэмэгдэх татвар, олон, олон зүйлүүдийг ярьсан ийм л нэг бодлогын өөрчлөлтийг та бүхэн ярина лээ.

Тэр тусмаа ирээдүйд чинь эрсдэлтэй зүйлүүд бий. Энэ AI орж ирснээр яг ажлын байруудад манай улсад улам илүү эрсдэл бий болох, ажлын байруудыг AI орлох яг бодит үйл явц компаниуд дээр аль хэдийн эхлээд яваад эхэлчихсэн. Тэгэхээр энэнд дасан зохицох олон, олон ажлууд бид бүгдэд маш их олноороо асуудлууд хүлээгдэж байна. Тэгэхээр АН-ын зүгээс ажил хөдөлмөр хийж байгаа, баялаг бүтээж байгаа энэ хэсгийг л онцгойлон бид дэмжих ёстой. Тэр байтугай бид 20 жилийн өмнө санаачилж, АН дээр овоглогдож явж байдаг 4 10-ын татварын бодлогыг гэхэд зөвхөн 4 10 биш, одоо бид шинэ цагт энийг.../минут дуусав/

Н.Учрал: Цогтгэрэл даргын дэвшүүлж байгаа, санал болгож байгаа дэвшилтэт энэ сайхан үзэл санааг амилуулах хуулийг би Их Хурлын даргад хүргүүлчихсэн. Гэр бүлийн хөгжлийг дэмжих хууль, Нийгмийн халамжийн хууль. ЗГ-аар 90 хүрэхгүй хоногийн хугацаанд татварын реформ, тэтгэврийн реформ, ТӨК-ийн реформ, гэр бүл, халамж, хамгаалал 2-ыг салгах, нийгмийн даатгал, хувийн нэмэлт тэтгэврээр дамжуулж, хөрөнгийн захыг босгох 2 тулгууртай эдийн засагтай болгох бодлогыг дэвшүүлсэн. Ажил хэрэг болж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажил хийж болдгийг харуулж байгаа юм. Өнөөдөр 98 оноос хойш улс орны хөгжлийг хүний хөгжлийн индексээр томъёолдог болсон. Тэр хүний хөгжлийн индекс юу вэ гэхээр ядуурал гэдэг чинь зөвхөн тоо биш. Ядуурал чинь цалин биш, ядуурал чинь боловсрол, эрүүл мэнд. Нэг ёсондоо боломжийн ядуурал үүсчхээд байна.

Сая би Булган аймгийн, Булган аймагт очоод тэр ногоон өртөө нээгээд ирлээ. Татварын 1 хувиар хувийн компани ногоон өртөө байгуулаад, дотор нь 5 биеэ угаах угаалтуур газрууд байна л даа усанд орох. Тэнд тэр сум, орон нутгийнхан ирж усанд орж байна. Ерөөсөө энэ чинь юу вэ гэхээр боломжийн ядуурал бий болчихоод байгаа байхгүй юу. Энэ болгоноос болоод боломжийг маш их хүн алдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ механизм өөрөө төр, хувийн хэвшлийн түншлэл байх ёстой. Өнөөдөр СОР-с өмнө 40 ногоон өртөө байгуулна. Улс орныхоо өнцөг булан бүрд очоод усандаа ороод, амарч суугаад, гадаа машинаа тавиад цэнэглээд явдаг энэ түлш, шатахууны хамаарлаас бууруулъя ч гэдэг юм уу, ерөөсөө энэ түншлэлийн хамгийн хөгжлийн зөв замыг сонгож байна.

Жишээ нь Улаанбаатараас Замын-Үүд рүү 4 эгнээ хурдны зам түншлэлээр эхэлчихлээ. Тэгэхээр энэ болгон бол ажил юм. Тийм учраас хэдүүлээ улс төр биш ажил ярь. Тэгэхээр би АН-ынхандаа их итгэлтэй боллоо. Халамж, хамгаалал 2-ыг салгая гэдэг энэ бодлогыг бүрэн дүүрэн дэмжиж байгаа юм байна. Тэгээд энэ хуулийг оруулаад ирнэ.

С.Бямбацогт: 37 минут 30 секунд дууссан байна. УИХ дахь цөөнхийн бүлгийн гишүүд, бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна Цогтгэрэл даргад баярлалаа. Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Ерөнхий сайд хоёулаа хэдэн логик, баримтуудыг ярилцъя. 1 дүгээрт, та гэнэт сонгогдсон Их Хурлын гишүүн биш, 3 удаа сонгогдож байгаа, 2016 оноос хойш 10 дахь жилдээ Монгол УИХ-ын гишүүнээр ажиллаж байгаа. Тэгэхээр та сая хэлж байна шүү дээ Цогтгэрэл даргатай мэтгэлцэхдээ гутранги зүйл яриад байна, бид өөдрөг гэж. Үнэхээр бид өөдрөг байхыг хүсэж байгаа байхгүй юу. Гэтэл яг энэ өнгөрсөн 10 жилийн нэг нам тэргүүлсэн, дангаар бүрдүүлсэн энэ ЗГ-ын үйл ажиллагаа чинь өөрөө гутранги байхаас өөр аргагүй байдалд хүртэл нь ард иргэдийг туйлдуулж байна шүү дээ. Өнөөдөр Монгол Улсын жирийн иргэнээс та хэр аз жаргалтай байна вэ, та өөдрөг байж чадаж байна уу, та энэ нийгэмдээ, шударга ёсондоо, эдийн засгийн хүртээмжтэй байдалдаа сэтгэл хангалуун байна уу гээд асуухад ихэнх нь асар их бухимдалтай, ууртай байна. Тийм учраас энэ бодит байдлыг гоёчилж ярих шаардлагагүй 1.

2 дугаарт, та сая хэлж байна шүү дээ хариуцлагаа хувааж үүрнэ гэж. Өнөөдөр ирээдүй цаг дээр олон зүйлийг ярьж болох ч гэсэн одоо байгаа зүйл дээр шийдэмгий шийдвэр гаргаад явах энэ цаг хугацаа болчихсон, өнгөрчихсөн, нийгмийн хүндрэл нь ужгирчихсан байгаад байна шүү дээ. Ерөнхий сайдын ажил хийж байгаагийн тань хувьд нэг зүйлийг асууя. Та сая халамж нүдээ олсонгүй, нүдээ олохгүй байна гэж хэлээд байгаа юм. Тэгвэл яаж яг тэр зорилтот хэсэгт нь тэр 2.4 их наядыг хүргэх гээд байгаа юм бэ? Хүргэнэ гэж хэлэх хялбар, зорилго дэвшүүлэх амархан. Гэхдээ энэ чинь хэмжих нэгж, хугацаа, үр дүнгээр явдаг. Та ингээд Монгол Улсын Ерөнхий сайдаар нэг улирал болж байна, улирал гаран болж байна, 2 улирал болж байна уу одоо.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя. Шууд нэг минутаа үргэлжлүүлэе. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Дэвшүүлээд байгаа бодлого чинь ямар хугацаанд, ямар өгөөж авчрах юм бэ гэдэг нь хариулт хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. 24-өөс 28

оны 3Г-т 578 зүйл, заалттай хөгжлийн хөтөлбөр дэвшүүлсэн, дунд нь 2, 3 Ерөнхий сайд солигдлоо. Гэхдээ энд чинь нэг хэмжих нэгж байх ёстой, бид ард түмэнд худлаа ярьж болохгүй. Энэ дээр хариулт авъя.

2 дугаарт, хариуцлагын асуудал. Нийгмийн халамжийн нөгөө талд нь нийгэмд баялаг бүтээх хүмүүс, бизнес эрхлэгчдээ дэмжих Бизнесийн эрх чөлөөний хууль яваад байгаа. Та олон талаар чөлөөлье гэж яриад байгаа. Гэхдээ өнгөрсөн хугацаанд үйлдэл, эс үйлдлээрээ энэ бодлогыг тушчихаад, Монгол Улсад хор хохирол учруулаад байсан энэ эрх мэдэлтэй, албан тушаалтай хүмүүст ямар хариуцлага тооцох юм бэ? Өнөөдрийн хугацаанд тооцсон зүйл алга байна. Энэ 2 дээр та хариулт өгөхгүй юү?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя. 2 дээр нэмэх нь нэг минут, 3 минут хариулна.

Н.Учрал: Монгол парламентын засаглалтай орон, парламентын баталсан 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлж байна. 5 жилийн үндсэн чиглэл 10 үндэсний үзүүлэлттэй, салбарын үндсэн үзүүлэлттэй, бүгд индикатортай, хэмжих нэгжтэй, жил болгон гүйцэтгэлээ тайлагнаад явдаг. Би энэ гүйцэтгэлийнхээ тайлангийн дагуу Их Хуралд ажлаа тайлагнана. Хуулийн дор ажиллаж байгаа. Миний энэ дэвшүүлж явуулж байгаа бодлогуудыг би бүгдийг нь яривал их юм болно 3Г-ын 100 хоногоор ярья. Өнөөдөр би яг 80 хонож байна, 80 хонож байна. Төр иргэддээ итгэж чаддагийн илрэлийг л би үзүүлье гэж зорьж байгаа. Төр иргэддээ итгэж чаддаг юм.

Тийм учраас би Бизнесийн эрх чөлөөний хуулийг өргөн мэдүүлсэн. Бүтэн жил ажилласан 100 хууль байгаа. 100 хуулийн өөрчлөлтийг өргөн мэдүүлсэн. Би энэ хууль батлагдсаны дараа 41 тусгай зөвшөөрлийг энгийн зөвшөөрөл рүү шилжүүлнэ. Энэ хууль би батлагдсаны дараа 5 жил тусгай зөвшөөрөл олгоод, 10 жилээр шууд олгодог шинэ зохицуулалттай болж байгаа учраас эрсдэлийн үнэлгээнд суурилоод тусгай зөвшөөрлөө сунгах гэж байгаа компаниудын тусгай зөвшөөрлийг шууд 10 жилээр сунгана. Энэ дандаа чөлөөлөлтүүд, хөрөнгө оруулалтын орчин сайжруулна. Хөрөнгө оруулалтын орчин. Сая эдийн засгийн форумд яваад ирлээ. Хөрөнгө оруулагч нартайгаа хэлэлцээрүүдийг хийлээ. 120 хүн нэг дэх өдөр ирнэ, бодитой хөрөнгө оруулалтыг татах ажлыг хоёрхон салбарт хийнэ. Сэргээгдэх эрчим хүч, хиймэл оюун. Хөрөнгө оруулалт, хариуцлагын тогтолцоогоо би хэмжих нэгжээрээ та бүхэнд тайлагнаад УИХ дээр явж байгаа. Түүнийхээ дагуу хариуцлагыг шат шатанд нь хийгээд л явж байгаа юм. Зүгээр энэ батлагдаж байгаа хуулиар тендер хиймэл оюун руу шилжиж байгаа. ТӨК-ийн бараг хэдэн жил ч юм батлаагүй хууль гарснаар авлигын индексэд том хувь нэмрээ оруулна. Ингээд засаглалыг хараат бус байх арга хэмжээнүүдийг авч байгаа.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 14 цаг 47 минутаас хуралдааныг даргалав.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх Цэндийн Баатархүү гишүүн. Цэндийн Баатархүү гишүүн. Микрофон нээе. Чимээгээ багасгаарай.

Ц.Баатархүү: Ерөнхий сайдаасаа амлалт биелж байна уу гэж асуумаар байна. Та сүүлийн 10 жил Монголын төрд хамгийн хариуцлагатай ажлыг удаа дараа хийлгээ. Хамгийн сүүлд 2024 оны сонгуульд ядуурлыг 2 дахин бууруулна, халамжаас хөдөлмөрт шилжүүлнэ гэсэн ийм мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж олонх болж, Ерөнхий сайдаар ажиллаж байна. Ерөнхий сайдаар ажиллахаас өмнө Монгол

Улсын эдийн засгийн асуудал хариуцсан Тэргүүн шадар сайд, Цахим хөгжлийн сайд, Байнгын хорооны дарга хийж байсан. Энэ амлалт биелсэн үү гэж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Би Монгол төрд 2016 оноос УИХ-ын гишүүн хийхдээ өөрт оногдсон ажлаа хариуцлагатайгаар хийж ирсэн. 2016 оноос 2020 оны парламентад Инновац, цахим бодлогын түр хороог анх байгуулж, Байнгын хороо болгож, цахим засаглалын индексийг 28 байр үргэлжлүүлсэн, 1480 үйлчилгээг И-Монгол /E-Mongolia/ дээр нэгтгэсэн. Энэ цахимын салбарт би 7 хуулийг батлуулсан, 109 хуулийг батлуулсан. Цахим засаглалын сүүлчийн цэгийг одоо Бизнесийн эрх чөлөөний хуулиар атгаж байна. Энэ миний Байнгын хорооны дарга, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд байсан үеийн ажлыг товч хэлбэл энэ.

Их Хурлын гишүүнээр ажиллаж байхдаа Залуучуудын хууль, Багшийн хууль, өнөөдрийн багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг Багшийн хуулиар шийдэж явж байгаа. Туслах багшийн орон тоог Багшийн хуулиар шийдсэн, ингээд шийдсэн. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг би санаачилж, баталсан юм. Энэ хуулийн дагуу туслах багшийн орон тоог аймаг, орон нутгууд хийж байгаа юм. Тэгэхээр хариуцсан ажлаа би хариуцлагатайгаар хийж байсан. Хэрэг эрхлэхийн сайд байхдаа та бүхний хэлэлцэж байгаа ТӨК-ийн хуулийн ажлын хэсгийг ахалж оруулж ирсэн, ажлын хэсгийг ахалж оруулж. Энэ хувьсгал. Эдийн засгийн хөгжлийн сайд байхаас би нэг зүйлийг онцолъё. Эдийн засгийн хөгжлийн сайд байхдаа төсвийн тэнцвэржүүлсэн орлого ДНБ-ий харьцааг 30 хувьд, 28 хувь хүртэл буулгах төсвийн хүрээг оруулж ирсэн. Яг энэний дагуу өнөөдөр хувийн хэвшилд орон зай бий болсон. Таны харин бантагнуулсан юмыг Гантөмөр дарга би буулгаж оруулж ирсэн юм. Буулгаж оруулж ирсэн, 28 он хүртэл 30 хувь хүртэл оруулж ирсэн. Тэгэхээр хариуцсан ажлаа хариуцлагатайгаар хийж ирсэн нь миний цаг үе. Өнөөдөр Ерөнхий сайдын ажлыг даваад би 80 хонож байна, тэгэхээр манайхан 80 хонож байна. Би 80 хоногийн дотор зүтгэж байна. Надад 80 хоног байна шүү дээ, би 80 хоногт олон жил дуусдаггүй яриаг дуусгах гээд явж байна. Тийм л юм байна.

Ж.Бат-Эрдэнэ: Суудал суудлаасаа ингээд хашхиралдах юм уу, гишүүдээ хүндлээд хэлэх боломжийг нь олгоё. Баатархүү гишүүн, наад хүмүүстээ саад болоод байна шүү дээ.

Ц.Баатархүү: Монгол Улсын Ерөнхий сайдын ярьж байгаа зүйл ярьж байгаа зүйлтэй нь статистикийн гаргаж байгаа мэдээлэлтэй асар их зөрж байна. Статистикийн газар энэ Ерөнхий сайдаа 1 дүгээрт зөв мэдээллээр хангах хэрэгтэй. Ядуурлыг 2 дахин бууруулна гэсэн энэ мөрийн хөтөлбөр огт биелээгүй. Өнөөдөр яг одоогийн байдлаар 10 хүний 30 нь ядуурлаас доод шугамд амьдарч байна, 27.9 хувьтай байна. 2 дугаарт, халамжаас хөдөлмөрт шилжүүлнэ гэдэг ийм уриатай орсон. 2015 оноос хойш халамжийн зардал 4.5 дахин нэмэгдсэн. Халамжид өгч байгаа 100 төгрөгийн 26 төгрөг нь эзэндээ очиж байгаа, 74 төгрөг нь эзэндээ очихгүй байна. Тэгэхээр 1 дүгээрт. халамж эзэндээ очихгүй байна, улам ядууруулж байна. 2 дугаарт. халамжаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил хийж байгаа хүмүүсийг дэмжих энэ бодлогыг сүүлийн 10 жил.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Суурь реформуудаа хийж байгаа юм. Суурь реформуудыг. Засгийн газар 80 хоногийн дотор Их Хурлын гишүүдийнхээ хамтаар ТӨК-ийн хуулийг ингээд бараг баталж байна. Энэ 100 хуулийг, хөрөнгө оруулалт, зөвшөөрөл, мэдэгдэл, энийг хэн өмнө нь баталсан юм, баталж байна. Энэ та бүхний гавьяа, 126 гишүүнтэй парламенттай болсны гавьяа. Би та нартаа их баярлаж байгаа. Хэрэгжүүлэх ажил надад үлдсэн, хэрэгжүүлэх ажил нь. Дээрээс нь татварын реформ, шударга тэтгэврийн тогтолцоо руу шилжье гэж олон жил ярьсан. Хэн хагас хуримтлал руу шилжих ажлыг парламент аль үед хийсэн юм, одоо орж ирж байна. Энэ та нарын гавьяа, энэ суурь реформуудыг хийж байгаа сайн хэрэг. Татварын ч бай, тэтгэврийн ч бай, энэ олон төслүүд, гацаа бүх юмнаасаа гаргана. Тэгээд 146 бизнесийн үйл ажиллагааг сая би нээлээ гээд байсан шүүдээ, 500 гаруй компани байгуулагдсан байна шүү дээ. Тэд нар чинь надтай уулзъя гээд явж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Өлзийхүүгийн Шижир. Таных сунгачихсан, нэг сунгачихсан, сунгачихсан. Шижир гишүүн. 2 минут, нэмэх нь 1 шүү.

Ө.Шижир: Ерөнхий сайд түрүүн яриандаа тэтгэвэр болон нийгмийн хамгаалал гэж ярьж байна лээ. Тийм учраас би танаас нийгмийн хамгааллын тал дээр хэдэн асуулт асууя. Дандаа дарга байсан хүмүүс сая энд алга ташаад зогсож байна. Амьдрал сайхан харагдаад байгаа л даа, энд алга ташиж байгаа хүмүүст. Сүүлийн 10 жилд дарга хийсэн хүмүүс дөнгөж одоо энд алга ташаад иргэдийн амьдрал сайхан байна гээд ичихгүй алга ташаад зогсож байна. Ичихгүй алга ташаад зогсож байна. Би тэгээд танаас нэг юм асууя.

Бүх насаараа төр, түмний төлөө зүтгээд тэтгэвэр, НДШ-ээ төлөөд, өнөөдөр тэтгэврийн хамгийн доод хэмжээгээр амьдарч байгаа 450 мянган иргэн байна, 793 мянган төгрөгөөр. Эхний асуулт та 793 мянган төгрөгөөр хэдэн хоног амьдрах вэ? Амьжиргаагаа залгуулах вэ нэг?

Ер нь би дахиад хэлье, хулгайлахгүй бол хүрэлцэнэ. Би энд сууж байгаа та нарт бүгдэд чинь хандаж хэлье. Хулгайлахгүй бол Монголд хүрэлцэхээр хэмжээний их хөрөнгө хөрөнгөжихөөр их баян орлого байна. Өнөөдөр нийгмийн амьдралын нөхцөл байдлыг та нар мэдэхгүйгээр энэ ордон дотор алга ташаад сууж байна. Та нар бүгдээрээ энд алга ташаад сууж байна. Өнөөдөр энэ дээр байгаа иргэдэд одоо та хэд хариул даа, 792 мянган төгрөгөөр Ерөнхий сайд хэд хоног амьдрах вэ? Хэлээрэй. Та нарын тэтгэвэр хүрч байгаа юу, орлого чинь хүрч байгаа юу? Ерөнхий сайдаа сая та сонсов уу. Би дахиад яриагаа дуусгая. Өнөөдөр ахмадууд тэтгэвэрт гараад шууд ядуурлын эгнээнд шилжиж байгаа. Өнөөдөр ахмадууд тэтгэвэрт гараад шууд ядуурлын эгнээнд шилжиж байгаа. Энэ та нарын буруу бодлогын үр дүн, хулгайлахгүй бол хүрэлцэх байсан. Өнөөдөр тэтгэвэрт гараад хэдэн ахмад шууд ядуурлын эгнээнд шилжиж байгаа вэ? Би танд нэг жишээ авч өгье. Тэтгэвэрт гараад машин Prius аваад, такси бариад амьдрал нь хүрэхгүй, хагалгааныхаа мөнгийг өөрөөсөө гаргасан тохиолдол байна, ЭМД-ын санд нь мөнгө байхгүй. Энэ тэгээд нийгмийн хамгааллын даатгал юм уу, энэ нийгмийн хамгаалал юм уу, ийм тэтгэврийн бодлого.../минут дуусав/

Н.Учрал: Өнөөдөр ингээд сонгууль болж байгаа юм шиг байх шиг байна. Шижир дарга та ч дарга байсан шүү дээ. Та бүр Хөл бөмбөгийн холбооны ч дарга байсан шүү дээ. Та чинь бүх юмны дарга байсан шүү дээ. 10 хүний 6 нь бага тэтгэвэр, доод тэтгэвэр аваад байгаа учраас шинэчилье гээд байгаа байхгүй юу. Тэгээд байгаа юм. Таны яг энэ үзэл санаа, зарчим, хүсэл эрмэлзэл, ард түмнээ

сайхан амьдруулъя гээд байгаа хүсэл эрмэлзлийг би асар их хүндэтгэж, яаж хийх вэ гэдэг арга замыг нь оруулж ирж байгаа юм. Энийг УИХ-ын гишүүд хийгээд өгвөл тэтгэврийн шударга тогтолцоо бий болно. Та бод, тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байгаа 57 хувийн 1/3 нь 25 жилээс дээш ажилласан байхгүй юу. 25-аас дээш жил ажиллачхаад тэтгэврийн доод хэмжээ аваад байгаа байхгүй юу. 13 оноос өмнөх нь сая 400-гаар, 18 оноос өмнөх нь 2 сая 400-аас цалин бодуулчхаад хэдхэн жилийн зөрөөн дээр тэтгэвэрт гарчхаад хоорондоо зөрөөд байгаа байхгүй юу. Энд 140 мянган хүн байгаа юм. Тэтгэвэр авагч 504 мянган хүн байгаа юм. Тэд нарт баталгаат тэтгэврийг ажилласан жилээр нь бодож хийхгүй бол энэ нийгмийн даатгалын сангийн чинь алдагдал жил ирэх тусам багасаад байгаа байхгүй юу.

90 оны бага төрөлтийн үеийнхэн чинь 60 оны их төрөлтийн үеийнхний тэтгэврийг нуруун дээрээ үүрээд явахаар, нөгөө 2 залуу хүн үүрээд явдаг байсан чинь одоо 1 залуу хүн үүрээд явахаар удахгүй сөхрөх гээд байгаа байхгүй юу. Нийгмийн даатгалын сан чинь 50 онд 40 их наяд руу хүрэх гээд байгаа байхгүй юу. Төсөв баталж чадахгүй болох гээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авагчдын 769 мянга чинь ард түмний амьдрал ахуйд, тэтгэвэрт гарсны төлөө амьдралынх нь баталгаа болж чадахгүй байна. Тийм учраас эд нарт 100-аас 300 мянган төгрөгийн ажилласан жилийнх нь уялдуулаад, индексжүүлээд баталгаат тэтгэврийг 504 мянган хүнд өгье, 504 мянгад. Үгүй ээ, наад 769-тэй чинь амьдарч чадахгүй, би шийдлийг нь яриад байна шүү дээ. Та зөв юм яриад байна, таны үзэл санаа зөв, надад шийдэх гарц байна. Тэгээд та нар баталж өгвөл би хэрэгжүүлнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Өлзийхүүгийн Шижир гишүүн.

Ө.Шижир: Уг нь энэ улс төрийн бодлогын мэтгэлцээн юм. Уран илтгэлийн мэтгэлцээн биш байхгүй юу. Хэн нэгнийгээ ямар нэгэн субъектив байдлаар дайрах биш юм. Тэгээд би танд маш тодорхой жишээ хэллээ шүү дээ. Би хааяа таксинд суудаг юм. Тэгээд таксинд суусан таксины жолооч намайг таньчхаад уурласан юм. Юу гэж уурласан бэ гэхээр 2 дугаар эмнэлэгт зүрхний стент тавиулахдаа тэнд даатгалын сангаас мөнгө байхгүй учраас өөрөөсөө сая гаран төгрөгөөр эм, эмнэлгийн тоног төхөөрөмжүүдээ аваад хагалгаанд орсон тухай ярьсан юм. Би таны яриад байгаа нийгмийн даатгалын хамгааллын хэлбэр чинь энэ мөн юм уу гэж асуугаад байгаа юм.

2 дугаарт, би таныг 793 мянга буюу тэтгэврийн доод түвшний хэмжээгээр хэд хоног амьдрах вэ гэж асууж байгаа юм. Яагаад гэвэл би таны бодит амьдралыг асуугаад байна шүү дээ. Тэгтэл одоо дахиад хэлье, танай энэ сайд нар амьдрал сайхан байгаа юм шиг алга ташчихаад сууж байна шүү дээ. Тэр дээр сая ярьсан иргэд та нарт шүүмжлэлтэй хандаж байна шүү дээ. Энэ чинь ганцхан бид нар биш байхгүй юу даа. Үнэн нүүр царайг чинь тэр дээр байсан 20, 30 хүн сая хэлээд өглөө шүү дээ, гараад явчихсан сая хүмүүс нь тийм.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Дээр ахмадууд байна, би тэтгэврийн шударга тогтолцоо руу шилжүүлбэ гэж энэ реформыг хийж байгаа. Илүү олон жил шимтгэл төлсөн нь илүү тэтгэвэр аваасай гэж бодож байгаа. Тэтгэврийн зөрөөг арилгах ёстой гэж бодож байгаа 13 оноос өмнө сая 400, 18 оноос хойш 2 сая төгрөг, энэ зөрөөг арилгах 140 мянга. Энэ ахмадаас гадна залуучуудад ч хамааралтай. Ирээдүйн 10 жилийн

хөдөлмөр чинь танд тэтгэвэрт гарсны дараа таны амьдралын баталгааг хангуулж чадах уу гэдэг асуултад бид хариулах ёстой байхгүй юу. Одоо хүмүүс яагаад тэтгэврийн насаа наашлуулаад эрт гаръя гэж байгаа юм. Илүү олон жил төлөөд өндөр тогтоохгүй юм чинь эрт гарсан дээр гэж үзэж байгаа. Тийм учраас 10 хувийн тэтгэвэр нэмлээ гээд таны яриад байгаа тэтгэврийн доод хэмжээгээ нэмж байгаа дээр 10 хувь, өндөр дээр 10 хувь нэмэхээр дахиад ялгаа үүсээд байгаа юм. Адилхан хөдөлмөр эрхэлсэн байна. Тэгэхээр тогтолцоог шинэчилж, Шижир гишүүнээ, би нөгөө И-Кабинет /E-Cabinet/ дээрээ өөрөө ингэж реал тайм /real-time/ мэдээлэл авч хардаг, ярьдаг хүн шүү, тэрийг ялгаарай. Би тэгж 10 хоногийн өмнөх мэдээллээр ярихгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Даваагийн Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Сайн байна уу, энэ өдрийн мэнд хүргэе. Энэ аудитаас авсан мэдээлэл, танай дарга нар мэдээллээ нууцлаад өгдөггүй, мэдэгдэл гаргахдаа сайн хэдэн компанитай гэдгийг өчигдрөөс хойш харлаа. Эрдэнэс Монгол буюу таны нэрлэдгээр Чингис хаан хөрөнгө оруулалтын сан гэж 65 сая төгрөгийн цалин авч байна, Эрдэнэс Критикал Минералс 44 сая, Төрийн үнэт цаас хэвлэл 38.3 сая, Шивээ-Овоо 31.6 сая, Диспетчерийн үндэсний төв 25.7 сая, Дарханы төмөрлөгийн үйлдвэр 24.5 сая, Барилгын хөгжлийн үндэсний төв 21 сая, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨК 20 сая, Эрчис ойл 19.5 сая, Эрдэнэс тавантолгой орон нутгийн өмчтэй нь 19.2 сая. Ингээд дунджаар нэг дарга чинь 30 сая төгрөгийн 1 сарын цалин авч байна.

Нөгөө талд нь дахиад энд нь байгаа, харагдаж байна уу. Нийгмийн халамжийн тэтгэвэр, би дандаа өндөр дүнгээр нь авсан шүү, 478 мянга, асаргааны тэтгэмж 330 мянга, онцгой тохиолдол болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж сая 200, хааяа л нэг өгдөг. Тэгээд эх, хүүхдэд олгох тэтгэмж 792 мянган төгрөгийг улиралд нэг удаа олгодгийг 700-гаар нь авсан байгаа. Эхийн алдар одонтой ээжүүд буюу 1, 2 дугаар одонтой ээжүүдэд 200, 400 мянган төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмж 100 мянга, ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт 230 мянга, насны хишиг 250 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт 250 мянга, өндөр насны тэтгэмж хамгийн ихдээ 700, хамгийн бага түвшин 792 мянга. Ингээд харьцуулаад харахаар нэг Монгол Улсын иргэн тэтгэмжээрээ 480 мянган төгрөг авч байна.

Асуулт нь, танай энэ дарга нар сайхан амьдарч байна 30 сая төгрөгөөр, иргэд 480 мянган төгрөгөөр, та өөрөө нөгөө нэг зах дээр очихдоо хэлсэн, гэдэс, цувдай авч билүү, ингэж хэлээд байна лээ. Тэгэхээр Монгол Улсын иргэд хэзээ танай намын энэ дарга нар шиг сайхан амьдрах вэ, паразит дарга нараа хэр удаан тэжээж явах вэ гэсэн энэ 2 асуултад хариулт өгнө шүү?

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Засгийн газрын дэвшүүлээд байгаа, шийдье гээд байгаа шийдлүүдийн оршлыг маш сайн тавих юм ер нь манай гишүүд. Би ахиад хэлье. Хэрвээ болж байсан бол би энэ ТӨК-ийн хуулийг хэлэлцэж өгөөч гэж гуйхгүй шүү дээ. Би болж байсан бол би тэтгэврийн хуулийг батлаад өг гэж гуйхгүй шүү дээ. Би болж байсан бол зөвшөөрөл, мэдэгдлийн хуулийг батлаад өг гэж гуйхгүй шүү дээ. Болохгүй байгаа болоод оруулж ирж байна. Таны ярьж байгаа яг зөв, болохгүй байгаа байхгүй юу. Болохгүй байгаа учраас, би болохгүй байгаа учраас энэ Чингис

хаан баялгийн сан болгосон шүү дээ, 260 орон тоотой болгосон шүү дээ. Монгол хүн оролцоод байгаа учраас, Монгол хүн наана чинь оролцоод байгаа учраас хамаарал оролцоод байна. Тийм учраас наадхад чинь ХОМК томилъё гээд би хуулийн дагуу яриад байгаа шүү дээ. Хөрөнгө оруулалтын сангийн хуулийн дагуу.

Тийм учраас ТӨК-ийн асуудлыг ярьж байна. ТӨК, Цогтбаатар гишүүн ийм байдаг. ТӨК бол, хувийн хэвшилд бүгдээрээ л KPI-аар үнэлүүлээд л, урамшууллаа аваад л явдаг зарчимтай. Үнэхээр ашиг орлого олоод, баялгийн санд орлого төвлөрүүлээд, ард иргэдэд түүнийг нь хүртээж өгөөж нь очоод байвал цалин урамшуулал авах нь нээлттэй. Гэтэл алдагдалтай байгаа бол ийм цалин авахыг би хэрхэвч зөвшөөрөхгүй. Тийм учраас ТӨК-ийн хуулиа баталчих, ТӨК-ийн хуулиа батлаад өгчих. Тэгээд ТӨК-ийн хуулийн дагуу би хэлсэн шүү дээ, ТӨК-ийн хуулийн дагуу би наадмаас өмнө гаднын менежментийг оруулж байгаад наадахыг чинь цэгцлээд өгнө, сюрприз барина гэж хэлсэн шүү дээ. Харин ар өврөөс янз бүрийн хүн амьтан яриад байв. Тэрийг хэлчихье. Янз бүрийн хүн амьтан яриад, зовоогоод, тэгээд ер нь тэгээд Монгол жижигхэн учраас, Монгол жижигхэн учраас Ерөнхий сайдын ажил зовлонтой юм байна лээ. Тэгээд хүн амьтан яриад, тэгээд маргааш нь оруулаад ирэхээр нөгөөдхийг нь дэмжээгүй болохоор ингээд эсэргүүцээд зовлон ихтэй. Тэгэхээр одоо битгий тэгээрэй, надад нэг жоохон хугацаа өгөөрэй л гэж хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Даваагийн Цогтбаатар гишүүн нэг минут сунгах юм уу? Саруулсайханы Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд. Би тантай далд халамжийн талаар ярих гэж байгаа юм. Ер нь МАН маань манай иргэдийгээ мэдээгүй байхад нь хүртэл халамжлаад явж байдаг. Тэгээд энэ хагас коксожсон түлшний талаар ярих гэсэн юм. Манай улс өөрөө нүүрсний арвин их нөөцтэй хэр нь Хятад улсаас нүүрсээ худалдаж авч өвөлждөг болоод жишиг тогтоод 2 жил болох гэж байна. Анх худалдаж авсан нийт хэмжээ нь болохоороо 360 мянган тонн байсан, нэг тонн нь 738 мянган төгрөгөөр хил дээр ирдэг юм байна. Тэндээсээ Улаанбаатар хотод ирэхдээ савлаад, ачаад орж ирэхдээ 1 сая 160 мянган төгрөг болчихож байгаа юм. Үүнийгээ иргэнд борлуулахдаа 200 мянган төгрөгөөр борлуулна, зөрүү 960 мянган төгрөгийг нь төр даадаг буюу татвар төлөгчдийн мөнгөөр энийг даадаг, энийг бид халамж гэж нэрлэж байгаа юм. Энийг хүмүүс мэдэхгүй ч гэсэн энэ өөрөө халамжийн хэлбэрээр явж байдаг.

Тэгээд өнгөрсөн жил нийтдээ 355 тэрбум төгрөгөөр Хятад улсаас бид бүхэн нүүрс аваад түлээд дуусгасан, энэ жил ахиад нийслэлийн төсөв дээр ахиад Хятад улсаас нүүрс худалдаж авна гээд 280 тэрбум төгрөгийг баталчихлаа. Энэ өөрөө яг үнэхээр бидний үндсэн бодлого мөн юм уу? Нөгөө өмнө чинь Тавантолгой түлш шахмал түлшний компани дээр чинь бүр жил болгон 200 тэрбум төгрөгийн бас ийм хэмжээний халамжийн зардал гараад, тэгээд нийтдээ 1.5 их наядын алдагдалтай болоод, дотооддоо ч үйлдвэрлэж чадахаа болиод, Хятадаас бид нүүрс авдаг болчихоод байна. Энэ өөрөө далд халамжийн нэг хэлбэр. Иргэдэд маань шууд бодит үр дүнгээ өгөхгүй. Улаанбаатар хот утаатай хэвээрээ байгаа. Тэгсэн хэдий ч ингээд явдаг. Ер нь би танаас асуумаар байна л даа. Энийг төр хийдэг буюу сүүлийн 10 жил дангаараа засаглаж байгаа МАН энийг удирдан зохион байгуулж, жил болгон 200 гаруй тэрбум төгрөгөөр энэ Улаанбаатарчуудын түлшний асуудлыг шийдсээр ирсэн. Та чөлөөлье гээд байгаа юм.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Агаарын бохирдлыг бууруулахад л хийж хэрэгжүүлж байгаа алхам, жигнэсэн нүүрсийг иргэдэд яг гэрт нь арай бага үнээр аваачихын тулд л төсөв дээр ачаалал аваад ирсэн юм байна лээ. Гэхдээ Багануур дээр пиролизийн үйлдвэр байгуулах ажлыг анх Гантөмөр дарга бид 2 ярьж эхэлсэн юм. Тэрнээс хойш хэдий ч удчихав. Тэгээд би энэ ажлыг явуулъя гэж бодож байгаа. Тийм учраас ирэх жилээс энэ ажлыг зогсоох ёстой, энэ гаднаас түлш авдгийг. Тийм учраас Багануурын Пиролизийн үйлдвэр дээр 350 мянган тонн нүүрсийг шинжлүүлээд сайн гэдэг дүгнэлт гарсан. Одоо Sinosure баталгаа гаргахаар шийдчихлээ. Сая Даляньд би Хятадын Ерөнхий сайдад энэ асуудлаа уламжилсан, болж байна. Ирэх долоо хоногийн 2 дахь өдөр Багануурын Пиролизийн үйлдвэр дээр ажиллаад, нээлттэй сонгон шалгаруулалтаа зарлаад, ирэх жилээс агаарын бохирдлыг бууруулах энэ жигнэсэн нүүрсийг Багануурын уурхайгаа түшиглээд би хийнэ гэдэг ийм бодолтой байгаа.

Ер нь түүхий эд үйлдвэрлэдэг түүхийг нь л арилгая л гэж ингэж зорьсон. Энэ жилийн хувьд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдсэн гэсэн сүүлийн би мэдээллийг авлаа. Хэрвээ ингээд шийдэхгүй бол өртөг нь иргэд дээр аягүй өндөр тусах юм байна лээ. Тэгэхээр Багануур дээр бид нөгөө нэг яг нөгөө хөх нүүрсийг жигнэсэн нүүрс хийхийн тулд намар амжихгүй юм байна. Тэгэхээр Багануурын пиролизийн үйлдвэрийг байгуулах энэ ажил дээр би дараагийн 2 дахид очно. Тэгээд энэ ажил дээр Цэнгүүн гишүүн өнөөдөр хамгийн ажил хэрэгч санал тавилаа. Тэгээд би өөрөөр чинь энэ ажлын хэсгийг ахлуулж ч болж байна. Багануурын Пиролизийн үйлдвэр дээр очъё, энийг би явуулна. Би Гантөмөр дарга байхгүй, гарчихлаа. Тэрнээс Гантөмөр дарга тааралдах болгондоо яриад байдаг. Тэгээд ерөөсөө хийе гэсэн хүсэл эрмэлзэл байгаа юм шиг байгаа юм. Тэгэхээр би хийж үзүүлье.

Ж.Бат-Эрдэнэ: Цэнгүүн гишүүнийг нэг минут сунгая.

С.Цэнгүүн: Тэгэхээр МАН-ын дарга Учрал Ерөнхий сайд сая хэллээ, МАН-ынхны атгадаг энэ түлшний сүлжээг таслан зогсоох юм байна гэж мэдэгдэж байна. Тэрэн дээрээ хүрсэн байгаарай. Энэхүү өвлийн дараагаас эхлээд энэ дээр тууштай хяналт тавьж ажиллана гэдгийг энэ ташрамд хэлмээр байна. Ер нь түүнчлэн энэ утааны асуудал бол эрчим хүчний хомсдол тэр чигтээ. Эрчим хүчийг бид бүхэн маань чөлөөт зах зээлийн зарчмаар явуулаагүйгээс болоод өнөөдөр эрчим хүчний дутагдалд орсон. Энэ өвөл ахиад эрчим хүч тасалдуулахгүй байхын тулд аукционыг маш хурдтайгаар зохион байгуулаад, шинэ станцууд орох ажлыг хурдтай зохион байгуулж байгаа гэдэг нь харагдаж байгаа юм. Гэсэн хэдий ч өнөөдөр төрийн өмчит эрчим хүчний компаниуд дээр байгаа бүтээмжгүй байдал арилаагүй байна, энэ өөрөө та энийгээ 100 хоног дотроо дагуулж шийдээд, бүтээмжгүй, орон тооны бус, сонгуулийн шахаагаар тавигдсан намынхаа гишүүдийг ажлаас нь халаарай гэж хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд нь нэг минут.

Н.Учрал: Ер нь дэлхийн бүх улс орон л утаатай тэмцдэг, тэгээд янз бүрийн шийдлүүдийг гаргадаг. Энэ халамж гэхээсээ илүүтэйгээр иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө хийж байгаа том алхам. Тэгэхээр энэ нийт өрхийн бараг 30 хувийг эзэлдэг юм байна лээ. Тэгээд энэ дээр тэр нийслэлийн төсөв дээр жоохон ачааллыг нь авахгүй бол тэрийг төлж чадахгүй, өвлийг давахад хэцүү ийм л зовлон байгаа

юм. Тэгэхээр яг энэ Цэнгүүн гишүүний хэлж байгаа шиг бид дотооддоо энэ нүүрс пиролизийн үйлдвэрийг байгуулж, дотооддоо түлшээрээ хангадаг зохицуулалтыг хийх ёстой, дэндүү их цаг алдсан. Тэгээд манай Засгийн газрын үед гангийн цогцолбор дээр 2 компани үлдчихлээ. Зэсийн цогцолборын чинь одоо компани шалгарчихлаа. Багануурын пиролиз дээр ингээд Sinosure баталгаа гаргачихсан, би шууд зарлана, нээлттэй зарлана. Тэгээд яг эрчим хүч дээр таны хэлж байгаа яг энэ хэмнэлтийг хийхээс өөр замгүй. Тийм учраас энэ нээлттэй auction-г 5 байршил дээр хийхэд үнэ хар даа, буухгүй гээд байсан 6-аас доош буучихлаа шүү дээ. Ингээд дахиад ADB-ийн 6-г бас нээлттэй зарлана. Ингээд л нууж хаах юмгүй л явъя.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвийн Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Эрхэм Ерөнхий сайд та сайн байна уу. Би энэ мэтгэлцээнийхээ өмнө ер нь ингээд нийгмийн хамгаалал, энэ халамж ярих энэ сэдэв дээр хамгийн түрүүнд надад бодогдсон зүйл энэ нийгмийн анги давхаргыг ялгаварлаад байгаа Үндсэн хуулиар хөрөнгө чинээ, ажил алба, албан тушаал, нас хүйс энэ бүх юм Үндсэн хуультай холбоотойгоор бид ер нь сүүлийн үед энэ Засгийн газар, үе үеийн Засгийн газар ялгаварлан гадуурхалт нийгмийн анги давхарга дээр үүсчихлээ гэдгийг хэлэх гэж байгаа юм. Жишээ нь Нийгмийн хамгааллын сайд, танай намын сайд Сарангэрэл гишүүний үед улны гэдэг ийм нэг шинэ давхарга бий болсон. Сүүлийн үед Алсын хараа-2050, тэгээд л энэ хөгжлийн бодлогын хөтөлбөр энэ тэр дээр нөгөө дунд давхарга гээд ороод ирсэн. Тэгээд яг ингээд дунд давхарга гээд ямар иргэдийг энэ давхаргад оруулаад байна вэ гэдгийг би хайж үзлээ. Үнэхээр энэ давхаргыг иргэд нь ямар орлоготой, ямар цалинтай, ямар ажил алба хашдаг, энэ орлогоос нь хамаараад энэ иргэдээ дунд давхарга гээд үзээд байгаа юм уу, та энийг ер нь дунд давхаргыг өөрөө нэг ингээд тодорхойлохыг нэг оролдох уу?

Тэгэхээр бид дундаж давхарга гэдэгт ямар иргэдийг хамааруулах вэ гэдгээсээ бид бодлогоо, тэтгэвэр, хөнгөлөлтүүдээ бүгдийг нь яриад явах юм шиг байгаа юм. Энэ сэдэв жоохон хөндүүр сэдэв байсан. Ер нь Статистикийн мэдээнээс ингээд харахаар Монгол Улсын ажилгүйдлийн түвшин ерөөсөө сүүлийн 3 жилд байнга өсөж нэмэгдсэн байна. 22 онд 5.1 хувь байсан, 24 онд 5.3 хувь болсон, 25 оны байдлаар 5.6 хувь болсон, 26 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар 5.7 хувьтай байна. Тэгэхээр Ерөнхий сайд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Дундаж давхарга гэдгийг улс орон бүр л янз бүрээр л тодорхойлдог. Гэхдээ таны яг хэлж байгаа шиг нийгмийн анги давхарга гэдэг зүйл Монголд байхгүй шүү дээ. Тэгж ярьж мэдээж болохгүй. Тэгэхээр л би нөгөө нийгмийн хамгааллын бодлого, халамж 2-ыг салгая гээд байгаагийн чинь гол зорилго нийгмийн хамгаалал чинь өөрөө амьдралын мөчлөг болгонд үүсэж байгаа, иргэдэд хүндээр тусаж байгаа тэр мөчлөгийг давах бодлого байхгүй юу. Нэг ёсондоо жирэмсэн байх үе, хүүхдээ төрүүлсний үе гээд энэ бүх цаг үе чинь амьдралын мөчлөгийг хамгаалах бодлого.

Нийгмийн хамгаалал, халамж гэдэг яг мөнгөн тэтгэмж ч гэдэг юм уу олгоод, яг тэр нөгөө ядууралд өртсөн тэр бүлгийг тодорхой хугацаанд халамжилж буцаагаад ажлын байранд зуучлах ийм л бодлого. Тийм учраас тийм анги давхарга гэж хэлж болохгүй. Зүгээр манай Засгийн газар энэ дундаж давхаргыг дэмжих л бодлогыг барьж байгаа учраас энэ чөлөөлье санаачилга гээд байгаа бол эдийн засгийн чөлөөлөлт гэдэг дандаа ажлын байрыг нэмэгдүүлэхтэй л холбоотой байхгүй

юу. Жишээ нь ингээд Нийгмийн даатгалын хуулийг би ингээд барилаа гэхэд Нийгмийн даатгалын хууль дээр чинь өндөр цалин өгвөл цалингийнхаа хэмжээгээр ажил олгогчийг чи өмнөөс нь шимтгэл төлөөрэй гээд торгоод байж болохгүй гээд байгаа байхгүй юу.

Жишээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний НДШ ажил олгогч төлж байгаа шүү дээ. Гэтэл тухайн хүнд компани урамшууллаа, цалингаа 10 сая өгчихлөө гээд яагаад 10 саяасаа төлөөд байгаа юм бэ. Энд нь чөлөөлөөд өгчихвөл тэнд дахиад тэр мөнгөөрөө шинэ хүн ажилд авна, ажлын байр нэмэгдүүлнэ гэдэг ийм бодлогыг оруулж ирэх гээд байна. Жишээ нь оюутан залуучууд тэр 22 нас хүртэл гээд л АН-ын гишүүд ч яриад байгаа чинь өөрөө шинэ ажлын байрыг бий болгох, ажил олгогчийг торгохгүй байх, ер нь энэ бүхий л хуулиуд, энэ концепцууд ингээд бүгдээрээ л ингэж уялдаж байж яг амь орох ийм л зорилттой байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Байгаа, нэг минут байгаа. Пүрэвийн Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Яах вэ, ойлгож байгаа. Нийгмийн анги давхарга гэдгийг энэ саяын юунаасаа гадуур ойлгож байна гэж та хариулж байх шиг байна. Салгаж ялгаж ойлгоно гэж байна. Гэтэл та 1996-аас 2000 онд АН тэтгэврийн тогтолцоог өөрчилж, нөгөө нэрийн дансны ийм тогтолцоонд шилжүүлж байсныг санаж байна уу? Эндээс ямар үр дүн гарч байсныг та сонирхож үзсэн үү? Энэ нэрийн данс гэдэг чинь юу гэж байгаа вэ гэхээр хөдөлмөр эрхлээд хуримтлал үүсгээд, иргэн хүн өөр дээрээ тэгээд даатгалтай, даатгал нь тэр хэмжээгээрээ нас нь өндөр болоод ирэх үедээ өөрийнхөө мөнгийг буцааж авч ингээд шударга ёсны ийм даатгалын тогтолцоог бий болгож байсан юм. Тэгэхээр одоогийн энэ үед энэ халамж, хавтгайрсан халамж ер нь сүүлдээ сонгуулийн схем, сонгуулийн хэрэгсэл болчихлоо. Уг нь хөдөлмөрлөх юуг дэмжих хэрэгсэл байсан байхгүй юу. Хөдөлмөр эрхлэх байдлыг дэмжих.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: 96 оныг санах нь ч хаашаа юм, би чинь 10 хүрээгүй байсан юм уу хаашаа юм, тэгэхээр судалсан юм гэж хэлье дээ. Тэгэхээр ямар ч байсан тэр санаж байна гэж худлаа яриад яах вэ, би судалсан. Нэрийн дансны аргаар би хэлье. Нэрийн дансны аргыг 208 мянган хүнээс наймхан хүн сонгосон. Энэ хийсвэр нэрийн дансны арга хамгийн буруу. Яагаад гэвэл 1960 оноос хойш төрсөн иргэд тэтгэвэрт гарахдаа нэрийн дансны аргаа сонго гэсэн, 208 мянган хүнээс 8 хүн сонгосон. Аргаа бараад 15 онд байна уу нөгөө 1979 оноос хойш төрсөн иргэд тэтгэвэрт гарвал нэрийн дансыг сонго гэсэн байхгүй юу. Тэгээд сонгоно гэхээр 78 онд төрсөн иргэд тэтгэвэрт гарахад 40 хувь нь өндөр тогтоогдоно тэтгэвэр. 79 оноос хойш төрсөн ахмадууд, ахмадууд гэж би ярьсан гээд хүмүүс шоолоод байна шүү дээ, 79 оноос хойш төрсөн иргэд хэрвээ тэтгэвэрт гарвал.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Батбаярын Жаргалан гишүүн. 1 минут шууд өгнө шүү.

Б.Жаргалан: Би 1 минутаа шууд авчихъя. Манай парламент сонгогдоод, тангараг өргөөд яг 2 жил болж байна. Тэгээд энэ цаг хугацаанд АН, МАН-ын үзэл санаа, сэтгэлгээний ялгааг өдөр бүр мэдэрч байгаа. МАН дарга төвтэй бүтэц бий болгодог, аль болох олон хүнд суртал бий болгодог, эрх мэдлийг дандаа төрд овоолж ирсэн. Харин АН бол Монголчуудынхаа авхаалж самбаа, идэвх санаачилга,

хичээл зүтгэлд итгэдэг. Эдийн засгийн эрх чөлөөтэй Монгол хүн ямар ч халамжид найдалгүй ажил хөдөлмөр эрхлээд, ашиг орлого олоод сайхан амьдарч чадна гэдэгт итгэдэг. Тийм ч учраас АН-ын гишүүний хувьд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг санаачилсан. Тэгээд ЗГ-аас Бизнесийн эрх чөлөөний хууль гээд яг саяын дурдсан тэр дарга төвтэй, хүнд сурталтай тэр бүтцийг тодорхой хэмжээнд задлах санаачилга ороод ирэхээр нь энэ асуудлаа хүлээн зөвшөөрч байгаа юм байна гэж бодоод, баярлаад 2 хуулиа нэгтгээд тэгээд өнгөрсөн хугацаанд Ерөнхий сайдын ажлын албатай хамт өдөржин шөнөжин л ажиллалаа. Тэгээд бид 2 хуулиа нэгтгээд, Эдийн засгийн эрх чөлөөний хууль гээд баталж байгаа.

ТӨК-ийн хууль дээр ч гэсэн дээ яг энэ үзэл санааны дагуу ТӨК-иудаа цөөлье, үсгэн байгуулах үндэслэлийг нь тодорхой болгоё гэдэг итгэлээр яг энэ ажлын хэсэгт нь ороод ажилласан. Гэтэл таны яриад байгаа чөлөөлье гэдэг санаачилга яг үнэндээ хоосон популизм биш, яг бодит ажил хэрэг болно гэдэг итгэл сая юун дээр нурж байна вэ гэхээр танай ЗГ-аас 2 хууль өргөн баригдлаа. Саяын Эдийн засгийн эрх чөлөөний хууль, ТӨК-ийн тухай хуулийн хамтаар Ашигт малтмалын тухай хуульд 2 тусгай зөвшөөрөл нэмчхэж байгаа юм. Орон сууцжуулалтын тухай хууль, Орон сууцжуулалтын тухай хууль бол маш их асуудалтай. Яаж байна вэ гэхээр Үндэсний орон сууцны корпорац гэдэг байгууллага байгуулна гээд бүр хуулиар тогтоочхож байгаа юм. Орон сууцны санхүүжилтийн банк байгуулна гэххэж байгаа юм. Тэгэхээр 1 гараараа Ерөнхий сайд Эрдэнэс Монгол дээр компаниуд татан буулгаад байна гээд яриад байдаг, нөгөө гараараа түүгээрээ орон сууцны корпорац байгуулах гээд байдаг, орон сууцны төрөлжсөн банк байгуулах гээд байдаг. Тэгээд энэ Орон сууцжуулалтын тухай хуулийг ингээд лавшруулаад уншихаар нийгмийн орон сууц, хөлсний орон сууц, хөлслөөд өмчлөх орон сууцны хөтөлбөрт иргэдийг хамруулахдаа хамруулах, эрэмбэлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн сайд нь батална гэххэж байгаа юм. Тэгээд энэ ийм барилгын салбарыг, орон сууцны салбарыг тэр чигээр нь ийм нийгмийн халамжтай, нийгмийн.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Жаргалан гишүүндээ их баярлаж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Цаг дуусаж байна уу.

Н.Учрал: Энэ Эдийн засгийн эрх чөлөөний хуулийн суурь үзэл баримтлалаа нэгтгэж, энэ хуулийг аль алиныг нь амилуулах, энэ 99 хуультай хамтатгаж хэд хоног л үдэш оройгүй ажиллаж, энэ хуулийг баталж байгаад би чин сэтгэлээсээ талархаж байгаа юм. Танай намд тан шиг ийм дэвшилтэт үзэл санаатай хүмүүс олон бий. Би үргэлж хүндэтгэдэг. Гэхдээ эрх барихаараа өөрсдөө манай намыг зүүн талаар нь тэргүүлээд явдаг шүү дээ, гүйцэд түрүүлдэг. 12-оос 16 оныг тод санаж байгаа. Тэгэхээр энэ дэвшилтэт үзэл санаан дээрээ хамт байж, улс төр бага ярьж, зөв зүйлийг нь зөв гэж явбал бид үр дүнд хүрнэ гэж бодож байгаа. Тийм учраас би тайлбар хэлье. Орон сууцжуулалтын банкны хуулийг миний Засгийн газрын хурал дээр ч гэсэн байр суурь болоод, хуулийн үзэл баримтлал энэ банк 34 хүртэлх хувь дээр буюу зөвхөн Golden Share л эзэмшинэ төр. Яагаад гэвэл ипотекийн зээлийн хөтөлбөр.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Уучлаарай цаг дууслаа, тэглээ. Цаг дууслаа. УИХ дахь МАН-ын бүлгийн асуултын цагийг хэлье. Соронзонболд гишүүнийг урьж байна. Ирж очих энээ тэрээ гэсэн цагууд, хугацаа гүйгээд байгаа юм байна шүү.

Л.Соронзонболд: Миний хувьд зүүн бүсээс сонгогдсон, тэгээд Хэнтий аймгийн Батноров сумын нутагт байдаг Бэрхийн уурхайд олон жил ажилласан. Тэгээд энэ ажиллаж байх хугацаандаа хөдөлмөрийн чадвараа алдсан, үйлдвэрээс хамаарсан осолд орсон гээд, амь насаа алдсан гээд ийм нэр бүхий 112 иргэний өргөдөл 2010 оноос хойш явсан юм байна лээ. Тэгээд энэ асуудал 2022 онд шүүхээр шийдэгдээд, ЗГ энэ улсуудын тэтгэмжийг олгох эсэх асуудлыг шийдвэр гарга гэдэг ийм шүүхийн шийдвэр гарсан, энэнээс хойш нэлээн олон жил өнгөрлөө. Энэ дээр ЗГ яагаад шийдвэр гаргахгүй байна вэ гэдэг ийм асуулгыг тавьсан байгаа. Энэний хариуг 1 дүгээрт авах юм?

2 дугаарт, болохоор Эрдэнэс Тавантолгой гээд манай төрийн өмчийн оролцоотой ХК маань нүүрсний борлуулалтыг уул уурхайн биржээр амжилттай борлуулж байгаа. Гэхдээ үүний хажуугаар нүүрс тээврийн салбарт болохоор үнэнд нь нөлөөлж, нүүрс тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 600 гаруй ААН, 10 мянга гаруй хувь машинаараа жолооч хийж байгаа иргэдийн бизнест нөлөөлөл үзүүлж байна гэж үзсэн. Тийм учраас энэ Төрийн худалдан авах ажиллагааны газраар дамжуулж, нүүрс тээврийн салбарын үнэд нөлөөлж, ноёлох үйл ажиллагаа явуулж байгаа учраас энэ дээр ямар арга хэмжээ авах вэ гэдэг асуудлаар 2 дахь асуултыг тавьсан байгаа? Тэгэхээр энэ асуулгынхаа хариуг авах гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Би энэ асуултын талаар мэдээлэл авсан. Энэ Бэрх болон Налайх, Шарын гол зэрэг уул уурхайнууд 90-ээд оны дунд үеэс хувьчлагдах, татан буугдах, дампуурах зэрэг шалтгаанаар үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон. Бэрхийн уурхайн хувьд 99 оны 2 сарын 6-ны өдрөөс Монголросцветмет нэгдлийн харьяаллаас тус уурхайг гарган, Бэрх уул ТӨХК болгоод өөрчлөн зохион байгуулж, Бэрхийн уурхайг 2004 он хүртэл Төрийн өмчийн хороо хариуцаж байсан юм байна. Ингээд 2003 онд Хэнтий аймгийн Бэрхийн уурхайд ажиллаж байсан 188 иргэнд 59 сая, 2007 онд 18 сая, 2011 онд 245 хүнд 68 сая төгрөгийг тус тус ЗГ-ын нөөц хөрөнгөөс олгож байсан. Бэрхийн уурхайд ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан иргэдэд шүүхээс 22 оны 570 дугаар магадлал шийдвэрлэснээр нөхөн төлбөр олгох эсэх асуудлаар ЗГ шийдвэрийг гаргах ёстой юм байна. Уг асуудлыг ЗГ 12 сарын 3-ны өдрийн 25 оны хуралдаанаараа хэлэлцүүлэхээр төлөвлөсөн байсан боловч хойшлуулсан. Би энэ асуудлыг 27 оны төсвийг өргөн мэдүүлэхийн өмнө ЗГ-аар шийдвэрлээд оруулж ирье гэдгийг танд хэлье.

Асуулт 2, тэр ЭТТ компанийн асуудал байгаа. Үүн дээр Монгол Улс нөгөө төсвийн хүрээг анх мэдүүлэхдээ 2025 онд нийт 90 сая тонн нүүрс экспортолсноос ЭТТ компани Хөрөнгийн биржээр борлуулсан нүүрсний 8.5 сая тонныг экспортолсон нь нийт нүүрс тээврийн 9.4 хувийг эзэлж байгаа. Тэгэхээр биржээр арилжаалсан нүүрсийг худалдан авагчид хүргэх, тээврийн үйлчилгээг гүйцэтгэх зорилгоор энэ төрийн өмчит, нөгөө тендерийн хуулиар, хуулийн дагуу ерөнхий гэрээний аргаар буюу ерөнхий гэрээ байгуулсан 221 аж ахуйн нэгжийн дунд ил тод, нээлттэй, хяналттай, зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд нийцсэн ийм сонгон шалгаруулалтыг зарласан. Тэгээд ЭТТ компанийн зүгээс 101.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Соронзонболд гишүүнд нэг минут.

Л.Соронзонболд: Тэрийг ойлгож байгаа, гэхдээ гол асуудал нь юу байна вэ гэхээр Монгол Улсад мөрдөгдөж байгаа Өрсөлдөөний тухай хууль байгаа. Энэ хуулиар болохоор бодит өртгөөс доогуур хэмжээнд оролцож, тухайн салбарын үнэд нөлөөлж байгаа асуудал нь өөрөө буруу байна гэдэг асуудал байгаад байгаа юм.

2 дугаарт, танай ЗГ-аас өргөн баригдсан Бизнесийн эрх чөлөөний тухай хууль дээр болохоор мөн адилхан төр хувийн сектортой өрсөлдөхгүй гэж байгаа. Тэгэхдээ төр өөрөө шийдвэр гаргахдаа хувийн компаниудын үйл ажиллагаа эрхэлж байгаа ашигт ажиллагаанд нь нөлөөлөөд байгаа учраас энэ асуудлуудыг яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр л гол асуулт тавиад байгаа юм. Тэгэхээр энэ дээр арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байна гэж харж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: ТӨК-ийн хууль хэлэлцэж байгаа. Дээрээс нь бизнесийн эрх чөлөөний, эдийн засгийн эрх чөлөөний хуулийг хэлэлцэж байгаа. Энхтүвшин гишүүн ажлын хэсгийн ахлагч, тэгээд мэдээлэл өгч байна. Ажлын хэсэг дээр яриад энэ тээврийг нь салгахаар зохицуулалтуудыг нь хийгээд явж байгаа гэж байна. Тэгэхээр хуулиараа энд салчихвал бид ч гэсэн ажлыг явуулахад их амар, хялбар болно. Би үүнд онцгой анхаарч ажиллая.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн гишүүн Жанчивын Галбадрах.

Ж.Галбадрах: Сайн байна уу, таны өдрийн амгаланг айлтгая. Улс орны хөгжлийн үндэс боловсрол. Энэ салбарт хийх шинэчлэлийг хөнгөн, хуумгай, яаруу сандруу, PR байдлаар ерөөсөө хийж болохгүй. Судалгаатай, эрэмбэ цэгцтэй, няхуур нямбай хийх учиртай. Тэгээд 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан асуудалтай холбогдуулж 3 асуулт байна. 1 дүгээрт, би байнга л ярьж байгаа сургуулийн хүртээмж, багшийн хомсдол яриад байгаа. Энд яагаад яриад байгаа вэ гэвэл энэ маань үндсэн суурь нөхцөл нь учраас энийг бид хийхгүйгээр цаашаа ямар ч шинэчлэл байхгүй. Өнөөдрийн байдлаар бид яам маань судалгаагүй эхлүүлээд байна уу, энд би санаа зовж байна. Тэгээд их өгөгдөл ашиглаж байгаа гэх боловч тэр нь их зөрөөтэй, алдаатай байна. 40-өөс дээш хүүхэдтэй бүлэгт сурч байгаа 210 мянган хүүхэд, 29 хувьтай, 150-иас 500 хувьд даац нь хэтэрчихсэн сургуульд 380 мянган хүүхэд буюу 50 хувь нь сураад байгаа юм. Тэгэхээр энд хүүхдийн эрх маш их ноцтой зөрчигдөж байна. Тэгэхээр 108 сургууль, 95 цэцэрлэгийг шинээр барья гээд Лувсанжамц гишүүн бид хэд ингээд төлөвлөгөө гаргаад ингээд явсан. Тэгээд энэ төлөвлөлт их алдагдсан байдалтай орж ирсэн, АХБ-ны хөнгөлөлттэй зээл зориулалтын бусаар орж ирж байна. Энийг асуух гэсэн юм танаас?

Багш хангалттай болчихсон, 85 хувийн мэргэжлийн багшаар хангагдсан, бага ангийн багш бараг ихэднэ гээд байхад л 6300 багшийн хомсдол байгаа. Би ийм тооцоог хийхчээд байгаа юм. Тэгээд энэ төлөвлөгөөнд нэг ч төгрөг багшийн хомсдолд зарцуулахгүй байна. Тэгээд 1 багш 1 компьютер гээд, хиймэл оюун гээд ийм цахим шилжилтэд орох зүйл дээр их бид ийм төлөвлөлт гаргажээ, энэ дээр 810 тэрбум төгрөг зарцуулж байгаа, яам өөрөө хүртэл chromebook үйлдвэр барина гээд байгаа. Гэтэл дэлхий нийтээрээ энэ цахим шилжилтээс татгалзаад байгаа. Нэг аймагт нэг Кембридж сургууль гэсэн зүйл миний 3 дахь асуулт, Кембриджийн 3

сургууль байгаа, энэ маань 1.5-д багш нь 50 хувийн нэмэгдэлтэй, хувьсах зардал нь 3 дахин их ийм ялгарлыг төр өөрөө ингээд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Галбадрах гишүүн бүлэг дээр танилцуулж байсан 2030 он хүртэл нийт 108 сургууль, 95 цэцэрлэгийг барих, өргөтгөх шаардлагатай гэсэн тооцооллыг та их өгөгдөл дээр сууриалаад гаргаж үзүүлсэн. Би энэ зарчмыг Ерөнхий сайдын хувьд барьж ажиллана. Энэ жил улсын хэмжээнд нийт орон нутгийн төсөв болоод улсын төсөв, гаднын зээл, тусламжаар нийт 53 сургууль, 33 цэцэрлэг ашиглалтад орно. АХБ-ны болон Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр 33 цэцэрлэг, сургууль, Дэлхийн банкныхаар 43 сургууль, нийслэл, орон нутгийн төсвөөр 18 сургууль, цэцэрлэг энэ 30 хувь хүртэлх зорилтод хүрэхийн тулд орно гэсэн үг.

Тэр цахимжилтын асуудал юу юм бэ гэхээр ер нь энэ нөгөө гэртэй ойрхон сургууль хамгийн сайн сургууль гэдэг зарчим буюу анги дүүргэлт их өндөр байхаар заавал туслах багшгүй болохоор хүүхэд болгонд мэдлэг очиж хүрэхгүй байна. Тийм учраас энэ хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр илүү ажиллая гэдэг зорилгыг агуулж байгаа. Тэр хүрээндээ Google Chrome-н notebook-г бид сургуулиуд дээр ширээ болгон дээр, хүүхэд болгоны ширээн дээр тавиад үүгээрээ дамжуулаад Боловсролын яамны хэрэгжүүлж байгаа Мэдлээ, Pearson энэ тэр гээд хөтөлбөрүүдийг гүүглээр нь дамжуулаад, cloud-р ингээд мэдээллийг нь өгөөд явбал хөдөө орон нутагт ч гэсэн, сумд ч гэсэн хүүхдүүд тэр мэдээллийг авах бололцоог нь бүрдүүлбэ гэж зорьсон. Энийг Хөгжлийн банкнаас бид нөгөө лизингийн /leasing/ зарчмаар хүүхэд болгонд ингээд хүргэх гэж байгаа юм.

Тэр угсрах үйлдвэр барих асуудал үнийг бууруулах гэж байгаа зорилготой, төр огт тийм үйлдвэр барихгүй. Google Chrome notebook-г тэр угсрах үйлдвэрийг гаднын талынхан өөрсдөө угсрах үйлдвэрээ барья гэдэг саналуудыг хэлж байгаа юм. Тэгээд 1 ч гэсэн угсрах үйлдвэр барьж, ажлын байрыг нэмэгдүүлэх сайн төсөл болно гэж итгэлтэй байгаа. Тэрнээс төр барихгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Галбадрах гишүүнд нэг минут.

Ж.Галбадрах: Тэгэхээр тэр Кембриджийн сургуулийн хувьд ч гэсэн үзэхэд бид туршаад хэрэгжүүлээд олон жил болчихсон. Тэгвэл энэ дотооддоо нутагшчихсан байж байгаа энэ юмыг заавал бид энэ гадаадаас өндөр төлбөр төлж энэ төсөл, хөтөлбөрүүд аваад байх хэрэг байна уу? Өнөөдөр Монгол нутагт суурьшихсан багш, эрдэмтдийнхээ итгээд энийгээ дэлгэрүүлж явах энэ арга хэмжээ. Нөгөө талаас энэ хийж байгаа энэ шилжилтүүд ерөөсөө компьютер та авна л гэж байна. Тэгээд энэ чинь 3 жилийн дараа ахиад солигдох ёстой. Тэгэхээр энэ Төрийн хэмнэлтийн хуулийн үзэл санаа нь ч гэсэн хэт ийм үрэлгэн байдлаар, ийм сонголтгүй тулгаж байгаа хэлбэр ажиглагдаад байгаа. Тэгээд гол нь хүртээмж, багшийн дутагдал, цалин хангамж, ачаалал, сурах бичиг зэрэг ийм санхүүгийн ач холбогдолтой маш үндсэн зүйлүүд байгаа юм руугаа бид эрэмбэлж эд нартаа нэг номерт тавьж явах ёстой. Энэ дээр бид хамтдаа анхаараад, тэгээд л боловсролын салбараа чанартай сургалт өгч байж л Монгол Улс хөгжинө. Энэ ядуурлаас гарах ч хамгийн ганц гол гарц гэдэгтээ бид бүрэн итгэх ёстой гэдгийг л хэлбэ.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ гүүглийн /Google/ угсрах үйлдвэр барина гэдэг гаднын хөрөнгө оруулагч нар өөрсдөө хүсэлтээ тавиад, үйлдвэр байгуулбал өртөг нь буурна гэдэг маш сайн жишиг шүү дээ. Төв Азийн Монголыг сонирхоод гүүгл /Google/ угсрах үйлдвэрээ барина гэвэл энэ гүүглийн /Google/ анх салбарыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд байхдаа анх энэ салбарыг нь байгуулж мянган төгсөгч бэлдчихээд байгаа юм. Тэгэхээр энэ сайн буюу суманд, алслагдсан сумд, алслагдсан аймаг, орон нутагт тэр Google Chrome тавиад мэдээлэл аваасай л гэж би хүсэж байгаа юм.

Кембриджийн хөтөлбөр гэдэг Кембридждээ биш, дэлхий даяар IGCSE, A Level, AS Level-ийн хөтөлбөрийг явуулдаг Кембридж шиг олон тийм professional body гэж нэрлэдэг байдаг. Эдгээрийн нэг нь л Кембридж. Тэгэхээр тэр хөтөлбөрийг явуулах эрхийг аваад энд явуулж байвал ядаж төгсөөд нөгөө нэг тэтгэлэг авах, гадаад, дотоодод сурах боломж нь малчин ардын хүүхдүүдэд ч гэсэн бий болоосой.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: МАН-ын бүлгийн цаг дууслаа. Цөөнхийн гишүүдийн цаг эхэлж байна. ХҮН намын зөвлөлөөс Уянгахишиг гишүүн. Энхнасан гишүүн хариулах уу, асуух уу?

Л.Энхнасан: Өдрийн мэнд Ерөнхий сайдаа. Өнөөдөр Монгол Улсын нийгмийн даатгалын сан олон жилийн туршид алдагдалтай ажиллаж ирсэн. Энийг та ч болон гишүүд зөвшөөрч байна. Тэгээд хүн амын насжилт, шимтгэл төлөгч ба тэтгэвэр авагчийн харьцааны өөрчлөлтөөс шалтгаалан энэ дарамт цаашаа улам нэмэгдэхээр байна. Засгийн газрын танилцуулгад 2050 он гэхэд нэг тэтгэвэр авагчид ногдох шимтгэл төлөгчийн тоо 2.1-ээс 1.2 болж буурч, улсын төсвөөс нийгмийн даатгалын санд олгох санхүүжилт өнөөдрийн 1.6 их наяд төгрөгөөс 10.7 их наяд төгрөгт олгох ийм эрсдэлтэй тооцоо харагдаж байна.

Тэгвэл өнөөдөр өргөн барьсан байгаа Нийгмийн даатгалын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийг та энэ бүтцийн асуудлыг шийднэ гэж үзэж байна уу, нийгмийн даатгалын сан урт хугацаанд санхүүгийн хувьд тогтвортой болох шинэчлэл гэж үзэж байна уу? Мөн эсхүл энэ зөвхөн одоогийн тогтолцоог богино хугацаанд тогтон барих арга хэмжээ бөгөөд цаашид хуримтлалд суурилсан олон тулгуурт тэтгэврийн тогтолцоонд илүү зоригтой, үе шаттай шилжих зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна уу? Энэ асуудлаар Засгийн газрын тодорхой байр суурийг сонсьё.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ Засгийн газрын чөлөөлье бодлого ерөөсөө л ажил эрхлэлтийг л их өндөр байлгах. Тэгж байж хөдөлмөрийн орлого өндөр байна, тэгж байж GDP рүүгээ нөлөөлнө, тэгж байж өрх рүү орно гэдэг зарчим. Тийм учраас нийгмийн даатгалын реформ, шинэчлэл гэдэг илүү хөдөлмөр эрхлэлтийг дэмжих мотивац өгөх ийм зорилготой. Нэг ёсондоо нийгмийн даатгалын сангийн алдагдал яагаад жил ирэх тусам нэмэгдээд байна вэ гэвэл хүмүүс илүү олон жил хөдөлмөрлөө, НДШ төлье гэдэг ямар ч сонирхолгүй болсон. Ингээд бүлэг бүлгээрээ тэтгэврийн насыг наашлуулж өгөөч л гэж байгаа. Буруу биш. Яагаад гэвэл илүү олон жил төлбөл бидэнд өндөр тэтгэвэр тогтоохгүй шүү дээ. Энэ шимтгэл надад ямар нэмэртэй юм бэ? Тэгэхээр бид илүү олон жил төлснийг нь урамшуулах тогтолцоо руу даруй шилжих ёстой.

Тийм учраас 35 жилээс дээш ажиллаад тэтгэвэрт гарч байвал цалингийн 67 хувиар тогтдог байсныг 72.5-аар тогтоохыг энд хуульчилж өгсөн. Дээрээс нь хэрвээ 57 настай эмэгтэй 60 настайдаа тэтгэвэрт гаръя гэвэл 4, 4 хувиар нэмэгдээд, 60-тайдаа гарвал 12 хувийн нэмэгдэлд тооцож, тэтгэвэрт өндөр тэтгэвэр тогтооно гэж зорьж байгаа. Дээрээс нь энэ НДШ хэдэн жил төлснөөсөө шалтгаалж өндөр насны тэтгэвэрт гарсных нь дараа та 10 жил ажилласан юм байна, танд баталгаат тэтгэврээс 120-ийг өгье, 15 жил ажилласан юм байна, танд 140-ийг төлье гээд ажилласан жилээс нь шалтгаалж шууд бүгдэд нь баталгаат тэтгэвэр өгөх буюу энэ тэтгэврийн тогтолцооны шинэчлэл явснаар 504 мянган тэтгэвэр авагч 100-аас 300 мянган төгрөгийн тэтгэврийг бүгдээрээ нэмэгдүүлж авна. Дээрээс нь тэтгэврийн зөрүү гээд байгаа тэр 13, 18 оны цалингийн зөрөөнөөс болчихсон хэсэг тэр зөрөөн дээр тодорхой дэвшил гаргаснаараа 140 мянган хүнийг хамруулна. Тэгэхээр энэ тогтолцоо явснаараа шимтгэл төлөх сонирхол нэмэгдэнэ. Жишээ нь хувийн секторынхон шимтгэл төлье гээд ирвэл 24 сар хүртэл хугацаанд 50 хувь чөлөөлчихнө, хөнгөлчихнө. Тэгэнгүүт шимтгэлээ төлж эхэлнэ. Ингээд эхлэхээр алдагдал үе шаттай буурна.

Ж.Бат-Эрдэнэ: Энхнасан гишүүн, Лутаагийн Энхнасан.

Л.Энхнасан: Тэгэхээр та энэ шинэчлэлийг энэ урт хугацаандаа нийгмийн даатгалыг тогтвортой байлгана гэж үзэж байна уу? Тэгвэл энэ нийгмийн даатгалын төсөлд баталгаат тэтгэвэр гэсэн шинэ төрлийн тэтгэврийг нэвтрүүлж байгаа. Энэ шимтгэл төлөлтөөс үл хамааран төсвөөс санхүүжүүлэх тийм шинжтэй учраас энэ НДШ төлсөн хэрэгслээсээ үр шим хүртэнэ гэсэн энэ үндсэн зарчмыг зөрчиж байгаа гэж харагдаж байгаа, тогтолцоог халамжийн чиглэл рүү илүү явуулж байгаа юм уу гэж харагдаж байна. Тэгэхээр нөгөө талаас УИХ-д Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хэлэлцэж байгаа. Гэвч энэ нь зөвхөн сайн дурын нэмэлт хуримтлал бөгөөд нийгмийн даатгалын үндсэн тогтолцооны санхүүжилтийн тогтвортой байдлыг шийдэхгүй гэж харагдаж байна. Тэгэхээр ЗГ цаашид НДШ-ийн тодорхой хувийг үе шаттай өөрчлөх, эсхүл хуримтлалын дансанд төвлөрүүлэх ийм бодлогыг дэмжих үү?

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд.

Н.Учрал: НДШ төлнө гэдэг хөдөлмөрлөсөн хөлснийхөө тодорхой хувийг санд өгөөд, тэтгэвэрт гарсны дараа надад эргэж ирнэ гэдэг зорилгоор иргэд төлж байгаа, төсвөөс 100 хувь санхүүжнэ гэсэн үг биш. Тэгсэн мөртөө өнөөдөр нөгөө хүн ам зүйн насны бүтцийн хувьд яг нөгөө бага төрөлтийн үеийнхэн их төрөлтийн үеийнхний тэтгэврийг барагдуулаад яваад байхаар, намайг 2020 онд ажлын хэсэг ахалж байхад 3 залуу 1 хүний тэтгэвэр гэж байсан, одоо 2 залуу 1 хүний тэтгэврийг барагдуулж явж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нөгөө олон тулгууртай болгоё, хагас хуримтлал руу шилжүүлбэ гэж байгаа юм. Хуримтлалыг нь, өгөөжийг нь хүртээдэг болгоё, хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо руу явуулъя. Дээрээс нь нийгмийн даатгалын сангийн алдагдлыг үе шаттай бууруулахын тулд бид ингэж байгаа, нийгмийн даатгалын санд 6 их наяд орчим хэрэгтэй байгаа байхгүй юу жил болгон, тэрний чинь 1.6-г нь төсвөөс тавиад байгаа байхгүй юу. Үлдсэнийг нь иргэд өөрсдөө хуримтлуулж байгаа шүүдээ. Тэгэхээр тэр баталгаат тэтгэвэр төрийн мөнгө биш, тэр өөрийнх нь олон жил ажилласны урамшуулал.

Ж.Бат-Эрдэнэ: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр ер нь өнөөдөр нийгмийн даатгалын талаар нэлээн асуулт явчихлаа. Тэгээд сая бид өнөөдөр үдээс өмнө хүн амын, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг баталчихлаа. Тэгээд үүгээр нэг шатлал нэмэгдүүлсэн, үүнээс цаашаа улбаалаад яг процессын шинэчлэл, ер нь тогтолцооны шинэчлэл гэдэг юм хийх төлөвлөгөө байгаа юу? Өөрөөр хэлбэл бид И-Монголиа /E-Mongolia/ бий болголоо, И-Баримт /E-Barimt/ бий болголоо, И-Такс /E-Tax/ бий болголоо. Дээрээс нь хувь хүн жил болгон өөрийнхөө тайланг гаргах үүрэгтэй болсон. Тэгэхээр энэ үүрэгжүүлэлт болон энэ бүх цахим бүртгэлүүдийн үндсэн дээр автомат цахим хасалтуудыг хийх боломж үүсэж байгаа гэсэн үг. Тэгэхээр хувь хүн орлогын албан татвар төлөхдөө орлого нь тодорхой байна, дээрээс нь хасагдах зардлуудыг бид тодорхойлж гаргаж чадах болж байгаа юм.

Тэгэхээр үүн дээрээ үндэслээд жишээлбэл, түрээсийн орлого эсвэл ипотекийн хүү, дээрээс нь улсын итгэмжлэгдсэн сургуульд сурч байгаа хүүхдийн сургалтын төлбөр, мөн хүнсний сагсан дэх бүтээгдэхүүний худалдан авалт гэдэг юм уу, иймэрхүү байдлаар яг хасагдах зардлуудыг тодорхойлж оруулаад тэр нь өөрөө автоматаар нөгөө И-Баримтаас, нөгөө И-Монголиагаас татагдаж ордог болоод эхэлбэл энэ нь хувь хүн болгон дээр жишээлбэл, тодорхой нэг Х дүнгээр хасна гэдэг ерөнхийлсөн хасалт биш, тухайн хүн хэрэглээн дээрээсээ өөрийн, жишээлбэл 2 сая хүртэлх цалинтай хүн илүү гаргаж татвар төлөх мөнгө бараг үлдэхгүй, 3 сая хүрэхэд ч бараг үлдэхгүй гэсэн үг. Тэгэхээр иймэрхүү нөхцөл байдал руу, иймэрхүү тайлагналын систем рүү оруулах тийм төлөвлөгөө байна уу? Үүн дээр энэний давуу тал үүсэх нь болохоор нөгөө эрсдэлийн хяналтыг тавьж чадна. Орлого, зардал бүртгэлжих боломжийг гаргана, дээрээс нь хувь хүн болгон дээр татварын зардлаа тайлагнадаг болоод эхэлбэл нөгөө санхүүгийн хариуцлага чинь нэмэгдэж орж ирж байгаа юм. Хэрвээ зардлаа тайлагнаж чадахгүй бол.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь жил болгон бид төсөв барихдаа ийм орлого, зарлагын бүртгэлтэй л нэг ийм төсөв бариад байна л даа. Тэгээд энэ төсөв бол өөрөө энэ төсвийн бодлого, өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль үнэхээр хоцрогдсон. Бид яаралтай ядаж хувийн компани, жишээ нь манай компани хэдий хэмжээний хөрөнгөтэй юм эд нарыгаа тодорхойлж байж, орлого, зарлагаа тавьж байж төсвөө баталдаг. Тэгээд одоо гишүүдийн яриад байгаа тэр аккрузал суурь руу орох ёстой гээд байгаа бол би зарчмыг маш зөв гэж бодож байна. Энд тэгэхдээ мэдээж нэг багадаа 5 жил хэрэгтэй. Тэгэхээр намрын төсөв дээр энэ алхмаа хийе. Ядаж төр хөрөнгөө тоолъё гэдэг.

Тийм учраас таны яг ярьж байгаа энэ цахим системийн хувьд бид бэлэн. Жишээ нь, НӨАТ-ын системийг олон жил хувийн хэвшлийг хүртэл оролцуулж байж шийдлээ шүү дээ. Түүний хүчинд өнөөдөр ЗГ-ын гишүүд, УИХ-ын гишүүд ч гэсэн, би УИХ-ын дарга байхдаа өгсөн тэр dashboard дээр real-time-р мэдээлэл харж байгаа. Өнөөдөр тэр аймагт тэр бараа бүтээгдэхүүний үнэ ямар байгаа юм, гаалиар хэдэн машин гарсан юм, хэдэн тонн нүүрс тээвэрлэсэн юм бэ гэдгийг бүр яг реал таймаар харж байгаа. Энэ НӨАТ-ын системийн data exchange хийж байгаа мэдээлэл. Яг үүнтэй холбогдуулаад энэ эдийн засгийн эрх чөлөөг дагасан 99 хууль дээр цахим ашиглаж, татвар, халамж, бусад эдийн засгийн бодлогыг их өгөгдөлд суурилж шийдвэрлэнэ гэдэг заалтыг биччихсэнд би их олзуурхаж байгаа. Энэ цахим шилжилтийн цэг хатгаж байна гээд би хэлээд байгаагийн шалтгаан. Тэгэхээр энэ

хууль гарчихсанаар цахимаар компаниа ч байгуулна, хяналтаа ч тавина, эрсдэлээ ч үнэлнэ. Эрсдэл үнэлчихсэн байхад зөвшөөрөл нь ч сунгагдана, хяналтын систем ч тодорхой байна. Үүнийг хэн нэгнээс асуугаад байх шаардлагагүй. Энэ тохиолдолд төрийн алба тайлан тавиад, энд орж ирж гүйцэтгэл тавиад ямар ч шаардлагагүй болчихож байгаа юм. Тэгээд торгууль, зөрчил бүх асуудал системээрээ л шийдэгдээд л явчихдаг байвал ийм.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахишиг гишүүний нэг минут.

Г.Уянгахишиг: Яг миний асуугаад байгаа юм болохоор хувь хүн орлогоо тайлагнадаг, тэрнээсээ татвараа төлдөг. Тэгвэл хувь хүн тэр орлогоосоо энэ системүүдээр баталгаажчихсан тэр зардлаа хасдаг болж болохгүй юу? Тэр зардлаа хассаны дараа татвараа төлдөг, татвар ногдох орлого нь тодорхойлогддог тэр боломжийг бий болгооч гээд байгаа юм. Тэгэхээр бид өнөөдөр төсөв бүрдэхгүй байна гээд байгаа. Тэгээд татварынхаа хэмжээг буулгаж чадахгүй байгаад байгаа. Гэтэл энэний чинь нөгөө талынх нь боломж нь болохоор далд эдийн засгийг ил болгох ёстой. Тэгэхээр нөгөө хувь хүмүүс зардлаа тайлагнадаг болгоод, түүгээрээ орлогын татвар нь багасдаг болоод эхэлбэл нөгөө талдаа орлого олж байгаа субъектүүд чинь тодорхой болоод эхэлнэ. Жишээлбэл, ямар хүн түрээслүүлээд орлого олоод байгаа юм гэдэг чинь мэдэгдэж эхэлнэ шүү дээ. Яагаад гэвэл иргэд өөрсдийнхөө түрээсэлсэн түрээснийхээ зардлыг хасдаг болно гэсэн үг. Нөгөө нэг сагсны худалдан авалт буюу наад захын мах, сүү, гурил, будаагаа авсан тэр зардал чинь хасагддаг болог л доо. Тэгвэл тэрний чинь цаана орлого олоод байгаа субъектүүд чинь маш тодорхой болж эхэлнэ. Энэ нөгөө хувь.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Уянгахишиг гишүүний ярьж байгаа маш зөв. Ер нь энэ татварын бааз сууриа өргөтгөх нь л бидний зорилт. Тийм учраас та бүхэн анзаарсан бол Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулиуд дандаа энэ бааз суурийг өргөтгөх зорилготой. Нийгмийн даатгалын хууль ч гэсэн аль болох хувийн секторт байгаа бол 2 жил төлбөл та 5 хувийн шимтгэлээс чөлөөлөгдөнө шүү, ажил олгогч талд нь ч гэдэг юм уу ингэж татан оролцуулж, бааз сууриа өргөтгөх зорилгоор дандаа оруулж ирсэн. Татварын хууль дээр ч тэр. НӨАТ-ын суутган төлөгчийн босгыг 400 сая болгосон дээр зарим хүмүүс эсэргүүцэж байсан. Гэхдээ бид системийн хувьд бэлэн байхгүй юу. Түүнийг хурааж аваад буцаагаад буцаалт хийх бүрэн бололцоотой. Ингэж байж 23 мянган компани бий болно. Тэгэхээр илүү нөгөө хамрах хүрээгээ өргөжүүлэхийн тулд л энд анхаарах ёстой. Тэгэхээр хасагдах зардлуудыг хууль дээр тодорхой заачихсан байгаа. Тэгэхээр бидэнд системийн хувьд бүрэн боломж байгаа. Тэгэхээр та бүхэн дэмжвэл ингээд яг заалт болгон дээр нь, заалтууд дээр өөрчлөлт хийчихвэл.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: УИХ-ын хэлэлцүүлгийн цаг дууслаа. Ерөнхий сайдад баярлалаа.

15.43 цаг

**Арван найм.Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх
Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт**

Дараагийнхаа асуудалд оръё. Нийслэлийн 2024-өөс 2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэнэ. Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Энхтүвшин таныг индэрт урьж байна.

Д.Энхтүвшин: УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2.2 дахь заалт, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119.1.2-т заасныг үндэслэн УИХ-ын гишүүн Золжаргал нарын 25 гишүүнээс 2026 оны 5 сарын 1-ний өдөр Нийслэлийн 2024-өөс 26 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдвээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлт гаргасан.

УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2.2-т заасны дагуу УИХ-ын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тул УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2026 оны 5 сарын 19-ний өдрийн ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай 02 дугаар тогтоолоор Нийслэлийн 2024-өөс 26 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдвээр ерөнхий хяналтын сонсголыг 6 сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулахаар тов гаргаж, сонсгол даргалагчаар УИХ-ын гишүүн Золжаргалыг томилсон болно.

Төсвийн байнгын хорооны 2026 оны 5 сарын 19-ний өдрийн 03 дугаар тогтоолоор уг сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, ажлын хэсэгт УИХ-ын гишүүн Алтаншагай, Батболд, Баярмаа, Бум-Очир, Заяабал, Золжаргал, Лодойсамбуу, Сайнзориг, Хэрлэн, Да.Цогтбаатар, Энхтүвшин нар ажилласан.

Нэг.Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд: 1.Нийслэлийн 2024-өөс 26 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдэвт ерөнхий хяналтын сонсголын зарыг Монгол УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 121.2-т заасны дагуу 2026 оны 5 сарын 21-ний өдөр d-parliament.mn цахим хуудаст байршуулсан. 2.оролцогчдыг Монгол УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 121.11-д 14-өөс доошгүй хоногийн хугацаанд бүртгэнэ гэж заасны дагуу 6 сарын 10-ны өдрийн 17:00 цаг хүртэл бүртгэсэн. 3.Нийслэлийн төсвийн зарлагад хяналт хийх асуудлаар холбогдох төрийн байгууллагуудаас баримт бичиг гаргуулан авч, нотолгоонд суурилсан дүн шинжилгээ, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн 10 шинжээчийг Төсвийн байнгын хорооны 2026 оны 6 сарын 4-ний өдрийн 4, 6 дугаар тогтоолоор томилон ажиллуулсан.

Хоёр.Ерөнхий хяналтын сонсголын талаар. Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль, Монгол УИХ-ын чуулганы дэгийн тухай хуульд заасны дагуу ерөнхий хяналтын сонсголыг 6 сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сонсголын эхний өдөр буюу 6 сарын 15-ны өдөр төрийн байгууллагаас 61 иргэн, хуулийн этгээд, ТББ-ын төлөөллөөс 19, нийт 80 хүн, мөн сонсголын 2 дахь өдөр буюу 6 сарын 16-ны өдөр төрийн байгууллагаас 61 иргэн, хуулийн этгээд, төрийн

байгууллагын төлөөллөөс 41 оролцогч, нийт 102 хүн, 2 өдрийн турш нийтдээ 182 оролцогч сонсголд биечлэн оролцож, санал, тайлбар, мэдээлэл өгсөн.

Сонсголыг УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 126.4-т заасны дагуу нээлттэй явуулсан бөгөөд хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах, тэдний оролцоог хангах зорилгоор Үндэсний радио, телевизээр дохионы хэлмэрчтэйгээр шууд дамжуулж, УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 121.4-т заасны дагуу ерөнхий хяналтын сонсголын тайланг тэмдэглэлийн хамтаар УИХ-ын албан ёсны цахим хуудсанд байршуулсан болно.

Тайлангийн дүгнэлтийг товчлон авч үзвэл, сонсголын үеэр танилцуулсан төрийн байгууллагуудын мэдээлэл, шинжээчдийн дүгнэлт, аудитын тайлан, иргэдийн санал, асуулт хариулт болон холбогдох баримт материалд үндэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг гаргасан байна. Үүнд: 1.Нийслэлийн төсвийн тогтвортой байдал алдагдах эрсдэл нэмэгдсэн байна. Нийслэлийн төсвийн алдагдал улсын төсвийн алдагдлаас давсан 232.8 хувь, жилд 4-өөс 5 удаа тодотгол хийж байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсвийн сахилга бат, алдагдалгүй төсөв батлах тухай зарчимтай нийцэхгүй байна. Үнэт цаас, бонд болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлж буй төслүүдийн эргэн төлөлт нь цаашид улсын болон нийслэлийн төсөвт нэмэлт дарамт учруулах эрсдэлтэй байна.

2.Хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийн төлөвлөлт, бэлтгэл ажил хангалтгүй байна. Сонсголын үеэр хэлэлцсэн 16 мега төслийн нийт төсөвт өртөг 28.9 их наяд төгрөгт хүрсэн боловч санхүүжилтийн гүйцэтгэл ердөө 5 хувьтай байна. Төсөл, арга хэмжээнүүдийн зарим нь ТЭЗҮ, зураг төсөл, газрын асуудал, техникийн магадлал, байгаль орчны үнэлгээ, олон нийтийн оролцооны шаардлагыг бүрэн хангаагүй байхад батлагдсан нь хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах зэрэг нөхцөлийг бүрдүүлжээ.

3.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд ноцтой зөрчил илэрсэн байна. Төсвийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авлигын эсрэг хууль болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хууль тогтоомжийн шаардлагууд бүрэн хангагдаагүй нөхцөл байдлууд тогтоогдсон.

4.Нийслэлийн өмчит байгууллагын тоо, чиг үүргийн давхардал нэмэгдэж, засаглалын эрсдэл үүссэн байна. Сүүлийн жилүүдэд нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой байгууллагуудын тоо эрчимтэй өсөж, чиг үүргийн давхардал бий болсон бөгөөд төрийн оролцоог нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн өрсөлдөөний орон зайг хязгаарлах нөхцөл үүсжээ. НИТХ-ын төлөөлөгч төрийн өмчит байгууллагын удирдлага, ТУЗ-д ажиллаж, тухайн байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг хэлэлцэн баталж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх өндөр эрсдэлтэй байна.

5.Иргэдийн оролцоо, олон нийтийн хэлэлцүүлэг хангалтгүй байна. Томоохон төсөл, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог бодитой хангаагүй, олон нийтийн хэлэлцүүлгийг шийдвэр гарсны дараа зохион байгуулсан, эсвэл хуульд заасан төлөвлөлтийн сонсголыг зохих журмын дагуу хэрэгжүүлээгүй тохиолдлууд илэрсэн байна.

6.Ил тод байдал, мэдээллийн хүртээмж хангалтгүй байна. Нийслэлийн төсөв, мега төслүүдийн хэрэгжилт, санхүүжилт, гүйцэтгэгч байгууллага, гэрээ, зарцуулалтын талаарх мэдээлэл иргэдэд бүрэн нээлттэй биш байгаа нь иргэдийн мэдээлэл авах эрх болон олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

7.Санхүүжилтийн эх үүсвэрийн бодит эрсдэл өндөр байна. Мега төслүүдийн нийт санхүүжилтийн 54 орчим хувийг гадаад зээл, үнэт цаас болон бусад өрийн хэрэгслээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч эх үүсвэрүүд бүрэн баталгаажаагүй. Зарим төслийн эдийн засаг, санхүүгийн үр өгөөжийн тооцоолол бодитой бус, хэт өөдрөг таамаглалд тулгуурласан нь хэрэгжилтийн болон өрийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

8.Худалдан авах ажиллагаа болон урьдчилгаа санхүүжилттэй холбоотой ноцтой эрсдэл илэрсэн байна. Туулын хурдны замын төслийн тендер шалгаруулалт, гэрээ байгуулах ажиллагаанд шаардлага хангаагүй баримт бичиг, эрх зүйн зөрчил ба санхүүгийн баталгаатай холбоотой асуудлууд илэрсэн бөгөөд төслийн хүрээнд олгосон их хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд хууль хяналтын байгууллагууд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Тухайлбал, 500 тэрбум төгрөгийн урьдчилгааг эргэлзээтэй баталгаагаар олгосон, 8 хүн яллагдагчаар татагдаж, 3 хүн цагдан хоригдсон, 2.6 их наяд төгрөгийн гүйлгээ хязгаарлагдсан.

9.Хяналт шалгалтын тогтолцооны үр нөлөө хангалтгүй байна. Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжүүд бүрэн хэрэгжихгүй байгаа, хууль тогтоомжийн зөрчилд холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хариуцлага тооцох механизм сул байгаа нь ижил төрлийн зөрчил давтагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж дүгнэсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Бадамсүрэн нийслэл, орон нутгийн төсвийн сахилга бат, хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлыг зарчмын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлж, ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулсантай холбоотойгоор ЗГ-т чиглэл өгсөн УИХ-ын тогтоолын төслийг УИХ-аар хэлэлцүүлэх нь оновчтой эсэх, мөн орон нутагт төсвийн хөрөнгөөр төслүүдийг хэрэгжүүлэх боломж, түүний хуваарилалт, зарцуулалтад өөрчлөлт орох эсэх талаар, УИХ-ын гишүүн Түвшин томоохон мега төслүүдийн улсын эдийн засагт үүсэж болзошгүй эрсдэл болон нийслэлд хэрэгжүүлж буй төслүүдийн зураг төсөв, зардлуудын огцом өсөлтийн үндэслэл, шалтгааны талаар тодруулж, нийслэл, орон нутагт үүссэн өр зээлийн эрсдэлийг цаашид хэрхэх талаар, мөн улсын болон орон нутгийн төсвийн зардлын огцом өсөлтийн шалтгаан, үр дагавар, төрийн захиргааны төв байгууллага болон нэгж дэх төрийн удирдлагын тогтолцооны чиг үүрэг, орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх боломж, улс болон орон нутгийн төсвийн хуваарилалт, чиг үүргийн зохистой харьцааны талаар, УИХ-ын гишүүн Сайнзориг ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулсантай холбоотой боловсруулсан тайлан болон УИХ-ын тогтоолын төслийг ажлын хэсэг хэлэлцсэн эсэх, улсын болон орон нутгийн төсвийн хуваарилалтын тухай орон нутгийн хүн амын тоотой уялдуулах нь зүйтэй талаар, нийслэлийн төсвийн алдагдал болон улс, орон нутгийн төсвийн зохистой харьцааны талаар асуулт асууж үг хэлсэн болно.

Монгол УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 120.5-д заасны дагуу Нийслэлийн 2024-өөс 2028 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын

төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдвээр зохион байгуулсан ерөнхий хяналтын сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 55.6 хувь буюу олонх нь дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Нийслэлийн 2024-өөс 26 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Нийслэлийн 2024-өөс 28 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийг танилцуулъя та бүхэнд. Цэрэннадмидын Хосжаргал Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Санжаагийн Бат-Эрдэнэ Үндэсний аудитын газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын ахлах аудитор, Сандагийн Оюун-Эрдэнэ Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын өгөгдлийн шинжилгээний ахлах аудитор, Чулууны Мөнхбаатар ХЗДХЯ-ны ХШҮДАГ-ын шинжээч, Болдбаатарын Энхчимэг Монголын хуульчдын холбооны хуульч, Тогтохбатын Мөнхбат Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөрийн тооцооны хэлтсийн мэргэжилтэн, Эрдэнэбатын Батболд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын зохицуулалтын газрын Дэд бүтцийн хэлтсийн дарга, Дагвадоржийн Энхбаяр судлаач.

Та бүхэнд Монгол УИХ-ын тухай хуулийн 21.24-т нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл өгөхийг хориглоно. Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хариуцлага тооцно гэсэн хуулийн заалтыг танилцуулж байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгнө үү? Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Бямбасүрэнгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 51 дүгээр сургуулийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ УИХ-ын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Нэрс өгсөн байна. Ариунзаяагаар, гишүүдээс л асуулт асууна шүү дээ, тийм. Ариунзаяагаар тасаллаа. Жуковын Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Би Их Хурлын гишүүний хувьд нэг асуулт асуух гэсэн юм. Хан-Уул дүүргээс сонгогдсон Их Хурлын гишүүний хувьд нэг зүйл дээр их санаа зовж байгаа, манай энэ ажлын хэсэгт орж ажилласан хүмүүс маань нэг зүйлийг надад тодруулж өгөөч гэж хүсье. Энэ мега төслүүд гэх томоохон төслүүд хэрэгжиж байгаа, тэрний нөхцөл байдалтай танилцсан юм байна. Нөхцөл байдлын хувьд амаргүй

дүгнэлтүүд гарч ирж байгаа юм байна. Бэлтгэл ажил хангалтгүй байна гэж үзэж байгаа юм байна. Энэ Нисэхийн Буянт-Ухаа, Нисэх хавиас Улаанбаатар хотын төв рүү орох Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулахад, манай энэ Хан-Уул дүүргийн түгжрэлийг бууруулахад хамгийн чухал тээврийн хэрэгсэл болох Улаанбаатар трамвай гэж их чухал ажил байгаа. Энэ трамвайн ажил хийгдвэл замын трасс нь бэлэн, тэгээд Нисэх, Яармагийн иргэдийг массаар нь хотын төв рүү зөөх бололцоотой. Хотын төвд байгаа иргэдийг Нисэх, Яармаг руу массаар нь зөөх ийм бүрэн боломжтой ийм маш чухал ажил төлөвлөгдөөд ингээд явж байгаа.

Автобусанд 40-өөс 50 хүн ордог бол трамвайд 200-аас 300 хүн орох бололцоотой, цахилгаанаар явах бололцоотой, эдийн засгийн хувьд их хэмнэлттэй, түгжрэлийг шийдэх маш их том боломж бүхий ийм тээврийн хэрэгслийн асуудал ингээд яригдсан. Бараг эхлэх гэж байгаа гэж надад нийслэлийнхэн маш их олон мэдээлэл өгч байсан. Энэ төсөл маань ер нь та хэдийг шалгаж үзэж байхад ер нь явахаар болов уу? Бүр нөгөө бүхэлд нь зогсоогоод хаячхав уу? Энэ уул нь их л чухал төсөл байгаа юм даа. Энийг хэн ч байсан хэрэгжүүлэх ёстой л төсөл байгаа. Энэ дээр манай ажлын хэсэг хариулж өгөөч?

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хэн хариулах билээ? Ажлын хэсэг хариулах уу? Болно. Сонсгол даргалагч Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Энэ сонсголын зорилго ямар нэгэн төслийг зогсоох гэсэн зүйл байгаагүй. Тийм болохоор энүүгээр сонслоо гээд ямар нэгэн төсөл зогсчих зүйл байхгүй. Бүгдээрээ хүмүүст хэрэгтэй. Улаанбаатар нийслэл хүмүүст түгжрэл юманд хэрэгтэй, ёстой яаралтай хурдан хийх хэрэгтэй гэдэг нэрийн цаана хууль, эрх зүйн орчнуудаа өөрчилж байгаад маш их давуу тал болгож бий болгож аваад тэгээд хэдэн жил туйллаа шүү дээ. Тэрний үр дүнд нь энэ эргэлдэж байгаа мөнгөн дүн чинь улсын төсвийн жилийн төсвийн 80, 90 хувьтай тэнцэхүйц хэмжээний юм болчихоод, тэрийг захиран зарцуулж байгаа хяналт нь хангалттай биш, захиран зарцуулж байгаа хүмүүс нь өөрсдөө тэр төсвөө баталдаг болчихсон. Өөрсдөө батлаад, өөрсдөө зарцуулаад, өөрсдөө захиалаад, өөрсдөө зураг төслөө хийгээд, өөрсдөө хянаад, өөрсдөө мөнгөө босгоод, босгосон мөнгөө үрж амжихгүй болохоор банканд тавьж хүүлээд, хүүгээрээ ингээд сайхан хоол хийгээд, нийгэмд тустай юм хийгээд, хувийн хэвшлийн хийж байгаа бизнесүүдийг булааж аваад, төрөл бүрийн компаниуд байгуулаад, хууль дээрээ болохоор зэрэг зөвхөн хувийн хэвшлээр хэрэгжүүлж болохгүй, боломжгүй зүйлийг л төрийн өмчийн компани байгуулна гэхихсэн байтал тэрийгээ тоохгүй байгуулаад, ингээд ерөөсөө бүх зүйлийг нэг ийм нэгдсэн төсвийн хяналтын гадуур тусдаа ийм бөөрөнхийлсөн, хаалттай нэг юм үүсгэчихжээ.

Тэгээд энэний эрсдэл нь юу байна вэ гэхээр 2, 3 чухал дүгнэлт гарч байгаа. 1 дүгээрт нь, энэ улсын төсөв дээр эрсдэл үүсэж байна. Энэ төсвийн бодлого талаас салбарын яам нь ч тэр мэдээлэл хийсэн шүү дээ, Сангийн яам, ер нь том эрсдэлүүд үүсчихсэн байна. Тэгэхээр энэтэй холбоотой төсвийн хяналт, тэнцлийг сайжруулах нийслэлийн болоод орон нутгийн хуваарилалтыг эдийн засаг, байршил, хүн ам энэ онцлогтой нь хамааруулж хяналтыг чангалах хэрэгтэй юм байна.

2 дугаарт, иргэдийн төлөөлөл болсон хүмүүс иргэдээ төлөөлнө, хяналт тавина, өөрсдөө юм зарцуулаад байвал хяналт тавьж чадахаа байна. Тэгэхээр төлөөлөгчийн ажлыг хийх нөхцөлийг нь бүрдүүлж өгье, тэр хүмүүст ингээд тэр төсөв мөнгөтэй энээ тэрээ юмнууд нь хуучин байдаг байсныг нь байхгүй болгочихсон буруу байж гэсэн иймэрхүү эрх зүйн дүгнэлтүүд сонсголоос гарсан юм. Тэгээд энэ

дүгнэлтүүд хамгийн чухал зүйл. Үүний дагуу УИХ хууль тогтоогч, бодлого боловсруулагч байгууллага юм бол хууль, эрх зүйн орчноо яаж сайжруулах вэ гэдэг дээр дүгнэлт гаргах нь сонсголын нэг гол зорилго байсан. Тэрнээс биш тэр төсөл, энэ төсөл нөгөө төмөр дугуйтай нь эсвэл дүүжин даажин нь үр ашиггүй гэдэг 2 дугаар асуудал. Тэгээд ямар нэгэн төсөл зогсоосон зүйл байхгүй, илэрхий хууль зөрччихсөн жишээ нь Туулын хурдны замын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт ЗГХЭГ-аас танилцуулга хийсэн, Сангийн яам дүгнэлт хийсэн хуульд нийцээгүй, энэ ажлуудыг маш тодорхой хийсэн байгаа юм. Тэгээд ийм ажлууд нь бүгд зөвшөөрчхөөд байхад одоо тэр хүмүүс дээр хариуцлага тооцох хэрэгтэй. Зарим нь ажлаа хийгээд явж байгаа шүү.

Тэгээд энэ агуулгаар нь УИХ-ын тогтоолын төсөл боловсруулаад Байнгын хороон дээр хэлэлцсэн. Харамсалтай нь тогтоолын төсөл дэмжээгүй, тайлан хэлэлцэгдэхээр болж байгаа. Сайдын асуусан яг тэр төслийн тэр төсөл зогссон эсэх тал дээр энэ тээврийн төслүүдийг харьцуулж судалсан хүн байвал шинжээчдээс нэг нь төлөөлөөд мэдээлэл өгнө үү гэж хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: 4 дугаартай микрофон дээр.

Д.Энхбаяр: Сайн байна уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид мега төслүүдийн бидэнд ирүүлсэн ТЭЗҮ, бусад бичиг баримт, бүх материалтай танилцаж үзээд нийт төслүүдийн маань явцыг нь ингээд гаргасан байгаа. Энэ дотор таны асууж байгаа энэ трамвайн төслийн ТЭЗҮ нь 100 хувь хийгдсэн, ажлын зураг 0, барилгын ажлын явц 0, нийт гүйцэтгэл нь 5.2 хувьтай гэж мэдээлэл байгаа. Энхийг Нэгдсэн төслийн удирдлагын газраас өгсөн. Ерөнхийдөө нийт 16 мега төслийнхөн маань нийт явцыг 14 хувьтай гэсэн тийм мэдээллийг Нэгдсэн төслийн удирдлагаас бидэнд 6 сарын 10-ны байдлаар өгсөн байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Золжаргал дарга би шал өөр юм асуугаад, та хэд шал өөр юм яриад. Би ерөнхийдөө та нарын дүгнэлтийг хүлээн зөвшөөрснөө ойлгож байгаа. Тэгээд ингээд тодорхой төслийг асуухаар ингээд ерөнхий, тэгээд энэ төслөө мэдэхгүй байж би Улаанбаатар трамвай төсөл яг ямар шатандаа байна, хэрэгжих бололцоотой юу гэхээр ингээд ерөнхий юм хариулаад, яаж ерөнхий юмаар дүгнэлт гаргачхаад, яаж дүгнэлт гаргасан юм бэ? Тэгээд энэ дээр чинь ингээд бүр биччихсэн байна шүү дээ. Хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийн бэлтгэл ажил хангалтгүй байна гээд тэгж байна. Тэгээд тэр төслийн үр ашиг, энэ тэрийг нь ерөөсөө олж хараагүй юм уу? Зүгээр ерөөсөө ерөнхийд нь ингээд муу байна л гэсэн ийм юм бичсэн байна шүү дээ. Муу байгаа, муухай байгаа юмыг ойлгож байгаа, санал нийлж байгаа юм зөндөө олон бий. Нийслэлийн төсөв хэт том данхайсныг ойлгож байна. Улсын төсөв, нэгдсэн төсөв, нийслэлийн төсөв хоорондын харилцааг янзлах ёстой. Тэрийг би хүлээн зөвшөөрч байгаа, мэдэж байгаа. Зүгээр миний ярьсан юман дээр нэг.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Трамвайн төсөл яг энэ чинь ингээд түмэн янзын төсөл байна шүү дээ. Тэр төсөл дээр дэлгэрэнгүй яриагүй. Трамвай гэдэг зүйл хэрэгтэй, метро хэрэгтэй, дүүжин тээвэр хэрэгтэй, тусгай замын автобус хэрэгтэй, энэ тээврийн мега төслүүд чинь бүгдээрээ хэрэгтэй. Тэгэхдээ нэгэн зэрэг бүгдээрээ хэрэгжих

боломжгүй. Тэгээд энэ 7 тээврийн төслийн энэ тойрог замуудыг хооронд нь яаж зангидаж уялдсан юм бэ гэдэг бодлогын асуудал дээр Зам, тээврийн яам хариулт өгч чадаагүй. Яагаад гэвэл хариулт байхгүй. Аль нь эхлээд, аль нь хэзээ хэрэгжих талаар дэс дараалсан тийм эрэмбэ алга байна. Яг таны асуусан Хан-Уул дүүргийн оршин суугчдад чухал байгаа тэр хотын төв рүү орох трамвайн хувьд хувь хүнийхээ хувьд дэмжиж явдаг. Ингэхээр энэ эрэмбэ нь чухал байна гэдэг дээр л гол нь дүгнэлт хэлж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Золжаргал даргаа ингэмээр байна. Тэгээд дүгнэлт гаргачихсан юм чинь энэний араас ажил хэрэг болгоод ажилламаар байна, зүгээр ингээд орхимооргүй байна. Ёстой муухай юм байна лээ, пүү паа гэж орхимооргүй байна. Эндээс тэр шигшээд нийслэл энэ тэртэй хамтарч ажиллаад, Их Хурлын ажлын хэсэг энэ дэд ажлын хэсэгтэйгээ ажиллаад эрэмбэлж болдог юм бол эрэмбэлж өгөөд, янз бүрийн бүгдээрээ хулгай зэлгийтэй холбогдоогүй байлгүй дээ. Зарим энэ тэр нь зүгээр явж байгаа төсөл байгаа байлгүй. Тэр энэ тэрийг нь сонгож аваад энэ хотын иргэддээ зориулсан ажлыг нь үргэлжлүүлмээр байна. Ялангуяа манай Хан-Уул дүүргийн иргэд надаас, би Их Хурлын гишүүний хувьд яриад байгаа шүү дээ. Юу хүсэж байна вэ гэхээр энэ Яармагийн энэ түгжрэлийн асуудлыг шийдэхэд хамгийн чухал тэр ажлыг яаралтай эхлүүлж өгөөч гэсэн. Тэгэхээр танай ажлын хэсгээс энэ хотын удирдлагууд энэ тэртэй ярьж, нэгэнт энэ сонсгол зохион байгуулсан юм чинь энэ ажил хэргийг нь дуусгаад өгөөч гэсэн ийм хүсэлтийг Их Хурлын гишүүний хувьд та бүгдэд тавьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Алдаржавхлан гишүүний саналтай санал нэг байна. Энэ Төсвийн байнгын хороон дээрээс гарах байсан тэр тогтоолын төсөл дээр яг энэ төслүүдийг ингэж эрэмбэлж байгаад, хөрөнгө оруулалт, хэрэгцээ шаардлага, хугацаа боломжоор нь эрэмбэлж байгаад аль дээр нь хамгийн түрүүнд яах вэ энэ тэр гэдэг дээр анхаарал хандуулах шаардлагатай байна, яаж эрэмбэлэх гэж байгаа вэ гэх мэтчилэн иймэрхүү чиглэл байсан юм. Тэгээд энэ тогтоол маань өчигдөр батлагдаагүй. Гэхдээ Ерөнхий сайдад асуулга хэлбэрээр томьёолоод өнөөдөр энэ сонсгол санаачилсан гишүүд гарын үсэг зураад бланкаар хүргүүлж байгаа юм. Тэгэхээр энэ дээр анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй. Тантай санал нэг байна.

Ж.Бат-Эрдэнэ: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Ерөнхий хяналтын сонсголын санал, дүгнэлттэй ингээд танилцахаар нийслэлийн төсвийн тогтвортой байдал алдагдах эрсдэл нэмэгдсэн байна гээд. Тэгээд нийслэлийн төсвийн алдагдал маань улсын төсвийн алдагдлаасаа давчхаад байна гээд. Тэгээд би ойлгохдоо Төсвийн байнгын хороон дээр тогтоолын төсөл оруулсан гэж ойлгосон. Тэр сонсгол даргалагчаас асуух гээд байгаа нь яг нөгөө тогтоолын төсөл дээр Төсвийн байнгын хороогоор оруулсан тогтоолын төсөл дээр энэ төсөвтэй холбоотой, ялангуяа нийслэл маань төсвөө батлахдаа улсын төсвөөс илүү алдагдалтай баталдаг. Энэ хооронд ямар харьцаа, зарчим байх ёстой юм бэ гэдэг ч юм уу энэ дээр яг тодорхой санал байсан уу гэдэг 1 дүгээр асуулт байгаад байна.

2 дугаарт болохоор энэ хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийн төлөвлөлт, бэлтгэл ажил хангалтгүй байсан гээд. Яах вэ нийслэлийн 16 мега төслийн тухай яриад байх шиг байна. Тэгээд ерөнхий санхүүжилтийн гүйцэтгэл нь 5 хувьтай гээд байдаг. Тэгэхээр санхүүжилтийн гүйцэтгэл 5 хувь яах вэ зүгээр тодорхой нэг санхүүжилтийн төлөвлөгөөний л хэсэг шүү дээ. Тэгэхээр яг энэ бэлтгэл ажлын хүрээнд ТЭЗҮ нь, зураг төсөл нь, газрын асуудал, техникийн магадлал, байгаль орчны үнэлгээ гээд олон нийтийн оролцоо, мэдээллээр мэдээлэл хангах байдал эд нар гээд энэ бүх ингээд үзүүлэлтүүдээр тооцоод үзэхээр нийслэлийн баталсан байгаа 16 мега төсөл ер нь хувийн жин нь хэдэн хувь байсан юм бэ? Санхүүжилтийн гүйцэтгэл 5 хувь байх бол бүх хувийг гүйцэтгэлийн хувийг илэрхийлэхгүй гэж харж байгаа. Тийм учраас энэ талаар нэг тодруулж өгөөч?

Ж.Бат-Эрдэнэ: Хариулъя. Золжаргал гишүүн хариулъя.

Ж.Золжаргал: Энэ төсөв, санхүүгийн төрийн захиргааны төв байгууллагаас ч юм уу хүмүүс ер нь хариулах нь зөв байх. Би сонсгол даргалагчийн хувьд зүгээр энэ тогтоолын төсөл дээр ямар санаанууд тусгагдаж байсан бэ гэхээр, жишээлбэл энэ Төсвийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлдэг боловч энэ зарлага нь төсвийн орлого хэсэгт тусгагддаггүй, улмаар орон нутгийн төсөвт алдагдалтай харагдах нөхцөл үүсээд, төсвийн төлөвлөлт ба гүйцэтгэл үнэн, бодитоор тайлагнахгүй байна. Энэ зөрчилтэй байдлыг эрх зүйн орчинд яаж зохицуулах, эрх зүйн орчинд зохицуулах энэ саналыг боловсруулж, УИХ-д өргөн барь гэсэн иймэрхүү агуулга явж байсан.

ЗГ Үндсэн хуулиар нэгдсэн төсөв боловсруулж өргөн барьдаг цорын ганц субъект. Тэгээд төсвийн нэгдсэн бодлогоо барьж явдгийн хувьд ЗГ энэ тал дээр анхаараад, мөн тэр зээлийн бондын хүү эргэн төлөлт нь төсөв дээр ямар ачаалал үзүүлэх юм, тэрийг яаж өрийн удирдлагаараа саармагжуулах гэж байгаа энэ тал дээр ямар хязгаарлалтууд байх юм гэдэг ийм чиглэлүүд байсан. 28.9 их наяд төгрөг байгаа шүү дээ одоогийн бүртгэлтэй, биччихсэн байгаа, жагсаачихсан байгаа 16 мега төсөл маань 28.9 их наядыг ирэх хэдхэн жилийн дотор хэрэгжүүлэх ёстой. Тэр нь болохоор 28 их наяд гэдэг чинь улсын төсвийн 80 гаруй хувь байхгүй юу. Тэгэхээр энэ ингээд нөлөөлнө. Дараа жилийн 27 оны 10 дугаар сараас гэхэд Сэлбэ 20 минут хотын зээлийн бондын эргэн төлөлт явагдах ёстой, төсөв нь дуусаагүй байгаа. Тэгэхээр зэрэг яах вэ гээд энэ энд асуудлуудыг боловсронгуй болгоод, тэгээд эрх зүйн орчноо яаж хяналт тэнцвэртэй болгох вэ гэдэг ийм л агуулгатай тогтоолын төсөл байсан. Тэгэхдээ энэ маань асуулга хэлбэрээр явж байгаа. Ерөнхий сайдын асуулгыг УИХ-ын холбогдох Байнгын хороод дээр, чуулган дээр хэлэлцэнэ гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя. Соронзонболд гишүүний асуусан асуултад 4 дүгээр микрофон.

Д.Энхбаяр: Шинжээч Энхбаяр байна. Сая гишүүний асуусан асуултад нийт 28.9 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 16 мега төслийн 26 оны 6 сарын 12-ны байдлаар 1.4 их наяд буюу 5 хувийн гүйцэтгэлтэй, үүнд нь ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ боловсруулах, зөвлөх үйлчилгээ авах, боловсон хүчин бэлтгэх, барилга угсралтын зардал байгаа. Нийт төслийн маань явц нь болохоор 14.3 хувьтай байгаа байхгүй юу. Эндээс шийдэгдээгүй буюу нөгөө 19.1

их наяд төгрөгийн санхүүжилт нь одоогоор шийдвэрлэгдээгүй байгаа гэсэн тийм дүгнэлтэд хүрсэн. Тэгэхээр нөгөө хугацаа сунах эрсдэл байна гэж бид үзэж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгээс асуугаад байгаа нь ингээд байхгүй юу. Энэ 16 нийт нийслэлийн мега төслийг чинь ТЭЗҮ нь огт боловсруулагдаагүй ч юм уу, зураг төсөл нь хийгдээгүй, байгаль орчны үнэлгээ нь хийгдээгүй гээд энэ нөгөө техникийн магадлал эд нар нь хийгдээгүй ийм ажлуудтай төсөл нь хэд байгаа юм бэ л гэж байгаад байхгүй юу? Яах вэ би энэ санхүүгийн гүйцэтгэл 5 хувьтай байгааг бол ойлголоо. Гэтэл аливаа төсөл эхлэхээс өмнө зайлшгүй хийгдсэн байх ёстой суурь тооцоолол, ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ, магадлал гээд эд нар нь хийгдээгүй хэдэн төсөл байгаа юм бэ л гэж асуугаад байхгүй юу.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг.

Д.Энхбаяр: Энэ дээр нь би танд явцаас нь хэлбэл дүүжин замын тээврийн 2 дугаар шугамын ТЭЗҮ хийгдээгүй байна. Ханын материал дэд төвийн ТЭЗҮ хийгдээгүй байна. Туул усан цогцолборын ТЭЗҮ 90 хувьтай, 2 дугаар тойрог замын ТЭЗҮ 70 хувьтай, тусгай замын автобус BRT-ийн ТЭЗҮ 87.9 хувьтай байна. Ажлын зургийн явц гэвэл Дүүжин замын тээвэр 1 дүгээр шугамын ажлын зураг 100 хувь, Сэлбэ орон сууцжуулахынх 95 хувь, Дулааны 5 дугаар станц 31 хувь, Баянхошуу дэд төв 100 хувь, Ханын материал дэд төв 30 хувь, Олон түвшний уулзвар 100 хувь, Туул хурдны замын авто зам 80.7, Хүннү хотын дэд бүтэц 60 хувьтай хийгдчихсэн, бусад төслүүд нь хийгдээгүй, эхлээгүй байгаа юм байна.

Ж.Бат-Эрдэнэ: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Сая Ж.Алдаржавхлан гишүүн аягүй тодорхой асуусан шүү дээ. Энэ трамвай гээд тэр төслийн ТЭЗҮ бусад юмнууд нь хийгдсэн байсан юм уу гээд, уул нь Ж.Алдаржавхлан гишүүн асуусан шүү дээ. Тэгээд тэрэнд яг сайн хариулахгүй л байх шиг байсан. Тэрийг тодруулаад өгөөч?

Ж.Бат-Эрдэнэ: 4 дүгээр микрофон.

Д.Энхбаяр: Яг Улаанбаатар хөнгөн галт тэрэг трамвай дээр, уучлаарай, хөнгөн галт тэрэг трамвай дээр ТЭЗҮ нь 100 хувь, ажлын зураг 0, барилгын ажлын явц 0, нийт төслийнхөө гүйцэтгэлийг 6.2 хувь гэсэн байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Сонсголтой холбоотой би үг хэлье. 3 зүйлийг онцолж хэлэхийг хүсэж байна. Тэгээд үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмжүүдийг уул нь гаргасан. Тэгээд УИХ-ын тогтоолын төсөл байдлаар гаргахаар Байнгын хороонд оруулсан боловч дэмжигдээгүй. Тэгээд эндээс онцолж 3 зүйлийг хэлэхийг хүсэж байна.

1 дүгээрт болохоор энэ нутгийн өөрөө удирдах байгууллагын энэ эрх мэдэл, энэ чадамж, чадавхыг сайжруулах тухай асуудал байгаа. Засаг дарга бол Засаг даргын томилсон дарга нар нутгийн өөрөө удирдах байгууллага биш. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол иргэдийн хурал, иргэдийг төлөөлөх чадвартай Иргэдийн

Хурал. Тэгэхээр Иргэдийн Хурал маань үнэхээр энэ Ерөнхий сайдын томилсон Засаг даргын эрх мэдэл, шийдвэр гаргах яг ийм хэрэгсэл нь байдалтай л болчихсон ийм дүр зураг харагдаад байгаа юм. Тэгэхээр нутгийн өөрөө удирдах байгууллагыг сайжруулахын тулд тодорхой хэмжээний энэ нутаг дэвсгэр, засаг захиргаа, түүний нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтуудыг сайжруулж, энэ нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдлүүдийг тодорхой хэмжээгээр сайжруулах, чадваржуулах хэрэгцээ шаардлага байгаа харагдаж байна. Тухайлбал, магадгүй Ерөнхий сайд томилох эрхтэй байгаа бол огцруулах тодорхой эрхийг нь жишээлбэл иргэдийн хурал дээр энэ эрхүүдийг нь тодорхой болгож өгөх гэх мэтчилнээр гээд.

Нөгөө талаасаа энэ иргэдийг төлөөлж байгаад сонгогдсон иргэдийн төлөөлөгчдийн бие даасан байдлыг нь хангахгүй бол эдийн засгийн хувьд цалин хөлс байхгүй учраас гээд энэ шалтгаанаар төрийн өмчит, өөрөөр хэлбэл Засаг даргынх нь өөрийнх нь эрх мэдэл, харьяаны энэ байгууллагуудын удирдлага, ТУЗ-үүдэд оруулдаг, гүйцэтгэх захирлаар нь томилдог энэ байдлууд энэ нутгийн өөрөө удирдах байгууллагыг маш жижигхэн хумьж байна. Иргэдийгээ төлөөлөх чадваргүй болгож байна. Иргэдийн төлөөлөгчид нь өөрсдөө засаг даргадаа худалдагдаж байгаа иймэрхүү асуудлууд үүсээд байгаа учраас энийг сайжруулах зайлшгүй шаардлага байгаа харагдаж байгаа юм.

2 дугаарт, энэ хөгжлийн төслүүдийг ямар төслийг нь хаана нь, хэн хариуцаж, яаж хуваарилах юм бэ гэдгийг тодорхой болгохгүй бол хөгжлийн бодлого, төлөвлөлт, том, том төслүүд байна, бидний хувьд асуудлууд байгаа. Утааны асуудал, түгжрэлийн асуудал, цахилгаан эрчим хүчний асуудал гэх мэтчилэнгээр энэ олон асуудлууд байгаа. Гэхдээ энийг тодорхойгүйгээсээ болоод нийслэл дээр нэг шийдэж байна. Жишээлбэл, цахилгаан станцыг Бөөрөлжүүт гээд нийслэл бонд босгоод санхүүжилт хийж байна, 5 дугаар цахилгаан станц гээд хийж байна, нөгөө талд нь Эрчим хүчний яам эрчим хүчний олон бүтцүүд байна. Тэр аль нь юуг, хаана нь хийх нь энэ нь тодорхойгүй харагдаад байна. Уул нь нийслэл бонд гаргахдаа ЗГ-аас баталгаа авч байж ингэж явдаг. Тэгээд энэ байдлууд нь дараа нь жишээлбэл өөрөө бие даагаад шийдчихсэн юм шиг иймэрхүү байдал гарч байна. Тэр бодлогоо тайлбарлаж хамгаалж чадахгүй байна Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамнууд нь, энийг анхаарах хэрэгтэй.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Үг хэлчихье. Төр засаг гэж байна уу гэж харагдахаар болж байна. Ерөнхий хяналтын сонсгол ингээд сонсоод өнгөрдөг байвал цаашдаа сонсгол явуулахын ач холбогдол гэж байх юм уу? Ямар ч шийдвэр гарахгүй. Өчнөөн олон хүн, төрийн албан хаагчдыг, ажил хөдөлмөрөө хийж байгаа хүмүүсийг олон сар ажиллуулчхаад ингээд сонсоод өнгөрдөг. Төсвийн байнгын хороо маш хариуцлагагүй байна. Ерөнхий хяналтын сонсголоос ямар нэгэн шийдвэр гаргах тэр үр дүнгийн тогтоолын төслийг унагасан юм байна лээ. 2.4 их наядаар Туулын хурдны зам барих тендер сонгон шалгаруулалт чинь хууль зөрчсөн байна. Урьдчилаад 500 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна гээд Ерөнхий аудитын газар нь хэлээд байдаг. Хариуцлага байдаггүй.

2 дугаарт нь, энэ ер нь салбарын бодлого гэж байгаа юм уу, 2015 онд түгжрэлийг бууруулах тусгай замын автобус хөтөлбөрийг эхлүүлсэн. Төслийн нэгж нь цалин аваад л байна. Огт түгжирдэггүй, тусгай замаар явдаг нийтийн тээврийн

энэ төсөл одоо болтол эхэлдэггүй. 2021 онд дуусна гэж байсан дүүжин тээвэр чинь одоо болтол дуусдаггүй. Францын ЗГ-аас зээл авсан. 2024 онд метро төсөл дуусна гэж байсан, метро төсөл эхлээгүй байна. Нийт нийтийн тээврийн салбар буюу түгжрэлийг бууруулах нэрээр 7 том мега төсөл явуулж байна, 20 гаруй их наяд төгрөг, үүний 70 хувь нь зээл. Энэ зээлийн хүүг 2027 оноос хойш Монголчууд бид бүгдээрээ төлнө. Салбарын бодлого гэж байна уу? Ийм олон салангид төслийг эхлүүлэх гээд зээл авч байхад нь ЗГ, хариуцсан яамнууд яагаад нүдээ таглаад, чихээ бөглөөд суугаад байгаа юм бэ, ЗТЯ байна уу? Сайд нь энд сууж байна. 7-гийн 7 төсөл трамвай нэмэгдчихлээ, LRT нэмэгдчихлээ, метро явж байна, тусгай замын автобус явж байна, дүүжин тээвэр явж байна, тойрог зам явж байна. Ингээд энэ төслүүдээ эрэмбэлээд 1-ээс 2-ыг нь эхлүүлээд нэг үр дүн гаргаж болохгүй юм уу. Үнэхээр энэ санхүүгийн сахилга бат, Төрийн сан, Сангийн яам дэндүү хариуцлагагүй байна, УИХ-д бид хариуцлагагүй байна. Ингээд нэг сонсгол ямар ч үр дүнгүй, шийдвэргүй өнгөрч байна6 УИХ, УИХ-ын хяналт шалгалтын хуульд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Ажлын хэсэг хэн хариулах вэ? Ажлын хэсгийн дарга нь хариулна, дарга нь хариулъя. Сая тэгэхдээ үг хэллээ гэсэн. Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Баатархүү гишүүнтэй ер нь санал нэг байна. Юун дээр гэхээр энэ Хяналт шалгалтын тухай хууль, яг энэ сонсгол, ер нь сонсголын зорилго нь юу вэ гэдгийгээ нэг бид бодохгүй л нэг тийм зүгээр нэг улс төржилтийн ч юм уу, нэг тийм хувь улс төрийн тоглолтын ч юм уу, нэг тийм сонин талбар болчихоод ердөөсөө нэг зорилгоо ердөөсөө огт биелүүлэхгүй байгаад байна л даа. Төсвийн байнгын хорооны дарга ч гэсэн хэлж байсан 40 сая төгрөг гарч байгаа. Энэ гишүүд өөрсдийнхөө тэр төсвөөсөө гаргах хэрэгтэй. Байнгын хорооны төсвөөс энэ 2 хоногт зориулж 40 сая төгрөг гаргаж байна гээд хэвлэлээр явсан шүү дээ. Ажиглаж байхад Байнгын хорооны гишүүд нь, сонсгол зохион байгуулсан хүмүүс нь өөрсдөө энэ сонсголдoo бараг дийлэнх нь оролцоогүй шүү дээ. Ирц нь хүрэхгүй хэчнээн удав, иргэд хэчнээн удаан хүлээв, тэгээд ер нь ийм сонсголын зорилго нь хэн нэгнийг намнах байгаа юм бол энэ Монгол Улсад ажил яаж явах юм бэ? Төрийн албанд дунд шатны албан тушаалтнууд, эсхүл яг шийдвэр гаргаж байгаа тэр хүмүүс ер нь аливаа зүйл дээр гарын үсэг зурахаасаа ч айдаг болсон шүү дээ. Монголын төрд ажил хийж байгаа хүн байхгүй.

Хэзээ нэгэн цагт хэн нэгэн хүн ирээд эргээд мушгиад, гуйвуулаад шоронд хийж байгаа байхгүй юу. Хэн зоригтой ажил явуулах юм бэ? Зээл авах, бонд босгох зөвшөөрлийг нь өгчөөд, тэгээд зориулалтаар нь ажиллая гэхээр яг маргааш нь "Өө биш ээ, болохгүй ээ, хэт их мөнгө байна, ер нь болохгүй". Туулын хурдны замыг хэчнээн жил ярьсан, манай нөгөө мөрийн хөтөлбөрт ч байгаа, төсөвт ч байгаа, бодлогод ч байгаа. Тэгээд л гэнэт нэг хүн сэдээд л, гэнэт л Туулыг баллаж байгаа юм шиг тэгээд яриад яваад л, тэгээд Нямбаатар явбал намжина гэж байсан. Тэгээд л одоо намжиж байна л даа.

УИХ-ыг өөрийг нь хэзээ нэгэн цагт сонсгол хийхээр бол бурхан минь та бидний улаан, ногоон лазераар баталсан төсөв, хөрөнгө оруулалтууд яаж байгаа билээ гэхчлэн ийм асуудлууд зөндөө юмнууд байгаа. Тэгээд би нутгийн өөрөө өөрийгөө удирдах энэ эрхийг нь өгч, ажлуудыг нь жоохон явуулмаар байна. Энэ олон LRT, метро, трамвай бүхий л юунууд чинь юунаас болж зогссон юм, яагаад мөнгө нь үр дүнгүй зарцуулагдаад байгаа юм улс төрчдөөс л болсон шүү дээ, нэг

дарга ирлээ, дахиад л төслийг нь зогсоолоо, өөр захирлыг тавилаа. Үгүй ээ би энэ.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Мэдээж сонсголтой холбоотой нэлээдгүй асуудлууд байгаа, иргэдээс нэлээдгүй зүйлүүдийг ярьж байгаа, тэгээд энэнтэй холбоотой мэдээж УИХ-ын гишүүд тодорхой өөрсдийн саналуудаа хэлж байгаа байх. Лодойсамбуу гишүүн.

Ч.Лодойсамбуу: Ариунзаяа гишүүн зорилго биелсэн үү, энэ ер нь тэгээд нэг улс төрчийг намнах ажил болсон юм биш үү гэдэг асуулт асууж байна. Ийм асуулт сонсоод сууна гэдэг үнэхээр харамсалтай байна. Хууль зөрчсөн байна, хотод эрх мэдэл өгсөн болохоос биш хууль зөрчих эрх өгөөгүй шүү дээ. Хулгай хийх эрх өгөөгүй шүү дээ. Хууль зөрчсөн байна, хулгай хийсэн байна, авлига хээл хахуулийн асар том нөхцөл байдлууд үүссэн байна гэж шинжээчид тогтоод, мэргэжлийн шинжээчид тогтоогоод, тэрийг нь ард түмнээрээ сонсоод, хараад, УИХ-ын гишүүд нь төрийн хууль хэрхэн хэрэгжиж байгаа вэ гэдэг нэг байгаа онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлээд энэ зорилго биелж байгаа хэрэг биш юм уу. Бид орон нутагт эрхийг нь өгсөн, хулгай хийх эрх өгөөгүй шүү дээ. Энийг хэн нэгний, 2 улс төрчийн, эсхүл хэдэн улс төрчийн хэрүүл битгий болгооч.

Энэ татвар төлөгчдийн мөнгө, ирээдүйд татвар төлөгчдийн төлөх өр төлбөр, баахан зээл яаж зарцуулаад байна вэ гэдгийг чинь харах бүрэн эрхтэй шүү дээ. Эрхийнхээ дагуу харлаа, болохгүй байна. Болохгүй байгаа учраас энийгээ дүгнэлт хийгээд, шийдээд, хэн нь зээл авч болох юм, ямар хүрээнд авч болох юм, ямар хугацаатай, ямар хэмжээтэй зээл бонд гаргаж болох юм, өр тавьж болох юм бэ гэдгээ тодорхойлоод, ЗГ нь шийдвэрээ оруулаад ир гэдэг үүрэг өгөх тогтоолын төсөл бэлдээд орохоор хамт ажиллаж байсан хэсэг нөхдүүд нь орж ирж, баахан загнаж байгаад унацгаачхаж байгаа юм. Энэ чинь төрийн ажил шүү дээ. Зүгээр найз нөхдийн хоорондын гар барьсан, хэдэн жил хамт ажилласан гэх мэт шалтгаануудын хажууд хэтэрхий том, өргөн хүрээтэй асуудал. Бид тангараг өргөдөг, тэр тангаргаа ер нь санаж баймаар байгаа юм. Хэн нэгнийг яллахын төлөө хянан шалгах түр хороо байгуулж, энэ олон шинжээчид ажилласан гэж хэлэх болохгүй байх.

Тэгэхээр энэ сонсгол зорилгодоо хүрсэн, харин үр дүнд хүрэх боломжийг нь Төсвийн байнгын хороо үгүй хийсэн. Бид өнөөдөр асуудлуудыг оношилчихоод, хаана асуудал байна гэдгийг харчхаад тэрийг засах ёстой, засъя гээд тогтоолын төсөл бэлдээд оруулахаар өөрсдөө баахан улс төржүүлж байгаад унацгаачхаж байгаа юм. Ийм л юм болсон шүү дээ. Дахиад хэлье. Орон нутагт эрх мэдэл өгнө гэдэг хулгай хийх, хумслах, завшуулах, цавчих эрх өгөөгүй шүү. Тийм эрх хаана ч байхгүй шүү. Тийм өгөөгүй эрхийг эдлээд байгааг л ил болгосон. Ил болгох зорилго биелсэн.

Ж.Бат-Эрдэнэ: Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Хэн нэгнийг яллах зорилго агуулаагүй гэж байгаа мөртөөсөө та яг яллагчийн дүгнэлтийг сая уншлаа шүү дээ. Хулгай хийсэн байна, зувчуулсан байна. Үгүй ээ бид ийм юмыг дүгнэх юм уу. Та шүүх үү? Шинжээч тогтоохгүй. Үгүй ээ би ер нь энэ сонсголчуудын үр дүнг нь хэлж байгаа нь бид яг ийм хандлагаар сонсголчуудыг хийгээд байгаа байхгүй юу. Тэгээд л нэг л их хэн нэгнийг яллана, тэгээд энийгээ шүүхээр нотол. Тэгээд шүүхээр энэ асуудлууд явах ёстой болохоос биш УИХ-ын гишүүд УИХ-ынхаа ажлыг хиймээр байна. Бид тэр чигээрээ 126 яллагч энд суугаад байна. Прокурорууд, мөрдөн байцаагчид юу юм, больё би хариулт авахгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Би нэг асуулт асуучихъя. Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Энэ нэг минут юм уу. Ариунзаяа гишүүнээ сонсгол үр дүнд хүрсэн, тэр нэг сонсголыг 2 өдөр хийдэг юм, 2 өдөр хүмүүс нэг цай, кофе уудаг юм. Тэр зардлыг юу бодож та ярьж байна, энийг байна шүү дээ энэ шинжээчид ч биш, энэ ажлын хэсгийнхэн ч бид ч биш, гишүүд ч биш, энэ ажил хариуцсан Монгол Улсын Үндэсний аудит, Монгол Улсын Сангийн яам, ЗГХЭГ хууль бус гэдэг дүгнэлтүүдийг хийчихсэн шүү. Тэр Туул голын жишээн дээр, замын жишээн дээр. Тэрний хуульд нийцээгүй сонгон шалгаруулалтаас болоод 500 тэрбум төгрөг байхгүй болчихсон, явуулчихсан, хэдийг нь олж авах юм бүү мэд. Энэ Монголчуудын мөнгө, тэгэхэд цаана нь яваа тэр 10, 20, 30-аад их наяд төгрөг чинь ийм зам руу явбал яана. Ийм сонсголыг хийх хэрэгтэй, ингэж айлгах хэрэгтэй. Айж амьдрах ёстой, юун кофе, цайны мөнгө.

Ж.Бат-Эрдэнэ: Сонсголын зорилго бол төрийн байгууллага, төрийн ажлын хэсэг буюу тухайн Байнгын хорооны гишүүд, УИХ-ын гишүүд төрийн байгууллага болон албан тушаалтнаас асуулт асууж, тодорхой асуудлуудыг ил болгох, өөрөөр хэлбэл ард түмэнд, ард иргэдэд мэдэх эрхийг нээх асуудал шүү дээ 1.

2 дугаарт мэдээж Байнгын хороогоор тухайн асуудлууд хэлэлцэгдээд, цаашаа ЗГ болоод энэ алдаа дутагдлыг засах чиглэлийг өгч байгаа, өгнө. Энэ хамгийн том энэ сонсголын ач холбогдол. Бид урьд өмнө ийм зүйлүүд хийгддэггүй дандаа хаалттай байсан шүү дээ. Хаалттай байсан, мэдэгддэггүй байсан, Хяналт шалгалтынхаа хууль дотор бид энийг оруулж байж асар том ард түмэнд мэдэх эрхийг нээж өгсөн байхгүй юу. Энэ чинь өөрсдийнх нь, бидний УИХ өөрөө өөрсдөдөө хийсэн хяналт шалгалтын асар том боломж байхгүй юу. Энийг би нэмээд хэлчихье гэж болж байна.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Хангалттай асуудлуудаа ярьчихлаа шүү дээ. Байнгын хорооны санал, дүгнэлттэй уялдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд надад гишүүд нэрсээ өгсөн. Уучлаарай, би та бүхэнд, танд би Лодойсамбуу гишүүнээ, би танд нэр өгөөгүй байхад ярих эрхийг чинь өгсөн шүү дээ, хангалттай сайхан ярьчихлаа. Тийм болохоор гишүүд нэрсийнхээ дагуу асуулт асууж, хариулт авч дууслаа. Хангалттай яриуллаа, хангалттай яриуллаа, уучлаарай, болж байна. УИХ-ын гишүүдээ, би хангалттай яриуллаа, хангалттай асуудлуудыг сая хэлэлцлээ шүү дээ, том, маш том хэлэлцэх ийм боломж, бололцоог чинь нээгээд өгчихлөө. Би сая асуудлыг чинь хангалттай яриуллаа шүү дээ, хооронд нь. Би та бүхний эрхэнд халдаагүй, надад өгсөн нэрс байгаа. Бид дэг шүү дээ, дэгтэй, дэгийнхээ дагуу явж байна. Уучлаарай.

Нийслэлийн 2024-өөс 2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлттэй танилцлаа.

16.34 цаг

Арван Ес. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын 2023 оны 117 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ. УИХ, төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Жудагийн Баярмаа танилцуулна. Баярмаа гишүүнийг индэрт урьж байна. Дүгнэлт уншина, ХЗБХ-ны санал, дүгнэлтийг уншина.

Ж.Баярмаа: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-д 2026 оны 6 дугаар сарын 2, 11-ний өдрүүдэд Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооноос ирүүлсэн саналуудыг үндэслэн ХЗБХ Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу боловсруулсан, Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийг 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд олонх нь Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж, хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, ХЗБХ-ноос боловсруулсан Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгнө үү? Лодойсамбуу гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Энэ цалингийн асуудал дээр ингээд би сая юуг нь харахад сая л харлаа, тэгээд үндсэндээ цалингаа нэмүүлье гээд хэлэнгүүт нь үндсэндээ 10 хоногийн дотор шууд Их Хурал руу орж ирээд шийдэж байх шиг байна. Цаашдаа ийм байдлаар явах уу, яах вэ? Яг нэмэх үндэслэл нь юу юм бэ? Төрийн захиргааны олон албан хаагч нар сая хөдөө гадаа явж байхад цалингаа яаж нэмүүлэх вэ, биднийхийг үндсэндээ хаягдлаа, компьютер байхгүй, тоног төхөөрөмж авахгүй гэхихсэн, цалин нь огт нэмэгддэггүй. Тэгэхээр ийм нэг ийм зарчим байхгүйгээр ингээд орж ирж байгаа нь энэ өөр хууль юугаар зохицуулагдаж байна уу, яаж байна вэ гэдгээр би тодруулга авъя. Эсхүл зөвхөн тухайн салбарын цалинг нь Их Хурлаар тогтоох гэдэг хуулийн асуудлын дагуу орж ирээд байна уу? Дахиад түрүүн Наранбаатар дарга хэллээ, аудитынхан асуудал тавьж байна гэнэ, ингээд, ингээд явбал яах вэ, эсхүл яаж шийдэх ёстой юм бэ гэдэг талаас нь зүгээр тодруулга авъя?

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хороо, Цогтбаатар гишүүн хариулъя.

Д.Цогтбаатар: Энэ зүй ёсны гарах ёстой асуулт. Энэний хариулт нь их энгийн. Ерөөсөө энэ яг хуулийнхаа дагуу явж байгаа зүйл. ШЕЗ чинь шүүгч гишүүд, шүүгч бус гишүүд гээд 2 гишүүдээс бүрдэж байгаа шүү дээ, 2 төрлийн. Тэгээд шүүгч гишүүд чинь шүүгчээрээ явж байдаг учраас шүүхийн цалин нэмэгдчихлээр шүүгч бус гишүүдийнх нь өөрөө үлдчихэж байгаа юм. Тэгэнгүүт 1 ажил, адилхан функцтэй

нэг ажил хийж байгаа хүмүүсийн нэг нь нэг цалин аваад, нөгөөдөх нь яг адилхан ажил хийж байж өөр цалинтай болчихож байгаа юм. Тэгээд энэ төсөв дотроо өөрөө шийдэгдэх боломжтой байж байгаа юм. Тэгээд тэр үүднээс нь энийг нь нэмэхгүй бол наадах чинь ёстой нөгөө ялгаварлан гадуурхсан, хүний эрхийн асуудал чинь гараад ирж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Дахин тодруулъя, Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Тийм, тэгэхээр иймэрхүү зүйл байгаа бол ер нь цаашдаа хуулийнх нь хувьд ч гэсэн өөрчлөхгүй бол ингээд Их Хурлаар нэг нэгээр нь ч юм уу оруулж ирдэг юм уу, нэг ийм юм харагдахаар энэ чинь зарчмын хувьд ингээд их сонин харагдаад байгаа юм. Аягүй бол олон хүн харж л байгаа байх л даа, ингээд гишүүд, УИХ болохоор нэг нэгээр нь ингээд хүмүүсийг оруулж ирээд байгаа юм шиг. Тийм учраас дараагийн ээлжид манай ХЗБХ гэдэг юм уу энэ холбогдох хуульд нь өөрчлөлтөд оруулаад, тэр төсөв дотроо багтаагаад өөрсдөө ижилхэн нэмэх гэдэг юм тавихгүй болохоор салбарын асуудал тусдаа гээд байсан чинь одоо албан тушаалаар нь тус тусад нь оруулж ирнэ гэдэг асуудал, энэ зарчмыг өөрчлөх хэрэгтэй юм байна гэдэг ийм саналыг хэлмээр байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: УИХ-аар ингээд энэ албан тушаалтнуудын цалин тогтоолын төслөөр баталдаг их сонин харагдаад байна л даа. Тэгэхээр ер нь яг Эрдэнэбат гишүүнтэй ер нь адилхан саналтай хэлэх гээд байна л даа. Цаашдаа ингэж энэ ялгаж шүүгч, шүүгч бус гэж ялгаж цалин тогтоодог, тэрийг нь тодорхойлдог биш, энийг яг тэр төсвийнхөө хүрээнд угаасаа төсөв дотроо өөрсдөө зохицуулах бололцоог нь өгчихсөн байгаа шүү дээ. Тэгээд тэр хүрээндээ ялгахгүйгээр энэ цалин хөлсөө тогтоодог тэр зохицуулалтуудаа өөрсдөө нэмж оруулж ирэх хэрэгтэй байгаа харагдаж байна. Тэгэхээр дараагийн энэ цалингийн өөрчлөлт ортлоо энэ асуудлуудаа холбогдох байгууллагууд нь хийгээсэй гэж хүсэж байна.

Тэгээд дээр нь зүгээр нэг тодруулах юм байна. Энэ шүүгч бус гишүүдийн цалин, энэ тогтоол нь бол 23 оны тогтоолд өөрчлөлт орж байх шиг байна. Тэгэхээр одоо ямар хугацаанд энэ цалин өөрчлөгдөөгүй, бусад одоо өөрчлөлт шүүгч гишүүнээсээ шүүгч бус гишүүнүүдийн цалин нь одоо энэ өөрчлөлт орж байгаа 10 хэдэн хувиараа зөрөөтэй байна уу, эсвэл дахиад өөр зөрөө байна уу гэдэг талаар хариулт өгөөч?

Ж.Бат-Эрдэнэ: Цогтбаатар гишүүн хариулъя.

Д.Цогтбаатар: Тийм, өөр зөрөө байхгүй. Наадах чинь одоо яг тэр тогтоолоороо л яг өөрийн чинь түрүүн Эрдэнэбат гишүүний ярьж байгаа ч яг зөв. Өнөөдөр бид байгаа хуулийнхаа хүрээнд л орж ирж байгаа нь энэ байхгүй юу. Энийг бид өөрчлөхгүй бол нээрээ болохгүй, энэ ингээд автономио тэнд нэгэнт тэр шийдвэр гараад явж байгаа бол өөрсдөө тэр хүрээндээ шийдээд явах боломжийг нь олгоё гэсэн энэ шийдлийг бол ярьсан байгаа. Гэхдээ өнөөдөр яг асуудал нь ийм биш болохоор ингээд л орж ирж байгаа байхгүй юу хуулийнхаа дагуу, түүнээс бол тэр зөв, зөв.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм, энэ нөгөө хуулийг дахиж ийм юм орж ирэхгүй байх хуулийн төслийг би одоо яг мэдэхгүй байна л даа. Аль субъект, хэн санаачилж орвол, ямар хуульд орвол өөрчлөлт орвол зүгээр вэ? Ер нь энэ тал дээр ХЗБХ-ноос чиглэл өгөөд ажиллах бололцоотой уу?

Ж.Бат-Эрдэнэ: Дамдины Цогтбаатар.

Д.Цогтбаатар: Тийм, энэ дээр бид шийдлүүд ярьсан, ер нь бол тусдаа яг нөгөө өмнөх тогтоол шиг тогтоол гаргаад, энэ дээр бол цаашдаа цалингаа түүгээрээ яг уялдуулаад шийдээд явж бай гээд. Жишээлбэл, шүүх чинь өөрөө хараат бус болохоор цалингаа өөрсдөө тогтоож байгаа байхгүй юу. Тэгээд тэр эрхийг нь бид өгчихсөн. Тэгсэн нөгөө шүүгч бус гишүүдэд үнэхээр өнөөдрийн хуулиар энэ нь хамрахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо бид бол нэг ярьсан нэг хувилбар нь бол ингээд тогтоол гаргаад энийг жигдлээд та нар цаашдаа өөрсдөө шийдээд явж бай гэдэг л юу гаргах хэрэгтэй байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Яах вэ, зарчим нь өөрөө миний хувьд бол буруу явж байна гэж үзэж байна. Яагаад гэхээр уг нь бол шүүгч бус гишүүний цалинг нь түүгээрээ тогтоох эрхийг нь өгөх тогтоол орж ирэх ёстой байсан болохоос биш цалинг нь нэмэх тогтоол биш байхгүй юу даа, уг нь бол яг алдааг нь засах гэж байгаа бол. Гэтэл ингээд он нэлээд явчихсан, өнөөдөр чинь 6 сарын 26. Тэгээд нэг байгууллагын зарим цөөхөн хэдхэн хүний цалингийн хэмжээг нь шинэчлэн тогтоох ийм асуудлыг УИХ өнөөдөр оруулж байгаа нь бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, хэн нэгэнд давуу байдал үүсгэж байгаа асуудал болчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр санаа нь зөв боловч арга нь бол буруу байна гэж хэлмээр байна. Уг нь бол өөрсдөө тогтоох эрхтэй, шүүгчийн цалинг нь өөрсдөө тогтоох эрхтэй юм бол тэр эрхийг нь шүүгч бус гишүүн дээр нь л өгөх ийм тогтоол байсан бол хэн ч барьцахгүй.

Гэтэл тэр эрх нь байхгүй байгаа учраас бид одоо цалинг нь тогтоож байна гэж энэ хүмүүсийн цалингийн асуудлыг нь 800 мянган төгрөгөөр нэмэгдүүлж байна шүү дээ. Одоо бусдаасаа ямар өндөр байгаа билээ, тэгээд тэрийг нь дахиад нэмэгдүүлээд энэ чинь бусдад ямар дохио өгч байна вэ гэхлээр УИХ зөвхөн шүүгчдэд л анхаардаг юм байна гэдэг ийм асуудал, ийм дохио өгчхөж байгаа байхгүй юу. Тэгээд одоо яах гэх вэ ингээд ороод ирчихсэн юм байна. Гэхдээ манай хандлага өөрөө буруу байна. Энэ цалин хөлсний ер нь ингээд нэгдсэн бодлого явуулаад, тэгээд бүх байгууллагуудаа нэгэн адил харж байхгүй бол ээж, аав өөрийнхөө хүүхдүүдийг ялгаварлаж байгаатай яг адилхан. Зарим байгууллагууд нь чимээгүй байдаг учраас, жагсдаггүй учраас, гомдол мэдүүлдэггүй учраас бага цалинтай, тэгээд одоо хүртэл ингээд бага цалинтай хэвээрээ явж байгаа. Гэтэл тэгээд маш өндөр зөрөө үүсчихсэн асуудлууд байгаа. Тэгээд энэ дээр л анхаараасай гэж энэ үгийг хэллээ.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн. Сая үг хэлье гээд байсан хааччихав, алга байна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэллээ. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна, 16:00 цагаас санал хураалт явах ёстой байсан.

16.45 цаг

***Хорь.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа
нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг УИХ-ын гишүүн Уянгахишиг танилцуулна.

Г.Уянгахишиг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2026 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Шагдарын Үнэнтөгс ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Эрдэнэцогтын Дарханцэцэг УИХ-ын гишүүний зөвлөх. Та бүхэнд Монгол УИХ-ын тухай хуулийн 21.24, 21.25, 21.31-д заасан нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв мэдээлэл өгөх, хэрэв худал мэдээлэл өгвөл Төрийн албаны тухай хууль болон холбогдох хуулиар хариуцлага хүлээнэ гэсэн хуулийн заалтыг та бүхэнд танилцуулъя.

УИХ-ын Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Урьдчилсан ирүүлсэн нэрсийг өгнө үү. Эрдэнэболд гишүүн алга байна, Батын Батбаатар гишүүн алга байна, Ренчинбямбын Сэддорж гишүүн алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүлээ.

16.49 цаг

Санал хураалтыг 16:00 цагаас хийх ёстой, гишүүдийг, 16:00 өнгөрчихсөн байна, гишүүдийг танхимд урья. Хэлэлцэх асуудлуудаа хэлэлцээд явж байна.

Гишүүдийг танхимд урья. Дуусаагүй байна. Дараагийнхаа асуудлыг хэлэлцээд явж байя.

Хорин нэг. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүн 2025.11.07-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төсөл, төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Пүрэвийн Батчимэг гишүүн танилцуулна. Батчимэг гишүүнийг индэрт урьж байна.

П.Батчимэг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүнээс 2025 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төслийг БОХХАА-н Байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч 1992 оноос 2025 оныг хүртэлх хугацаанд Улаанбаатар хотод олгосон газар олголтын шийдвэрүүд хууль, журамд нийцсэн эсэх, газар ашиглалтын байдал, гарсан алдаа зөрчил, газар олголтын үр дагаварт бий болсон нийтийн эрх ашигт харшлах асуудлыг тодорхойлох, цаашид газар ашиглалт, өмчлөлийн ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн санал, дүгнэлт гаргах зорилгоор Хянан шалгах түр хороо байгуулах санал гаргаж, УИХ-ын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар уг тогтоолын төслийг хэлэлцэхдээ Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.2, 33.4, 33.5, 33.6-д заасны дагуу УИХ дахь нам, эвслийн бүлгээс ирүүлсэн нэрийг өөрчлөхгүйгээр хэлэлцлээ. Тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед УИХ-ын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг баримтлан тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар Монгол Улсын Үндсэн хуульд харшилсан эсэх талаар санал хураалт явуулах үед хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 52.6 хувь нь Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж, тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх БОХХАА-н Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Төслийн талаарх БОХХАА-н Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонслоо. УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга Батсүмбэрэл.

Н.Батсүмбэрэл: Энэ өдрийн мэнд хүргэе. Хуралдаан даргалагчаас завсарлага хүсэж байна. МАН-ын бүлгээс түр хороонд орсон зарим гишүүд

хасагдах, нэр өөрчлөгдөх саналтай байгаа тул энэ асуудлаар 5 хоногийн завсарлага авах хүсэлтэй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын 2 өдрөөр, нэг дэх өдрийг дуустал 2 хоногийн завсарлага өглөө.

16.54 цаг

Одоо санал хураалттай тул УИХ-ын гишүүдийг танхимд урьж байна. Санал хураалттай тул УИХ-ын гишүүдийг танхимд урьж байна. Өнөөдөр 16:00 цагаас санал хураалт явуулна гэж байсан боловч хэлэлцэх ёстой асуудлуудаа хэлэлцээд 17:00 цаг болж байна. Одоо бүх хэлэлцэх асуудлуудаар санал хураалт явуулна, УИХ-ын гишүүдийг чуулганы танхимд урьж байна.

Санал хураалт явагдана, УИХ-ын гишүүдийг танхимд урьж байна, УИХ дахь намын бүлгийнхэн, бүлгийн дарга нар гишүүдээ цуглуулъя.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 17 цаг 28 минутаас хуралдааныг даргалав.

Гишүүдийг чуулганы танхимд урьж байна. Үдээс хойших чуулганы санал хураалтууд явах ёстой, санал хураалтуудаа явуулъя. Бүлгүүдийн ажлын алба, бүлгийн дарга, дэд дарга нар, хуралдаан зохион байгуулах, Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдийг танхим руу нь явуулна уу. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэх хооронд дараагийн асуудал.

Хорин хоёр.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-т УИХ энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг холбогдох Байнгын хороо бэлтгэж, УИХ-д танилцуулахад бэлэн болсон байна.

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2.Дагалдан гарсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3.Хуулийн төсөл буцаах тухай УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан боловсруулсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна, сонссонд тооцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга дээр сонссонд тооцлоо.

Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна, сонссонд тооцлоо.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна, сонссонд тооцлоо.

17.31 цаг

Татаж авч байгаа нэг хууль байгаа билүү. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.3-т Энэ хуулийн 32.1, 32.2-т заасны дагуу хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг УИХ-д ирүүлэх бөгөөд УИХ-ын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно.

Үүний дагуу Монгол УИХ-ын гишүүн Одонгийн Цогтгэрэлээс хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг татан авах тухай бичиг ирсэн байна. Уншиж танилцуулъя. УИХ-ын гишүүн миний бие болон УИХ-ын гишүүн Жаргалан, Очирбат нарын хамт санаачлан боловсруулсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй нэгтгэн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг хийсэн болно. Анхны хэлэлцүүлгийн шатанд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг ажлын хэсгээс татан авах санал гаргасан тул хууль санаачлагчийн зүгээс дээрх хуулийн төслүүдийг татан авах нь зүйтэй гэж үзлээ.

Иймд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг татан авч байгаа тул тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт заасны дагуу нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулж өгнө үү. УИХ-ын гишүүн Цогтгэрэл, Жаргалан, Очирбат гэсэн бичиг ирсэн байна, та бүхэнд уншиж танилцууллаа. Татан авсанд тооцлоо.

Гишүүд ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэлийн санал хураалт. 54 гишүүн ирцдээ орсон байна. Татгалзсан нь гарч байгаа энэ 44 гишүүнийг чуулганы хуралдааны танхимд хүрэлцэн ирэхийг урья. Урьж байна, гишүүдийн зөвлөх, туслахууд, ажлын алба. Болормаа гишүүн байна. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын

зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагддаг 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 35 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Нэг.Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал.

1.Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

1.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.7 дахь заалтын “дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө” гэснийг “хамтран өмчлөх дундын хөрөнгөө” гэж, 9.1 дэх хэсэг, 9.2.8 дахь заалтын “эд” гэснийг тус тус хасаж, 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 9.2 дахь хэсэг болгох:

“9.2.Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд дараах үүрэг хүлээнэ:

9.2.1.бие биеэ тэжээн тэтгэх, асран халамжлах;

9.2.3.бие биеийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, зөрчихгүй байх;

9.2.3.гэр бүлийн угийн бичиг хөтлөх;

9.2.4.гэр бүлийн үнэт зүйл, үндэсний соёл, уламжлал, зан заншлыг эрхэмлэх;

9.2.5.хамтын үүрэг, хариуцлагаа ухамсарлан бие биедээ үнэнч байх, гэр бүлийн хамтын амьдралаа тогтвортой байлгах, гэр бүлийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх.” Санал гаргасан ХЗБХ. Санал хураалт. Санал хураалтад 98 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Гэрлэлт дуусгавар болох

10.1.Гэрлэлтийг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно:

10.1.1.гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан;

10.1.2.гэрлэгчдийн хэн нэгийг нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсон гэж тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

10.1.3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн.

10.2.Гэрлэлт дараах тохиолдолд дуусгавар болно:

10.2.1.захиргааны, эсхүл шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан;

10.2.2.гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон.

10.3.Энэ зүйлийн 10.1.3-т заасан хүйсийн өөрчлөлт тухайн хүний хөрөнгийн эрх болон эцэг, эхийн эрхийг хязгаарлах, үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад 98 гишүүн орсноос 54 гишүүн буюу 55 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах

13.1.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад тохиолдолд гэрлэлт цуцлуулах асуудлыг гэрлэгчдийн хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.2.Энэ хуулийн 10.1.3-т заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө иргэний улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, гэрлэлт дуусгавар болсон бол гэрлэлт цуцлахаас бусад хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг, хамтран өмчлөх дундын хөрөнгө хуваах асуудлаар гэрлэгчид нэхэмжлэл гаргах үүрэгтэй бөгөөд эдгээр асуудлыг уг нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.3.Гэрлэгчид гэрлэлтийн гэрээнд хөрөнгийн эрх, үүргийг тусгасан эсэхээс үл хамаарч, гэрлэлт цуцлуулах үед хөрөнгийн эрх, үүргийн талаар харилцан тохиролцож болно.

13.4.Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын хөрөнгө хуваах асуудлыг бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.

13.5.Шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

13.6.Шүүх гэрлэлт цуцлахдаа нэхэмжлэлийн шаардлагаас үл хамааран дараах асуудлыг шийдвэрлэнэ:

13.6.1.хүүхдийн асрамж;

13.6.2.хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь /нөхцөл, хэлбэр, байршил, хугацаа/;

13.6.3.тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардал.

13.7.Шүүх энэ хуулийн 13.6.1, 13.6.2-т заасан асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хангаж, дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

13.7.1.хүүхдийн нас, бие махбод, оюун санаа, нийгэмшихүй, танин мэдэхүй, сэтгэхүй, хөгжил, сэтгэл зүйн онцлогт нийцсэн хэрэгцээ, шаардлагыг;

13.7.2.хүүхэд долоо, түүнээс дээш настай бол түүний саналыг;

13.7.3.хүүхдийн эцэг, эх, ах, эгч, дүү, эмээ, өвөө болон түүний амьдралд чухал нөлөө бүхий бусад хүнтэй тогтоосон харилцаа, ээнэгшсэн дассан байдал;

13.7.4.эцэг, эхийн хүүхдийг асран хамгаалж, хүмүүжүүлэхэд оролцож байсан оролцооны байдал, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, чадавхыг;

13.7.5.хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх төлөвлөгөө, хүүхэдтэй харилцах чадвар, эцэг, эхийн амьдралын хэв маяг, эрүүл мэнд, эрхэлсэн ажил, ажлын цагийг;

13.7.6.гэрлэгчид хүүхдийн асрамжийн асуудлаар тохиролцсон эсэхийг;

13.7.7.эцэг, эхийн зан байдал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эсэх, хүүхдэд үзүүлэх нөлөөг.

13.8.Гэрлэгчид хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцсэн байдлаар өөрөөр тохиролцоогүй бол шүүх энэ хуулийн 13.6.1-д заасан хүүхдийн асрамжийг хэрэгжүүлэхээр тогтоогдсон эцэг, эсхүл эхэд хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрхийг олгоно.

13.9.Шүүх энэ хуулийн 13.6.3-т заасан тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардлыг энэ хуулийн долдугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

13.10.Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авч, хамтран ажиллаж болно.

13.11.Эхнэр нь жирэмсэн, эсхүл хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзана.

13.12.Гэрлэгчдийн хэн нэгний хүчирхийллээс болж, гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд аюул, хор уршиг учирч болзошгүйн улмаас гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг гаргахад энэ хуулийн 13.11-д заасан нь саад болохгүй.

13.13.Энэ хуулийн 13.11-д заасан нөхцөл байдал арилсан бол гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.”

Тайлбар: -Энэ хуулийн 13.6.1-д заасан “хүүхдийн асрамж” гэж хүүхдийг хэний асрамжид үлдээх буюу хүүхдийн амьдрах газрыг ойлгоно.

-Энэ хуулийн 13.8-д заасан “хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрх” гэж хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүүхэд гадаад улсад зорчих, шашин шүтэх, эс

шүтэх, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх дугуйланд сургах зэрэг хүүхдийн хөгжил, хүүхдийн хуваарьт хөрөнгийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиран зарцуулах талаар шийдвэр гаргах эрхийг ойлгоно.

-Энэ хуулийн 13.11-д заасан “хүнд өвчтэй” гэж гэрлэгчдийн хэн нэг нь баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалтад заасан өвчтэй бөгөөд шүүхэд гэрлэлт цуцлуулах асуудлыг хэлэлцэх үед өвчин нь хүндэрсэн шатандаа орсны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжгүй болох нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байхыг ойлгоно. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 52 буюу 53 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Шүүх гэр бүлийн нэг гишүүнд ногдох хөрөнгийг тодорхойлох

15.1.Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хэсгийг тодорхойлоход гэрлэлтийн гэрээ, эсхүл гэрлэлтийн гэрээ байгуулаагүй бол Иргэний хуулийн 129, 130 дугаар зүйлд заасны дагуу шүүх шийдвэрлэнэ.

15.2.Гэрлэлтээс гадуурх харилцааны, эсхүл гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэрлэлт цуцалсан, эсхүл гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлын үүднээс гэрлэлт цуцалсан, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол Иргэний хуулийн 129.3-т заасны дагуу гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо шүүх өөрөөр тогтоож болно.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл.Хүүхдэд нэр, эцэг /эх/-ийн нэр, овог өгөх

24.1.Эцэг, эх харилцан зөвшилцсөний үндсэн дээр хүүхдэдээ нэр өгнө.

24.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хүүхэд эцгийн овог, нэрийг авна.

24.3.Хүүхдийн эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлээгүй бөгөөд харилцан тохиролцоогүй, эсхүл хүүхдийн эцгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогоогүй, эсхүл эцэг, эхийн хэн нэгний өмнөх гэрлэлт дуусгавар болоогүй бол эх нь хүүхдэд нэр өгөх бөгөөд хүүхэд эхийн овог, нэрийг авна.

24.4.Хүүхдийн эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй бол улсын бүртгэлийн байгууллага хүүхдэд нэр, овог, эцэг /эх/-ийн нэр өгч болно.

24.5.Дараах тохиолдолд хүүхдийн эцэг, эсхүл эхийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хүүхдэд овог, эцэг /эх/-ийн нэр өгнө:

24.5.1.хүүхдийн эцгийг тогтоосон бол эцгийн овог, нэрийг;

24.5.2.эцэг нь тодорхойгүй бөгөөд хүүхдийн эхийг тогтоосон бол эхийн овог, нэрийг.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 53 гишүүн буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 33 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32 дугаар зүйл болгох:

“32 дугаар зүйл.Хүүхдийн асрамж, хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн эрх, үүрэг

32.1.Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бусад шалтгаанаар хүүхдийн оршин суугаа газраас өөр газарт оршин сууж байгаа нь хүүхдийн өмнө хүлээх эцэг, эхийн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

32.2.Хүүхдийн асрамж, хүүхдийн талаар шийдвэр гаргах болон тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарьтай холбоотой гаргасан шүүхийн шийдвэрийг эцэг, эх биелүүлэх үүрэгтэй.

32.3.Хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхдийн талаар мэдээлэл авах эрхтэй.

32.4.Хүүхдийн талаар шийдвэр гаргах эрхтэй эцэг, эсхүл эх нь хүүхдийн асуудлаар гаргасан аливаа шийдвэрийн талаар тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

32.5.Эцэг, эхийн хэн нэг нь, эсхүл 14 насанд хүрсэн хүүхэд тухайн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хүүхдийн асрамж болон хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарийн талаарх шүүхийн шийдвэрийг өөрчлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

32.6.Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бусад шалтгаанаар эцэг, эх тусдаа амьдарч байгаа бол энэ хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хэн нэгэндээ саад учруулахыг хориглоно.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 53 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 49 дүгээр зүйлийг 46 дугаар зүйл болгож, 49.4 дэх хэсгийн “49.1-д” гэснийг “46.1-д” гэж, 49.5 дахь хэсгийн “49.4-т” гэснийг “46.3-т” гэж, 49.8 дахь хэсгийн “хүүхдийн” гэснийг “түүний” гэж тус тус өөрчилж, 49.3 дахь хэсгийг хасаж, 49.1, 49.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.1, 46.2 дахь хэсэг болгох:

“46.1.Талууд энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бол шүүх энэ хуулийн 46.2-т заасан тэтгэлэг тогтоох аргачлалын дагуу хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг харгалзан тэтгэлэг тогтооно.

46.2.Тэтгэлэг тогтоох аргачлалыг сар, улирал, хагас жил, эсхүл жилээр төлөх тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, тэтгэлэг авагчийн хэрэгцээ, шаардлага, хүүхдийн нас, тоо, хүүхэдтэй уулзах хуваарь зэрэг нөхцөл байдлыг харгалзан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” Санал хураалт. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 54 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 53 дугаар зүйл болгох:

“53 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөх

53.1.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бөгөөд шүүхийн шийдвэрээр тэтгэлгийн хэмжээг тогтоосны дараа энэ хуулийн 44, 45 дугаар зүйлд заасан тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдал өөрчлөгдсөн бол тэтгэлэг авагчийн, эсхүл тэтгэлэг төлөгчийн нэхэмжлэлийн үндсэн дээр тэтгэлгийн хэмжээг өөрчлөх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

53.2.Шүүх энэ хуулийн 53.1-д заасан асуудлыг шийдвэрлэхдээ энэ хуулийн 46.2-т заасан аргачлалын дагуу дахин тогтооно.

53.3.Эцэг, эх, эсхүл төрлийн хүн нь хүүхдийг энэ хуульд заасан хугацаанд тэжээн тэтгэх, өсгөн хүмүүжүүлэх үүргээ ноцтой зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол хүүхэд 18 насанд хүрснээс хойш эцэг, эх, эсхүл төрлийн хүнээ тэжээн тэтгэх үүргээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөж болно.

53.4.Тэжээн тэтгүүлэгчийн тэжээн тэтгүүлэх эрхийн үндэслэл арилсан бол энэ хуулийн 43.1-д заасан этгээдийн тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болно.

53.5.Тэжээн тэтгүүлэгч нь тэжээн тэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, хүчирхийлсэн, дарамталсан, гэм хор учруулсан, эсхүл учруулахаар завдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол тэтгэлэг төлөгчийг тэжээн тэтгэх үүргээс шүүхийн шийдвэрээр чөлөөлнө.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 56 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 66 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 65 дугаар зүйл болгох:

“65 дугаар зүйл.Үрчлэгчийн эрх, үүрэг, хориглох зүйл

65.1.Үрчлэгч нь эцэг, эхийн нэгэн адил энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

65.2.Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн чадамжтай, эрүүл мэндийн болон эдийн засгийн бүрэн чадавхтай хүн байх бөгөөд ашиг олох зорилгоор хүүхэд үрчлэн авахыг хориглоно.

65.3.Хүүхдийг дараах хүнд үрчлүүлэхийг хориглоно:

65.3.1.бусдын асрамж, дэмжлэгт байгаа хүн;

65.3.2.ганц бие 65, түүнээс дээш настай хүн;

65.3.3.шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тогтоогдсон хүн;

65.3.4.эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан хүн;

65.3.5.үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн хүн;

65.3.6.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүн;

65.3.7.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар эцэг, эх байх эрх, үүргийг биелүүлж чадахгүй болох нь тогтоогдсон хүн;

65.3.8.хорих ял эдэлж байгаа, эсхүл Эрүүгийн хуульд заасан хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж, эсхүл Эрүүгийн хуульд заасан бусад гэмт хэрэгт удаа дараа ял шийтгүүлж байсан хүн;

65.3.9.бүртгэлтэй хаяг дээрээ амьдардаггүй, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй орчинд амьдардаг хүн.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 53 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 68 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 67 дугаар зүйл болгох:

“67 дугаар зүйл.Хүүхэд үрчлэлтийн бүртгэл, хяналт

67.1.Хүүхэд үрчлүүлэх эсэх шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор тухайн шүүх шийдвэрийн хувийг улсын бүртгэлийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

67.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь үрчлэлтийн мэдээллийн сан /хүүхэд үрчлэх хүсэлтэй иргэн, үрчлүүлэх хүүхдийн болон үрчлэгдсэн хүүхэд, үрчилж авсан иргэний мэдээлэл/ бүрдүүлнэ.

67.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд түүнийг 18 насанд хүртэл хагас жил тутамд хяналт тавьж, хүүхдийн хөгжлийн тайланг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

67.4.Энэ хуулийн 67.2-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, энэ хуулийн 67.3-т заасан үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

67.5.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн нөхцөл байдал бий болсныг тогтоовол хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

67.6. Сонирхогч тал үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл үрчлэлтийг хүчингүй болсонд тооцуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй.” Санал хураалт. 98-аас 56 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11. Төслийн 83 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 82 дугаар зүйл болгох:

“82 дугаар зүйл. Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх

82.1. Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхэд Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хуулийг дагаж мөрдөнө.

82.2. Монгол Улсын харьяат хүүхдийг Монгол Улсын иргэн үрчлэн авах хүсэлт гаргаагүй бол хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцүүлэн хүүхэд үрчлэн авахаар хүсэлт гаргасан гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлнэ.

82.3. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий гадаад үрчлэлтийн орон тооны бус зөвлөл /цаашид “Гадаад үрчлэлтийн зөвлөл” гэх/ ажиллана.

82.4. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллага, эсхүл зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн байгууллагаар дамжуулан Гадаад үрчлэлтийн зөвлөлд гаргана.

82.5. Монгол Улсад 6 сараас доошгүй хугацаанд байнга оршин сууж байгаа гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах хүсэлтээ энэ хуулийн 82.4-т заасан байгууллагаар дамжуулалгүйгээр Гадаад үрчлэлтийн зөвлөлд гаргана.

82.6. Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэн үрчлэн авахад энэ хуулийн 64, 65 дугаар зүйлд заасныг нотлох тайланг өөрийн улсын эрх бүхий байгууллагаас гаргуулж, энэ хуулийн 82.9-д заасан журмын дагуу ирүүлнэ.

82.7. Гадаад үрчлэлтийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн улс хооронд хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэх бөгөөд үрчлэгдсэн эсэх тухай шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын таван өдрийн дотор улсын бүртгэлийн болон гадаадын иргэний асуудал хариуцсан байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

82.8. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх тухай шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор үрчлэгчид мэдэгдэж, шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

82.9. Энэ хуулийн 82.3-т заасан Гадаад үрчлэлтийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

82.10.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг тухайн улсын хуулийн дагуу үрчлүүлсэн нь Монгол Улсын олон улсын гэрээ, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд харшлаагүй бол хүлээн зөвшөөрч болно. 82.11.Энэ хуулийн 65.3-т зааснаас гадна Монгол Улсаас албадан гаргасан, Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байхаар тогтоосон хугацаа нь дуусаагүй байгаа гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 57 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 84 дүгээр зүйлийг 83 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“83 дугаар зүйл.Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих

83.1.Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийн мэдээллийг энэ хуулийн 67.2-т заасан үрчлэлтийн мэдээллийн санд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтмол нийлүүлнэ.

83.2.Улс хооронд үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд тавих хяналтыг Дипломат төлөөлөгчийн газар хэрэгжүүлнэ. Дипломат төлөөлөгчийн газар байхгүй тохиолдолд Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, мэдээлэл авна.

83.3.Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэн, гэр бүл нь хүүхдийн хөгжлийн тайланг 18 насанд хүртэл хагас жил тутамд энэ хуулийн 83.2-т заасан байгууллагаар дамжуулан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад болон гадаадын иргэний харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

83.4.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдсан, эсхүл тогтоогдсон бол Дипломат төлөөлөгчийн газар, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гадаадын иргэний харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

83.5.Гадаад улсад оршин суугаагаас бусад гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд заасан хяналт тавьж, хүүхэд хөгжлийн тайланг хагас жил тутамд гаргана.

83.6.Гадаад улсад оршин суугаагаас бусад гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдсан, эсхүл тогтоогдсон бол хүн, хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

83.7.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсний дараа хяналт тавих, үрчлэгч талтай гэрээ байгуулах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон

хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 83.8. Сонирхогч тал улс хооронд үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл үрчлэлтийг хүчингүй болсонд тооцуулах нэхэмжлэлийг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн хүүхдийг үрчлүүлэх шийдвэр гаргасан шүүхэд гаргаж, шийдвэрлүүлнэ.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Номтойбаяр гишүүн. Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Сая дэмжиж санал өгсөн, татгалзсанаар гарчихсан учраас саналыг хүчингүй болгож, дахиж хурааж өгөхийг хүсье. Амарсайхан гишүүний санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалт явуулъя. 98-аас 51 буюу 52 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Сая саналын томъёоллыг уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя. 98-аас 52 буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр. Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 8¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8¹.1. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 53 буюу 54 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.1.5, 6.1.6 дахь заалт болгох:

“6.1.5. донорын бэлгийн эс ашиглаж хүүхэд төрсөн бол түүнийг нотлох эмнэлгийн байгууллагын магадлагаа болон хоорондын байгуулсан гэрээ;

6.1.6. донорын бэлгийн эс ашиглан тээгч эхээс хүүхэд төрсөн бол түүнийг нотлох эмнэлгийн байгууллагын магадлагаа болон хоорондын байгуулсан гэрээ.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.19, 6.20 дахь хэсэг нэмэх:

“6.19. донорын бэлгийн эс ашиглаж төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг Гэр бүлийн тухай хуулийн 27.2-т заасан эцэг, эхийн овог, нэрээр бүртгэж, төрсний гэрчилгээ олгоно.

6.20. донорын бэлгийн эс ашиглан тээгч эхээс төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг Гэр бүлийн тухай хуулийн 27.2-т заасан эцэг, эхийн овог, нэрээр бүртгэж, төрсний гэрчилгээ олгоно.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 53 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.3.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцалсан бол гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 52 буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Гэрлэлт сэргээсний бүртгэл

9.1.Гэр бүлийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу иргэн гэрлэлт сэргээсний бүртгэлд бүртгүүлэх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, өөрийн биеэр бүртгүүлнэ:

9.1.1.тус тусдаа гаргасан өргөдөл;

9.1.2.иргэний үнэмлэх, эсхүл иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, эсхүл паспортыг орлох баримт бичиг.

9.2.Гэр бүлийн тухай хуулийн 18.2, 18.3-т заасны дагуу гэрлэлтийг сэргээсэн бол гэрлэлт сэргээсэн тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

9.3.Иргэнийг нас барсан гэж зарласан, сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 9.2-т заасан баримт бичигт хавсаргана.

9.4.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

9.5.Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан энэ хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор гэрлэлт сэргээсний бүртгэлийг хөтөлнө.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлд “Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн” гэсний дараа “7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “8 дугаар зүйлд” гэснийг “5.3-т” гэж, мөн зүйлийн 7.8 дахь заалтын “9 дүгээр” гэснийг “7 дугаар” гэж” гэж нэмэх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 53 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн ““нас барсны бүртгэлд” гэснийг “Гэр бүлийн тухай хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.4-т заасан тохиолдол бий болсон” гэж” гэснийг ““Гэрлэгч нас барсны бүртгэлд бүртгэгдсэн” гэснийг “Гэрлэгч нас барсны, эсхүл хүйс өөрчлөгдсөн бүртгэлд, эсхүл нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэж” гэж өөрчлөх. Санал

гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 127 дугаар зүйлийн 127.4, 127.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 127 дугаар зүйлийн 127.7 дахь хэсгийг 127.5 дахь хэсэг болгох. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 53 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт буюу 517 дугаар зүйлийн 517.3 дахь хэсэг нэмэх:

“517.3.Өвлүүлэгчийг 18 насанд хүртэл тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол өвлөх гэрээслэлд өөрөөр заагаагүй тохиолдолд уг этгээд хуульд заасан өвлөх эрхээ алдана.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 55 буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 129 дүгээр зүйлийн 129.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“129.3.Гэрлэлт дуусгавар болсонтой холбоотойгоор гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийг тодорхойлохдоо хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал болон хуульд заасан бусад нөхцөлийг харгалзан шүүх өөрөөр тогтоож болно.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 133 дугаар зүйлийн 133.2 дахь хэсгийн “энэ хууль болон” гэснийг, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 517 дугаар зүйлийн 517.1 дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 55 буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн “127.6” гэснийг “127.4” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 52 буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт,” гэснийг “заалтын” гэж өөрчилж, “мөн зүйлийн 7, 9 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 55 буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт нэмэх:

1/6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт:

“1.1.4.хүүхдээ үе тэнгийн дээрэлхэлт үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй;” санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “торгох, эсхүл албадан сургалтад хамруулж, долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэснийг “торгоно.” гэж өөрчилж, мөн зүйлийн 14, 15 дахь хэсгийг төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт болгох. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 54 хувь буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалтын дугаарыг “1.1.5” гэж өөрчлөх.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 98-аас 55 буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгох. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 52 буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “55.2.1-55.2.6, 55.3.1-55.3.6-д” гэснийг “54.1, 54.2-т” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Долоо.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.7.“бүтэн өнчин хүүхэд” гэж Гэр бүлийн тухай хуулийн 4.1.2-т заасныг.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 52 буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгасан санал:

Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 60 дугаар зүйлийг 59 дүгээр зүйл болгож, 60.1.1 дэх заалтын “сурч” гэсний өмнө “хөгжүүлэх,” гэж нэмж, 60.1.3 дахь заалтын “үл хөдлөх эд хөрөнгө, мал, банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг” гэснийг “хөрөнгийг” гэж, “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.1.4 дэх заалтын “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.2.3 дахь заалтын “асрамж,” гэснийг “асран хамгаалалт, харгалзан” гэж, 60.2.4 дэх

заалтын “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж, 60.2.5 дахь заалтын “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 60.3 дахь хэсгийн “бага насны” гэснийг “долоон насанд хүрээгүй” гэж тус тус өөрчилж, 60.2.4 дэх заалтын “, дэнчин тавих” гэснийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалтад 98 гишүүн орсноос 54 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 75 дугаар зүйлийг 74 дүгээр зүйл болгож, 75.1 дэх хэсгийн “хуулийн зарчимд харшлахгүй бол гэрлэлтийг Монгол Улсад хүчинтэйд тооцно.” гэснийг “хуульд заасан нөхцөлийг хангаж, гэрлэхэд харшлах шалтгаангүй бол Монгол Улсад гэрлэлтийг хүчин төгөлдөр гэж үзэж, хүлээн зөвшөөрнө.” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 55 буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 82 дүгээр зүйлийг 81 дүгээр зүйл болгож, 82.2 дахь хэсгийн “хуулиар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол хүчинтэйд” гэснийг “хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. 98-аас 56 буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүллээ. Ажлын хэсэг, ХЗБХ-нд баярлалаа. Манай олон гишүүд Баасанжаргал гишүүн, Алтангэрэл нарын гишүүд ажлын хэсэг ахалсан. Дахиад санал хураалттай шүү гишүүдээ. Байгаа шүү.

18.12 цаг

Дараагийн асуудал, хэддүгээр хуудас вэ, энэ үү. Гишүүд, аль хууль билээ энэ чинь. Нийгмийн даатгалын, дагасан Золжаргал гишүүнээ, дагасан хууль дээр Байнгын хорооноос горимын санал гаргасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү. Гишүүд, санал хураалт. Гишүүдээ анхааралтай байгаарай. Байнгын хорооноос нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 98 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүллээ.

18.14 цаг

Дагасан хууль байгаа. Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалт. Байнгын хорооноос Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүллээ.

18.15 цаг

Дараагийн асуудал. Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя. Байнгын хорооноос Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98-аас 55 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүллээ.

18.16 цаг

Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. Байнгын хорооноос Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98-аас 55 буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүллээ.

18.17 цаг

Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя. Байнгын хорооноос Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүд олонх дэмжсэн тул Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ руу шилжүүллээ.

18.19 цаг

Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя. Байнгын хорооноос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 98-аас 54 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүллээ.

18.20 цаг

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 3 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль шүү.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу санал хурааж, дэмжсэн санал:

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.“37 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч

37.1.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилох бөгөөд сэтгэл зүйч нь төрийн захиргааны албан хаагч байна.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан сэтгэл зүйч нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож болох бөгөөд ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ХЗБХ. Санал хураалт. 98-аас 51 гишүүн буюу 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн нэрийг “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” гэж өөрчилж, төслийн 1, 2, 3, 4, 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн онцлог, зориулалтад нийцсэн, стандартын шаардлага хангасан шүүхийн барилга байгууламж шинээр барих байршил, газрын асуудлыг судалж, шийдвэрлэх;

2/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн барилга байгууламжийг барихад шаардагдах зардал болон гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх бусад шүүхийн барилгад зориулалтын шүүх хуралдааны танхим, хүүхдээс мэдүүлэг авах тусгай өрөө байгуулах асуудлыг судалж, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх арга хэмжээг авах;

3/Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтад Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч, мэргэжилтнийг бэлтгэх, тэдгээрийн цалин хөлс болон үйл ажиллагаа, чиг үүрэгт холбогдох шаардлагатай зардлыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх;

4/гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, шүүхийн цахим үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хэрэг, маргааныг үр дүнтэй шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх.

2.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөл /П.Золзаяа/-д даалгасугай:

1/Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтад заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтнийг сургах;

2/гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчийг мэргэшүүлэн сургах;

3/гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж, хэрэгжүүлэх.

3.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи /Д.Эрдэнэчимэг/-д даалгасугай:

1/гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг мэргэшүүлэн шинээр батлагдсан хууль тогтоомж, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр сургаж, бэлтгэх;

2/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх болон дүүргийн, сум, сум дундын анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлалын багт ажиллах шүүгчийг бэлтгэх, шаардлагатай сургалтад хамруулах.

4.Өсвөр насны хүнд авсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, бэлтгэл ажил хангахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/, Хууль зүй, дотоод хэргийн сайд /С.Амарсайхан/-д тус тус даалгасугай.

5.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байгаа боловч хугацаанаас өмнө суллагдах боломжтой өсвөр насны хүний талаарх мэдээллийг хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтран гаргаж, хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд /С.Амарсайхан/, суллагдсан өсвөр насны хүүхдэд хяналт тавьж, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/-д тус тус даалгасугай.

6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор хамтран хэрэгжүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/, Шүүхийн ерөнхий зөвлөл /П.Золзаяа/-д тус тус даалгасугай.

7.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт заасан “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам”-ыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаан баталж, хэрэгжүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/, Хууль зүй, дотоод хэргийн сайд /С.Амарсайхан/, Монгол Улсын Ерөнхий прокурор /Б.Жаргалсайхан/, Шүүхийн ерөнхий зөвлөл /П.Золзаяа/-д тус тус даалгасугай.

8.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу арван зургаан насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах ажиллагааг явуулахад шаардагдах дуу-дүрсний бичлэг хийх зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэх, шинэчлэх асуудлыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

9.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт заасан эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийн ажиллах журмыг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор баталж, хэрэгжүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Т.Аубакир/-д даалгасугай.

10.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг тогтоох, хөрөнгөтэй холбоотой болон бусад гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хуульч, өмгөөлөгчийг мэргэшүүлэн сургах, хууль тогтоомжийг сурталчлах зэрэг арга хэмжээ авахыг Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч /М.Мөнхбат/, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч /Л.Данзанноров/-т зөвлөсүгэй.

11.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

12.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” Санал гаргасан ХЗБХ. Санал хураалт. 98 гишүүнээс 52 буюу 53 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Бас анхаарах, засах заалтууд байгаа юм шиг байна шүү. Тийм, ЗГ-т л даалгах ёстой. Сангийн сайд, Хууль зүйн сайд, Аубакир сайд гээд тодорхойлж, даалгахгүй. Тэр ШЕЗ-д бас даалгаж байгаа чинь зөв үү, тэрийгээ эргэж хараарай.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн дахин санал хураалгаж, дэмжсэн санал:

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “3 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8.6 дугаар зүйл:

8.6 дугаар зүйл.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1.Шүүх энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

2.Өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан бол энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоох хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авна.

3.Өсвөр насны хүнд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хүүхдийн

эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага хамтран хэрэгжүүлэх талаар шүүхийн шийдвэрт тусгана.

4.Өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааны 50 хувь өнгөрсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол цаашид хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй талаарх прокурорын дүгнэлтийг үндэслэн хугацаанаас өмнө эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

5.Өсвөр насны хүн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

6.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

7.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд өсвөр насны хүн санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

8.Шүүх прокурорын дүгнэлтийг үндэслэн өсвөр насны хүнд шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан хугацаанд хүлээлгэсэн энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтыг өөрчилж болно.

2/8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтаас гадна дараах үүрэг, хязгаарлалтыг хүлээлгэнэ:

2.1.өсвөр насны хүнд болон түүний гэр бүлд сэтгэл зүйчээс зөвлөгөө, эмчилгээ авахыг даалгах;

2.2.нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд хамруулах;

2.3.хичээлийн ирцээ тогтмол хүргүүлэхийг даалгах;

2.4.хохирогчоос уучлал хүсэхийг даалгах;

2.5.шөнийн цагаар гэртээ байхыг даалгах;

2.6.өсвөр насны хүнийг хүмүүжүүлэхэд шаардлагатай бусад. Санал гаргасан ХЗБХ. Санал хураалт. 98-аас 53 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг болон хамт өргөн

мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүллээ.

18.32 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Дагасан хуулиудаа санал хураалт явна. 44 тийм ээ. Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтдаа, санал хураалт явуулъя гишүүд анхааралтай. Байнгын хорооноос Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 98 гишүүн оролцсоноос 50 гишүүн буюу 51 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хүүхэд хамгааллын тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

18.33 цаг

Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя. Байнгын хорооноос Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 93-аас 53, 98-аас 53 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Цагдаагийн албан тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүллээ.

18.34 цаг

Хүний эрхийг хангах багц хуулийн төсөл дээр нэмэлт, өөрчлөлт дээр нэг санал байгаа. Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.5.10 дахь заалтыг хэвээр үлдээх. Санал гаргасан ХЗБХ. Санал хураалт. Санал хураалтад 98 гишүүн орсноос 56 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүллээ.

18.36 цаг

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. Байнгын хорооны саналаар ““Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 98-аас 51 буюу 52 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа. УИХ-ын гишүүдэд талархлаа илэрхийлье.

18.38 цаг

2 намын бүлгийн дарга нар уулзаад, ойлголцох нь зөв байх. Одоо завсарлага дуусгаад яах вэ. Ярилцаад, тэгээд асуудлаа шийдье.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Чуулганы хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА